

С
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 10.1 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2023.10.23

Дугаарыг эрхлэн гаргасан: Доктор (Ph.D) Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2023 №3 (36)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгосүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор Бө.Бат-Эрдэнэ

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) Б.Баянмөнх

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 99878219
мэйл хаяг: b.bayadaa2007@gmail.com

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2023 №3)

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ү.Хосбаяр Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоо.....	4
Н.Эрболд Кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлын талаар.....	10
Л.Түвшинжаргал Цагдаагийн алба хаагчдаас үйлдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлын талаар.....	15

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

В.Амарсанаа Пирамид тогтолцооны аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргийн нийгмийн аюулын шинж.....	19
Г.Болор-Эрдэнэ Урьдчилан сэргийлэх ажил ба өсвөр насны хүүхдээс үйлдэж байгаа гэмт хэрэг.....	28
Б.Баярболд Монгол Улсад авлигын гэмт хэрэг үйлдэгдэх зарим шалтгаан нөхцөл, үр дагавар.....	32

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Цогтбаатар Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт явдалд хийсэн түүх-эрх зүйн дүн шинжилгээ, тулгамдаж буй асуудал.....	39
Х.Буянтүмэн Бие даасан, хараат бус байдлыг мөрдөгчийн ажлын мөн чанараар тодорхойлох нь.....	47
Б.Батзаяа Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас ялгах, хэрэгцээ, шаардлага.....	57
Г.Саранхүү Гэмт хэргийн дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.....	65

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

П.Эрдэнэбаатар Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онол, эрх зүйн үндсэн асуудал.....	75
Н.Ууганбаяр. Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй мал хулгайлах гэмт хэрэгт матрицын аргаар хийсэн дүн шинжилгээ, хүрсэн үр дүн.....	82

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Чинтамир Монгол Улсад зохион байгуулагдаж буй жагсаал, цуглааны явц өрнөлийг шинжихүй нь	87
---	----

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Баянмөнх Хүүхэд зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал.....	94
С.Эрдэнэбаяр Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гадаадын зарим орны туршлагыг нэвтрүүлэх нь.....	101

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО
ENSURING SECURITY OF PRIVATE NATIONAL
OBJECTS OPERATING SYSTEM

Ү.Хосбаяр

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн гүйцэтгэх
ажлын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

цагдаагийн хурандаа

U. Hosbayar

University of Internal Affairs, Head of the Criminal
intelligence Department of the Police school,
Doctor (Ph.D), police colonel

Товч агуулга: Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй хүчин зүйлс, тэдгээрийн эх сурвалж, шинж чанараар судлан шинжлэх нь аюулгүй байдлыг хангах арга, замыг тодорхойлох, учирч болох аюул, занал, сорил, эрсдэлээс хамгаалагдах баталгаатай нөхцөлийг бүрдүүлнэ. Иймд энэхүү илтгэлээр улсын онц чухал объектын байдлыг хангах ажиллагааны тогтолцоо, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг онолын үүднээс тодорхойлохыг зорьсон.

Abstract. Analyzing the factors, their sources and characteristics that may have a negative impact on the implementation of the goal of ensuring the safety of extremely important state objects, will determine the methods and ways to ensure safety, and create guaranteed conditions for protection from possible threats, threats, challenges, and risks. Therefore, this report aims to theoretically define the operational system for ensuring the condition of the state's most important objects and the factors affecting it.

Түлхүүр үг: Аюул занал, аюулгүй байдал, эрсдэл, улсын онц чухал объект, нөлөөлөх хүчин зүйл, баталгаа, сорил, эрсдэл.

Key words: Threats, security, risks, important state objects, influencing factors, guarantees, challenges, risks.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж, хэрэгжих боломжийг багасгаж болзошгүй хүчин зүйлсийн талаар тэдгээрийн эх сурвалж, шинж чанараар судлан шинжлэх нь аюулгүй байдлыг хангах арга, замыг тодорхойлох, учирч болох аюул, занал, сорил, эрсдэлээс хамгаалах баталгаатай нөхцөл бий болгохыг шаарддаг.

Тийнхүү нүүрлэж буй аюул, заналын хор хөнөөлөөс хамгаалах, няцаах үйл ажиллагааны нэгдлийг бий болгох нь аюулгүй байдал судлалын үр дүнгийн илэрхийлэл болдог.

Улсын онц чухал объектын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс, түүнээс үүдэлтэй аюул, занал бодитойгоор оршин тогтнож байгаа нөхцөлд аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бий болгож, түүнийг хэрэгжүүлэх бүтэц, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйн хэрэг юм.

Аюулгүй байдлыг хангах ажиллагааны зорилго нь “түүхэн буюу цаг хугацааны тодорхой нөхцөлд язгуур ашиг сонирхлыг гадаад ба дотоод болзошгүй аюулаас хамгаалж, түүнийг аюулгүй байдлаа хангаж буй объектын хөгжил, дэвшил, хэвийн ажиллагааны үндсэн нөхцөл болгоход оршино”¹ хэмээх судлаачийн тодорхойлолт байдаг.

¹ Карпов.В.И, Павлов.Д.Б. Основы теории обеспечения безопасности личности, общества, и государства. М., 2000.с.44.

Энэхүү зорилтын гол агуулга нь түүнд хүрэхийн тулд нэг үйлдэл, үйл ажиллагаагаар үр дүн хангагдахгүй бөгөөд харилцан бие биеэ нөхөж чадах цогц, бие даасан үйл ажиллагаагаар дамжин хэрэгжих зүй тогтолтой.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэл тус бүр өөр өөрийн гэсэн зорилготой байж болох ч эцсийн үр дүнгийн төлөөх зорилго нэгдмэл агуулгатай байна. Аюулгүй байдлыг хангах ажиллагааны үндсэн зорилт нь учирч болох аюулыг илрүүлж, үнэлэх, улмаар түүний бодитойгоор оршин байгаа аюулыг эрсдэл, заналхийлэлгүй болгон өөрчлөн хувиргах явдал байдаг.

Эндээс авч үзвэл улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тодорхой дэс дараалал бүхий үе шатыг дамжин хэрэгжих боломжтой гэсэн дүгнэлт гарч байна. Судлаачдын зүгээс ч аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэг талаас үйл ажиллагааны цогц нэгдэл, түүнийг хэрэгжүүлэгч субъектын мөн чанар талаас авч үзэхийн өмнө үйл ажиллагааны үе шаттай байдлаар судалсан байдаг. Зарим судлаач аюулгүй байдлыг хангах ажиллагааны үе шатыг аюулыг илрүүлэх, өөрчлөх гэсэн үндсэн хоёр төрөлд хувааж үзсэн бол нөгөө нэг нь тухайн объектод нүүрлэж болох аюул, заналыг илрүүлж, үнэлэх, тэдгээрийн орон зай, цаг хугацааны өрнөлд дүн шинжилгээ хийж, шийдвэрийн санал боловсруулах, аюулыг зайлуулах, аюулыг саармагжуулах, тасалдуулах, тусгаарлах, арилгах, устгах гэж илүү дэлгэрэнгүй тодорхойлж өгчээ.²

Судлаачдын дүгнэлтийг харьцуулж үзвэл аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь юуны түрүүнд аюул, заналыг илрүүлэн судлан шинжлэх, үнэлэх, улмаар түүний хор аюулыг арилгах, бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн чиглэлд санаа нэгдсэн хэдий ч хоёр дахь тодорхойлолт илүү нарийвчлалтай үе шатанд хувааж авч үзсэн нь аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны үндсийг бий болгоход чухлаар нөлөөлнө.

Иймд улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны үе шатыг мөн адил дээр дурдсан хэлбэрт нийцүүлэхийн зэрэгцээ тухайн объектын онцлогийг харгалзан хэрэгжүүлэх нь зүйтэй. Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны үе шатыг дараах дэс дарааллаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Аюулыг илрүүлэх, учирч болох аюул, занал, сорил, эрсдэлийг эх сурвалж, шинж чанараар нь бүлэглэн ангилж судлах.
2. Аюулыг үнэлэх, орон зай, цаг хугацааны хувьд дүн шинжилгээ хийх.
3. Аюулыг зайлуулах, саармагжуулах, арилгах.
4. Аюулгүй байдлыг хангах шийдвэр, төлөвлөлтийн санал боловсруулах.
5. Хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавих гэж тодорхойлж байна.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог агуулга, мөн чанарын хувьд түүнийг бүрдүүлэгч бүтэц талаас нь авч үзэхээс гадна өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой, нэгдмэл, харилцан нөлөөлөл бүхий үйл ажиллагааны нэгдэл талаас нь тодорхойлох шаардлагатай гэж үзсэн.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах бүтэц нь аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч субъект буюу удирдлагын болон гүйцэтгэх, хянах, хамгаалах, судлан шинжлэх чиг үүрэг бүхий бүрдлээс тогтоно.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах субъект гэж аюулаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, аюулын үйл явцыг таслан зогсоох, нэгэнт үүссэн аюул, заналын хор уршгийг бууруулах, арилгах чиглэлээр тодорхой шийдвэр гарган хэрэгжүүлж буй этгээд, түүний нэгдлийг хэлнэ.

Энэ субъект нь нэг талаас мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж буй шууд удирдах удирдлагын чиг үүрэг бүхий албан тушаалтан байхаас гадна аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг арилгах нөхцөлийг бий болгох эрх хэмжээ бүхий, аюулгүй байдлыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж буй байгууллага, албан тушаалтан байж болно.

² Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 87-88 дахь тал.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангахад шууд бусаар оролцож буй ийм төрлийн субъектэд төрийн эрх барих буюу хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглалын байгууллага, тодорхой хүрээнд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад хамтран ажиллаж буй бусад хууль сахиулах, гамшгаас хамгаалах байгууллагууд багтана.

Хууль тогтоох байгууллага нь улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг бий болгох, аюулгүй байдлыг хангахад оролцож буй төрийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтын журмыг тогтоох, аюулгүй байдлыг хангах төсвийг батлах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг бол гүйцэтгэх засаглалын, төрийн захиргааны төв байгууллага нь хууль тогтоомжийн гүйцэтгэлийг хангах, хяналт тавих, салбарын хэмжээний бодлого боловсруулах, улс орны хэмжээний нэгдсэн, цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, хуульд нийцүүлэн аюулгүй байдлыг хангах байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг эрх хэмжээтэй оролцоно.

Харин улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд шууд хяналт тавьж мэргэжлийн удирдлагаар хангах субъект нь улсын онц чухал объектын аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг судлан шинжлэх, түүнээс үүсэх аюул, занал, сорил, эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, аюулгүй байдлыг хангах байгууллагын бодлого, түүн дотор хүний нөөцийн бодлогыг боловсруулна.

Түүнээс гадна аюулгүй байдлыг хангах ажиллагааны явц, үр дүнд хяналт тавьж нөхцөл байдалд нэгдсэн дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын ажилтны хөгжил, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгуулах, аюулгүй байдлын төсвийн хангамж, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, техник хэрэгсэл, орчныг бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Аюулгүй байдлын үүднээс судлаачид аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог нэгдүгээрт, түүнийг бүрдүүлэгч дэд систем буюу бүтцийн талаас, хоёрдугаарт, тэдгээр бүтцийг зүгээс хэрэгжүүлж буй харилцан ажиллагаагаар тодорхойлсон байна.³

Энд аюулгүй байдлын бүтэц нь хэдийгээр тус тусын онцлог шинж, учирч болох аюул заналхийлэл зэргээрээ харилцан адилгүй боловч бүрдэл хэсэг бүр дараах асуудлыг нийтлэг байдлаар агуулж байдаг. Үүнд:

- ✓ Аюулгүй байдлыг хангах тогтолцооны субъект, объектууд.
- ✓ Аюулгүй байдлын үзэл баримтлал, зорилго, зорилт, зарчмуудыг авч үзэх ба энэ нь нийгмийн бүхий л салбарт нэгэн адил хамаарна.
- ✓ Аюулгүй байдлын чиглэл тус бүрийн болон хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ.
- ✓ Аюулгүй байдлаа хангах зорилт бүхий субъект, объектын ашиг сонирхол.
- ✓ Аюул заналын талаарх мэдээлэл, ойлголт.
- ✓ Аюулгүй байдлыг хангах ажиллагааны арга, хэлбэр, явц, үр дүн зэрэг болно.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэл нь чухам ямар объектыг аюул, занал, сорил, эрсдэлээс хамгаалах гэж байгаагаар дараах үндсэн дэд хэсгүүдэд хуваагдана. Үүнд:

1. Улсын онц чухал объектыг хамгаалж буй албан хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа.
2. Улсын онц чухал объектод ажиллагсадын аюулгүй байдлыг хангах ажиллагаа.
3. Байгууллагын барилга, байгууламж, төхөөрөмжлөл, дэд бүтэц буюу объектын аюулгүй байдлыг хангах.
4. Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах гэсэн дөрвөн үндсэн чиглэлд хуваан авч үзнэ.

Эдгээрээс гадна өнөөгийн нийгэм, улс төрийн нөхцөл, байдал, технологийн хөгжил, орчны өөрчлөлт зэргээс хамааран дээрх дөрвөн үндсэн чиглэл тус бүрд хамаарч, зүй тогтлын хувьд зайлшгүй хамт хэрэгжиж, улсын онц чухал объектын аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсээс хамгаалах нэмэлт чиглэлүүд байна.

³ Ч.Улаанхүү. Дурдсан бүтээл. 79 дэх тал.

Үүнд, байгууллагын аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэргийг дурдаж болно.

Дээрх дүгнэлтээс авч үзвэл улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны дэд хэсгүүдийг аюулаас хамгаалагдах шаардлагатай объектын төрлөөр нь дөрөв хувааж авч үзсэн боловч эдгээр аюулгүй байдлыг хангах чиглэл тус бүрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны арга, хэлбэр, онцлог зэргийг тусгайлан төрөлжүүлэх шаардлагагүй бөгөөд аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог нэгдсэн байдлаар тодорхойлно.

Өөрөөр хэлбэл улсын онц чухал объектын аюулгүй байдлын үндсэн чиглэлүүд нь хамгаалагдаж буй объектын онцлог шинж, нүүрлэж буй аюул, заналхийллийн төвшнөөр ялгагдах боловч аюулгүй байдлын ухагдахуун, шаардлага, аюул, заналхийллийг үнэлэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний цар хүрээ, хугацаа, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, тогтолцоо зэргийн хувьд нэг нь нөгөөгөөсөө ялгагдах боломжгүй, адил түвшинд хэрэгжих зүй тогтолтой байдаг.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог дээр дурдсан үндсэн чиглэлүүд, үе шатанд хуваан үзэхээс гадна түүний чиг үүргийг дарааллын хувьд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нийцүүлэн дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Улсын онц чухал объектын аюулгүй байдалд нөлөөлөх аюулын шинж чанар, чиглэлээс шалтгаалан язгуур ашиг сонирхлоо хамгаалах стратеги зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох.

- Улсын онц чухал объектын язгуур ашиг сонирхолд учирч буй аюул, аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөг илрүүлэх, үнэлэх, урьдчилан дүгнэх.

- Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх.

- Аюулгүй байдлын хангах ажиллагааны тогтолцоон дахь хүч, хэрэгслийг боловсронгуй болгох зэрэг болно. Энэхүү чиг үүргийн дараалал нь Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэл тус бүрд нэгэн адил хамаарна.

Судлаачид “Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоо”-г аюулгүй байдлын орчин бүрдүүлэх, хямралт болон тайван үед аюулгүй байдлыг хангах ажиллагаа, аюулгүй байдлыг удирдах гэсэн хэсгүүдэд хуваан авч үзжээ.⁴

Харин аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны талаар бусад судлаачид үзэхдээ “...зориудаар байгуулагдсан харилцан ажиллагч субъектын нэгдэл, хуулиар баталгаажсан үзэл баримтлал, номлолууд, нийгмийн сэтгэлгээний төлөвийг баталгаажуулах хүч, хэрэгсэл, аюул, заналыг хаагдуулах замаар найдвартай оршин тогтнох, тогтвортой хөгжих бүтэц, институци”⁵, “аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцож буй хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх засаглал, олон нийт, иргэн, аюулгүй байдлыг хангах салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгийн нэгдмэл цогцыг хэлнэ”⁶ гэж тодорхойлжээ.

Судлаачдын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны талаарх санал, дүгнэлт нь өргөн хүрээтэй тодорхойлогдсон байгаа нь аюулгүй байдлыг хангах тогтолцоог Үндэсний аюулгүй байдлын түвшинд авч үзсэнтэй холбоотой. Гэвч аюулгүй байдлыг хангах тогтолцооны үндсэн шинж, бүрдлийн талаар судлаачдын байр суурь нэг байна.

Судлаачдын дүгнэлт, аюулгүй байдлын онолын ухагдахуунуудыг шинжилж үзвэл аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоо нь дараах хэсгүүдээс бүрдэж байна. Үүнд:

- Аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий субъектүүдийн нэгдэл.

⁴ Д.Адъяабазар. Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад шинэ хандлага чухал. Сүлд-Инфо. УБ., 2015. №01. 41 дэх тал.

⁵ Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 81 дэх тал.

⁶ Ж.Бор. В.Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ., 2012. 170 дахь тал.

- Аюулгүй байдлын тогтолцоонд хамаарах, аюулгүй байдлын объектын шинжээр ялгагдах бие даасан чиглэлүүд.

- Тодорхой үе шатыг дамжин хэрэгжих, аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог бий болгох зүй тогтол бүхий арга хэмжээний нэгдэл зэрэг болно.

Эндээс сүүлийн чиглэлийг гол үндэс болгон Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоо гэдэг нь “Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бүх шатны байгууллага, албан хаагч, бусад субъектээс заавал хэрэгжүүлэх шинжийг агуулсан аюул, занал, сорил, эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, хор уршгийг арилгах, таслан зогсооход чиглэсэн, онцлог шинж бүхий арга хэмжээний нэгдэл юм” гэж тодорхойлж байна.

Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааг тодорхой дэс дараалал, харилцан бие биетэй зохицолдсон, нягт уялдаа холбоо бүхий цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэхүү аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээг зохион байгуулахдаа дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

1) Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтоо тодорхойлж, түүнд нийцсэн үйл ажиллагаа явуулах.

2) Аюулгүй байдалд хор уршиг учруулж болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тэргүүлэх шинж чанартай хэрэгжүүлэх.

3) Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах бүхий л цогц арга хэмжээ шуурхай, тасралтгүй шинж чанартай байх.

4) Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, инженер техникийн хэрэгслийг ашиглах, бусад үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх.

5) Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны хүрээнд явагдаж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хүч хэрэгслүүд нь хоорондоо нягт уялдаа холбоотой байх.

Дүгнэлт

1. Аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн цэрэг, батлан хамгаалахын хүрээнд тодорхойлдог байсан уламжлалт хандлага өөрчлөгдөж, улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарыг хамарч, аюулгүй байдлыг хангах бодлого, чиглэл боловсронгуй болсоор байгаа өнөөгийн нөхцөлд улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах асуудал нь бие даасан салбар судлал байх нь зүйн хэрэг гэж үзлээ.

2. Эдийн засаг, улс төр, нийгмийн харилцаа хурдтай хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед улсын онц чухал объектын хэвийн үйл ажиллагааг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон дотоод аюулгүй байдалтай салшгүй холбоотой бөгөөд улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны онол, арга зүйн асуудлыг гүнзгийрүүлэн судлах бодит шаардлага байсаар байна.

3. Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь нийгэм, төрийн байгууллын хөгжил, төрийн албаны тогтвортой байдал, төрийн эрх барих байгууллага буюу хууль тогтоох байгууллагын төлөвшил, эрх зүйг бүтээх, улс орны хууль сахиулах бодлогыг тодорхойлогч хэсгийн нэгдмэл байдал, улс орны эдийн засгийн чадавх зэрэг дотоод аюулгүй байдлыг бүрдүүлэгч үндсэн элементүүдээс хамаарах зүй тогтолтой. Эдгээр нь улс төрийн нөхцөл байдлаас шууд хамааран нөхцөлдөж байдаг учир улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоонд нөлөөлөх гадаад хүчин зүйлсэд улс төрийн нөхцөл байдлыг хамааруулан авч үзнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Б.Батбаяр. Аюулгүй байдлын шинэ орчин, Монголын үүрэг оролцоо. Стратеги судалгаа 20 жилд. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2011.
2. Ч.Улаанхүү. Аюулгүй байдал. УБ., 2009.
3. Ч.Найдансүрэн Д.Содномгомбо. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах зарим асуудал. УБ., 2000.
4. Ж.Энхбаяр. Аюулгүй байдлын олон талт асуудал. УБ., 2007.
5. Ж.Бор. В.Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ., 2012.
6. Д.Адъяабазар. Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрсдэл бүхий зарим асуудал. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014.
7. Н.Наранчимэг нар. Хүний аюулгүй байдал. УБ., 2009.
8. Карпов.В.И, Павлов.Д.Б. Основы теории обеспечения безопасности личности, общества, и государства. М., 2000.
9. Арилдий.Х. Мэдээллийн аюулгүй байдал-системийн шинжилгээ. Дотоод аюулгүй байдал сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Үндэсний тагнуулын академи. УБ., 2011.
10. Батзориг.Б. Монголын криминологийн өнөөгийн байдал, чиг хандлага. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага. Эмхэтгэл 2. УБ., 2013.

**КИБЕР ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГИЙН
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР**
CRIMES COMMITTED IN THE CYBER ENVIRONMENT
ABOUT THE SITUATION

Н.Эрболд

Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй
тэмцэх хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч,
цагдаагийн ахмад
N. Erbold
Chief Criminal Investigator of the Cybercrime Division,
Criminal Police Department
Police Captain,

Хураангуй: Монгол Улсын иргэдийн интернет хэрэглэгчдийн тоо 2,9 саяд хүрсэн байна. Үүнээс фэйсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2,4 саяд хүрчээ. Үүнээс гар утсаараа нийгмийн сүлжээнд 2,2 сая орчим иргэн хандаж байгаа нь улсын нийт хүн амтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Энэ цахим хэрэглээг дагаж бусдын нэр хүндийг санаатайгаар, үндэслэлгүй гутаан доромжлох, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, залилах, худал мэдээлэл тараах, хууль бус жагсаал, цуглаанд уриалах зэрэг бусад уламжлалт гэмт хэргүүд кибер орчинд үйлдэгдэх болсон байна. Судалгаагаар энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчны талаар судаллаа.

Abstract: The number of Internet users in Mongolia has reached 2.9 million. Of this, the number of active Facebook users reached 2.4 million. Out of this, about 2.2 million citizens use their mobile phones to access social networks, which is a high figure compared to the total population of the country. Following this electronic use, other traditional crimes such as deliberately and unjustifiably defaming others, misleading and deceiving users, spreading false information, and calling for illegal demonstrations and gatherings have been committed in the cyber environment. Through the research, the situation of this type of crime, its future trends, and the legal framework for combating crime were studied.

Түлхүүр үг: Кибер орон зай, кибер аюулгүй байдал, кибер орон зайд үйлдэгдэж буй гэмт хэрэг.

Key word: Cyberspace, cyber security, crimes committed in cyberspace.

Дэлхийн улс орнууд кибер хүчин чадавхаа нэмэгдүүлэхэд тууштай анхаарч, улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд цахим зөрчил, сөргөлдөөн эрчимтэй нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд кибер орон зайн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх болсон.

Цар тахлын улмаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэд өөрсдийн бизнес, өдөр тутмын үйл ажиллагааг компьютерын сүлжээгээр дамжуулан явуулж хэвшээд байна. Энэ нь олон талын давуу талтай ч нөгөө талаар кибер аюулгүй байдлын асуудалд анхаарал хандуулах цаг болсныг илтгэж байна.

“Кибер орон зай”⁷ бидэнд аюулгүй байдлаа хамгаалах шаардлага тавьж байгаа ч улс үндэстнээ хөгжүүлэх шинэ гарц нээн өгч, шинэ сорилт, шинэ боломж олгож байна. Энэхүү орон зайгаар дамжуулан аль ч орны эдийн засаг, нийгэм, улс төрийн аюулгүй байдалд халдаж, ноцтой аюул учруулж болох учир дэлхийн улс орнууд аюулгүй байдлын ямар арга хэмжээ авах талаар идэвхтэй ажилласаар байна.

⁷ Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.2. "Кибер орон зай" гэж интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар.

Гэвч Кибер орон зайн аюулгүй байдлын тухай олон улсын түвшинд бүх орон хүлээн зөвшөөрсөн эрх зүйн баримт бичиг байхгүй, нийгмийн харилцаа, бидний аж байдалд технологийн дэвшил, түүний нөлөө эрчимтэй нэвтэрч, улам бүр дижитал орчинд шилжиж байна.


Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлж буй. Энэхүү ажлын хүрээнд Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн алба хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ⁸ гэж зорилт тавьсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д Цагдаагийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх төрөлжсөн болон үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мөрдөх, гүйцэтгэх ажил явуулах албатай байна⁹ гэж хуульчилж өгсөн.

Олон улсын мэргэжлийн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтээр Монгол улс нь кибер орон зайгаа аливаа халдлагаас хамгаалах, хариу арга хэмжээ авах чадамжгүй, хамгийн их кибер халдлагад өртдөг 5 орны нэг болсон байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018-2023 онд 179,373 гэмт хэрэг бүртгэгдсэний 23621 буюу 13,1% нь цахим орчинд үйлдэгдсэн байна. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн он тус бүрээр нь харуулбал, 2018 онд 659, 2019 онд 737, 2020 онд 1795, 2021 онд 4825, 2022 онд 8563, 2023 оны 9 сарын байдлаар 7042 бүртгэгдсэн байна.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн статистик судалгааг графикаар харуулбал:



Дээрх графикаас үзвэл, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2018 онд нийт гэмт хэргийн 1,8 хувийг эзэлж байсан бол 2023 оны эхний 09 сарын байдлаар 25,3 хувийг дангаар эзэлж байна.


Кибер орчинд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 85 хувийг “Залилах” гэмт хэрэг эзэлж байгаагаас интернэт банк, цахим төлбөр тооцооны хэрэгслийг ашиглаж, онлайн худалдаа, наймаа, зээл, урьдчилгаа төлбөр авах зэргээр залилах, мөн фейсбүүк хаягт хууль бусаар нэвтэрч түүгээр дамжуулан бусдыг залилах гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

⁸ “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

⁹ Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дэх хэсэг


Мөн улсын хэмжээнд 2040 он хүртэл бүртгэгдэх цахимаар залилах гэмт хэргийн төлвийг систем динамикийн тооцооллоор гаргахад 2022-2029 онд цахимаар залилах гэмт хэрэг тасралтгүй өсч, 2030 онд өсөлтийнхөө хамгийн оргил хэсэгт хүрч 16535 залилах гэмт хэрэг бүртгэгдэн, цаашид буурах зүй зүй тогтолтой байна.

Гэмт хэргийн ирээдүйн статистик судалгааг графикаар харуулбал:



Дээрх графикаас үзэхэд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2030 он хүртэл жил бүр 1-2 дахин өсөх хандлагатай байна.

Сүүлийн 5 жилд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн тоон судалгааг кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгтэй харьцуулахад дараах үзүүлэлт гарч байна.



Дээрх графикаас харвал хар тамхи, мансууруулах бодистой холбоотой болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг нь кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргээс дунджаар 20-30 дахин бага бүртгэгдсэн байна.

Прокурорын байгууллагаас энэ төрлийн гэмт хэрэгт явуулж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг шийдвэрлэгдэхгүй удааширч байгаа шалтгааныг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нэр, хаяг тодорхойгүй, дийлэнх нь хуурамч хаягаас хандалт хийдэг, иргэдийг төөрөгдөлд оруулах замаар олон тооны иргэдийг залилдаг, хил хязгааргүй үйлдэгддэг, олон тооны хохирогч, гэрчүүдийг олж тогтоох, мэдүүлэг авах, холбогдох газруудад албан бичиг хүргүүлэх, хариу лавлагаа авах зэрэг

мөрдөн шалгах ажиллагаа явуулах, илрүүлэхэд тодорхой хэмжээний ур чадвар дутагдаж байгаагаас хамаарч байна гэж дүгнэжээ¹⁰.

Монгол Улсын Их Хурлаас цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг батлан 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, ирээдүйд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнд бэлэн байх шаардлага тулгараад байна.

Дээрх хуулиудад шинээр мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ, биометрик мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл, тоон гарын үсэг, түүний нийтийн болон хувийн түлхүүр, цахим баримт бичиг гэх зэрэг шинэ ойлголт, боломжууд бий болж гэмт этгээдүүд түүнийг хууль бус үйлдэлдээ ашиглах нь цаг хугацааны асуудал болоод байна.

Иймд цахим шилжилттэй холбоотой ирээдүйд учирч болох эрсдэлд хүчин зүйлүүдийг тооцож, Засгийн Газрын бодлого, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах ажилд онцгойлон анхаарч ажиллах хэрэгцээ шаардлага байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд цагдаагийн байгууллага нь цахим халдлага, зөрчилтэй тэмцэх, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор тоон шинжилгээний лабораторийг байгуулан ажиллуулна¹¹ гэж заасныг хэрэгжүүлж, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст тоон ул мөр илрүүлэх лабораторийг байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Дүгнэлт

1. Гадаад, дотоодын кибер гэмт хэрэг үйлдэгчдийн арга, заль мэх тогтмол шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа энэ цаг үед цагдаа, прокурорын байгууллагын үйл ажиллагаа түүнийг гүйцэж, тэмцэж чадахгүй нөхцөл байдалд хүрч төр засаг, хууль цаазад итгэх иргэдийн итгэлийг сулруулж байна.

2. Кибер гэмт хэрэг нь данснаас мөнгө хулгайлах, залилах, заналхийлэх, амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, худал мэдээлэл тараах, мөнгө угаах, хар тамхи зэрэг бусад төрлийн гэмт хэргүүдтэй давхар зүйлчлэгддэг онцлогтой. Энэ нь дан ганц Кибер гэмт хэрэгтэй тэмцэхээс илүүтэй бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагыг бий болгодог бөгөөд сонгодог кибер гэмт хэргээр эхэлж, бусад төрлийн гэмт хэргээр төгсдөг буюу давхар зүйлчлэгддэг гэмт хэргийн тоо, төрөл жил бүр өссөхөөр байна.

3. Кибер орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн 30 хувийг бусдын фейсбүүк хаяг, банкны данс руу хууль бусаар нэвтэрч залилах гэмт хэрэг эзэлж байна. Энэ төрлийн залилах гэмт хэрэг нь бусдын цахим хаяг руу хууль бусаар нэвтэрсэн эсхүл нэвтрээгүй гэдгээрээ ялгарч кибер гэмт хэрэг мөн эсэхийг тогтоодог онцлогтой байна. Гэтэл Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл (Залилах)-д цахим сүлжээ ашигласан гэж хуульчилсан боловч мэдээллийн систем, сүлжээнд хууль бусаар нэвтэрч залилах хэлбэрийг хуульчилж өгөөгүй байгаа нь учир дутагдалтай байна.

4. Харилцаа холбооны тухай хуульд гадаад улсад сервертэй веб сайт, олон нийтийн сүлжээ, платформуос хэрэглэгчийн мэдээллийг хууль, хяналтын байгууллага саадгүй гаргуулан авдаг, хязгаарладаг, устгадаг, саармагжуулдаг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн.

5. Иргэдийн кибер аюулгүй байдал, цахим хэрэглээний боловсрол, цахим орчин дахь тодорхой төрлийн аюул занал, гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээлэл дугмаг, аюулгүй байдлын дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлдэггүй, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад байгууллага аж ахуй нэгжүүд төсөв, хөрөнгө зарцуулахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт өртөх үндсэн шалтгаан болж байна.

6. Кибер аюулгүй байдлын тухай хуульд цагдаагийн байгууллага нь кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор тоон шинжилгээний лабораторийг байгуулан ажиллуулна гэж заасныг

¹⁰ Улсын Ерөний Прокурорын газар “Цахим гэмт хэргийн судалгаа-2022” танилцуулга.

¹¹ Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсэгт

хэрэгжүүлж, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст тоон ул мөр илрүүлэх лаборатори байгуулах шаардлагатай.

7. Кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт нь урьдчилан сэргийлэх ажил, түүнтэй тэмцэж буй алба хаагчдын мэдлэг, ур чадвар, иргэд олон нийтийн цахим орчны боловсролтой урвуу хамааралтай байдаг тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг сурган мэргэшүүлэх нэгжийг байгуулан тухайн чиглэлд ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэн ажиллуулах зайлшгүй шаардлагатай. Ингэснээр кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон тоон ул мөр, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх ажил чанаржиж кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг хөтөлбөргүй нотлох, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай зохион байгуулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх болон энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарна гэж тус тус дүгнэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Кибер аюулгүй байдлын тухай хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
4. Улсын Ерөний Прокурорын газар “Цахим гэмт хэргийн судалгаа-2021 он” танилцуулга.
5. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДААС ҮЙЛДЭЖ БУЙ
ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР**
SITUATIONS OF CRIMES COMMITTED BY POLICE PERSONNEL

Л.Түвшинжаргал
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн хошууч
Police major L.Tuvshinjargal

Хураангуй: Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдаас гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт өгч цаашид анхаарах асуудлыг тодорхойлон удирдлага зохион байгуулалтын талаар санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Abstract: The thesis is intended to assess the current situation in which police officers and internal troops units are being investigated for crimes, and to identify the issues to be considered in the future and provide suggestions for management and organization.

Түлхүүр үг: Цагдаа, дотоодын цэрэг, гэмт хэрэг, зөрчил

Keywords: police, internal troops, crime, conflict

Иргэн, хуулийн этгээдээс энэ оны 3 дугаар улиралд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч холбогдсон гэмт хэргийн шинжтэй 365 гомдол мэдээллийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд хүлээн авч шалгах ажиллагаа явуулжээ. Үүнээс Авлигатай тэмцэх газар 230, Тагнуулын ерөнхий газар 2, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 133 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх бүртгэгдсэн 365 гомдол мэдээлэлд мөрдөн байцаалтын 11 хэрэг, хэрэг бүртгэлтийн 121 хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах 204, харьяаллын дагуу шилжүүлэх саналтай 11 гомдол, мэдээллийг прокурорын байгууллагад тус тус хүргүүлж шийдвэрлүүлэн, 18 гомдол, мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүртгэгдсэн гомдол мэдээллийг өмнө оны мөн үетэй харьцуулвал: ¹²

№	Гомдол, мэдээллийн тоо	2022 оны 3 улирал	224	141 нэгж буюу 61.3 хувиар өссөн
1		2023 оны 3 улирал	365	

Хүснэгт 1.

Үүнээс гадна Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдаас 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Авлигатай тэмцэх газарт энэ оны 105, өмнөх оны дугаартай үлдэгдэл 84 нийт 189 хэрэг, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст энэ оны 80, өмнөх оны 20 нийт 100, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтэст өмнөх оны үлдэгдэл 4 бүгд 293 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байгаагаас энэ оны дугаартай 185 хэрэг байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй дээрх хэргээс хэрэг бүртгэлийн хэргийг хаах саналтай 53, шүүхэд шилжүүлэх саналтай 58, нэгтгэсэн 13, харьяаллын дагуу шилжүүлэх саналтай 10, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай 3 хэргийг тус тус шийдвэрлэж одоо 92 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

¹² Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газрын 2022, 2023 оны тайлан

Бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд¹³:

№	Анги байгууллага	2022 /3 улирал/	2023 /3 улирал/	Өсөлт бууралт
1	МБА	30	100	70 нэгжээр буюу 30 хувиар өссөн
2	АТГ	173	189	16 нэгжээр буюу 15 хувиар өссөн
3	ТЕГ	2	4	2 нэгжээр буюу 50 хувиар буурсан
4	Нийт	205	293	87 нэгжээр буюу 69,9 хувиар өссөн

Хүснэгт 2.

Дээрх тоон үзүүлэлтээс үзвэл Улс орны аюулгүй байдал, Та бидний өдөр тутмын амгалан тайван амьдралын баталгааг хангаж, шударга ёсыг манах үүрэгтэй цагдаагийн байгууллага нь өөрсдөө шударгаар ажиллах баталгаа нь хаана байна?

Цагдаа ямар ч нөхцөлд хууль сахиx ёсыг даган биелүүлэх ёстой ба сахиулах ёстой тэр л хуулиндаа мөн захирагдаж байдаг. Улмаар цагдаагийн гол үүрэг нь эрүүгийн шүүн таслах тогтолцооны бусад байгууллагууд болох прокурор, шүүх, засан хүмүүжүүлэх нэгжээс ихээхэн ялгаатай¹⁴. Сайн засаглалын үүднээс авч үзвэл, бүх орон хувь хүний эрх чөлөөг хүндэлж, хүний эрхийг дээдлэхийн сацуу олон нийтийн аюулгүй байдлыг хангаж байх ёстой. Ардчилсан орны иргэд цагдаа бүгдэд шударга, тэгш, нөлөөллөөс ангид, тогтсон хэм хэмжээний дагуу үйлчилнэ гэсэн хүлээлттэй байдаг. Цагдаагаас иргэдэд хэрхэн хандаж байгаа байдал нь тухайн улсын ардчиллын чанарын гол үзүүлэлт болж байдаг юм.

Тиймээс цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг эрс буруутгах, зохисгүй үгээр хэлэх, албаны нэр төр, алба хаагчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үзэгдлүүд гарсаар байна.

Цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх засгийн нэгэн салбар бөгөөд нийгэмд хууль ёсны дагуу албан хүч хэрэглэх эрхтэй цорын ганц байгууллага гэхэд болно. Чухам энэ чадавхыг эзэмшдэг учир цагдаагийн байгууллага төрийн дарангуйлал, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, авилгатай холбоотой зорилгоор ашиглагдах эрсдэл өндөртэй байдаг. Тийм ч учир, ардчилсан орнуудад цагдаагийн алба нь улс төрчид, хүнд сурталтнууд, байгууллагын өөрийн ашиг сонирхлын төлөө бус харин нийгэм, олон нийтийн ашиг сонирхолд үйлчилж байгааг баталгаажуулах тусгайлсан арга хэмжээ авсан байдаг.

Цагдаагийн бүтэц нь онцгой эрхтэй бөгөөд үйл ажиллагааны хараат бус байдлаар хангагдсан байх ёстой хэдий ч хууль сахиулах ажиллагаандаа хөндлөнгийн нөлөөлөлд үл автаж, мэргэжлийн өндөр түвшинд ажиллах ёстой. Түүнчлэн цагдаагийн албан хаагчид албан болон албан бус мэргэжлийн ёс зүйн дүрмийг мэддэг, дагаж мөрддөг байх ёстой.

Цагдаагийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн нэг чухал хэсэг нь хүний амьд явах эрхийг хүндэтгэх, зөвхөн хуулинд заасан зорилгын хүрээнд, зайлшгүй шаардлагатай бөгөөд зөвшөөрөгдсөн хэмжээнд хүч хэрэглэх зарчим юм. Мөн цагдаагаас хүч хэрэглэх тохиолдолд пропорциональ зарчмыг байнга харгалзаж үзэх ёстой. Гадаад буюу улс төрийн болон шүүхийн хяналтаас гадна дотоод буюу албан хариуцлагын бүтэц зайлшгүй байх ёстой. Цагдаагийн байгууллага, албан хаагчаас гаргасан гэмт хэрэг, зөрчил, олон нийтийн зүгээс гаргасан гомдлыг хянан шалгах тогтолцоо мэргэжлийн цагдаагийн үйл ажиллагаанд мөн заавал байна.

Цагдаагийн байгууллагын бүтэцт алба хаагчаас үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, гүйцэтгэх ажлын шугамаар нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг шалгах үүрэг бүхий нэгж ажиллаж байгаа нь дотоод хяналт, аюулгүй байдлыг хангах байгууллагын үйл ажиллагааг тогтвортой явуулах, учирч болох эрсдлээс сэргийлсэн маш том алхам болсон.

¹³ Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газрын 2022, 2023 оны тайлан

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод аудитын тайлангын эмхтгэл 2022, УБ

¹⁴ Аюулгүй байдлын салбар дахь парламентийн хяналт гарын авлага №05 2005, Женев

4. Тагнуулын албадыг хянах нь гарын авлага 2002., Женев

Цагдаагийн байгууллагад тавих ардчилсан хяналтыг хүний эрхийн чиглэлээр олон нийтийн байгууллагууд зэрэг цагдаад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх албан бус, доороос дээшээ чиглэлтэй санаачлагуудын тусламжтайгаар сайжруулж болно. Түүнчлэн, иргэдийн гомдлыг хянан шийдвэрлэдэг омбудсмен зэрэг иргэний хяналтын байгууллагууд цагдаагийн хариуцлагыг өндөрсгөхөд тустай байдаг.

Зарим тохиолдолд иргэний нийгэм, орон нутгийн удирдлагын төлөөллийг багтаасан орон нутгийн аюулгүй байдлын зөвлөл, түүнтэй төстэй бүтэц нь орон нутгийн цагдаагийн үйл ажиллагааг чанаржуулахад сайнаар нөлөөлөх нь бий. Үүний зэрэгцээ хөндлөнгийн мэдээлэгчид болон энэ чиглэлээр хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудад цагдаа, тагнуулын албад, цэргийн хүчнээс дарамт, заналхийлэл үзүүлэхээс сэргийлсэн хууль тогтоомжийг баталсан байх шаардлагатай.

Алба хаагчдын зүгээс гэмт хэрэгт холбогдон шалгагдах нь тогтмол өсөж байгаа нь цагдаагийн байгууллагын нийгмийн баталгаатай холбон үзэж болох боловч алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, хууль эрх зүйн мэдлэг, харилцаа хандлага, ёс зүй, биеэ авч явах байдалтай шууд хамааралтай болох нь судалгаанаас харагдаж байна.

Алба хаагчид “Авлигын гэмт хэрэг”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т ихэвчлэн холбогдсон байгаа нь албаны чиг үүргийн хувьд хийх ёсгүй үйлдэл хийсний хариуд хахууль авдаг, ач холбогдол бүхий нотлох баримтыг устгадаг, хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахгүйгээр эзэнгүй хэрэг гэх байдлаар хугацаа сунгадаг, хууль ёсны шаардлага, цагдаагийн алба хаагчийн эрх, албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх тухай мэдлэг дутмаг, архидаг согтуурч гудамж талбай, гэр орон сууцанд маргаан үүсгэн бусдын биед гэмтэл учруулдаг, эрх мэдэл, албан тушаалын байдал, ажил үүрэгтэй холбогдуулан бусдаас зээл, тусламж авах зэргээс шалтгаалан гэмт хэргийн холбогдогч болж байна.

Энэ нь алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, улс төр, бизнес, эрүүгийн элементийн нөлөөнд автан эрхэлж буй албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөрийн хувийн эрх ашгийг урьтал болгон хэргийн оролцогч нартай шууд болон шууд бусаар харилцаа тогтоож, хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлж, хэргийг зориуд удаашруулж хахууль авах, цагдаагийн байгууллагын цахим мэдээллийн санд хууль бусаар нэвтэрч халддаг, санхүүгийн баримт хуурамчаар үйлддэг, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулдаггүй, эд мөрийн баримтаар хураагдсан сум, галт зэвсэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хувьдаа завшиж нотлох баримт хуурамчаар бүрдүүлж хэргийн оролцогч нарт ашигтайгаар шийддэг, архидаг согтуурч бусадтай маргалддаг, хууль дүрмийг сахин биелүүлдэггүй, удирдлагаас өгсөн үүрэг ажлын чиглэлтэй танилцадаггүй байдалтай холбоотой гэж үзэж болохоор байна.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц болон Цагдаагийн байгууллагын нэгдсэн сан, хоногийн хоногийн нөхцөл байдлын мэдээ, бусад сангаас гарах иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг задруулахгүй байхад анхаарч хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтан нь төрийн болон албаны нууцыг хамгаалах үүрэгтэйг анхаарч удирдах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг давтан сургалт, авлигаас ангид, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулж байх шаардлага тулгарч байна.

Цагдаагийн байгууллагаас тухай бүр гэмт хэрэгт холбогдон шалгагдаж шүүхэд шилжсэн, ял шийтгэгдсэн тохиолдол ¹⁵бүрийг судлан үзэж холбогдсон алба хаагч хаагчдыг албанаас халж, түр түдгэлзүүлэн, хууль эрх зүйн зөвлөмж тусалцаа хэрэгцээ шаардлагатай байгаа алба хаагчдад тусламж дэмжлэгийг тогтмол үзүүлж анги байгууллагуудад үүрэг ажлын чиглэл хүргүүлэн ажилласаар байна. Гэмт хэрэг, зөрчилд холбогдохоор сэргийлэхээр хүргүүлсэн аливаа зөвлөмж чиглэлийг алба хаагч уншин танилцаж гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тухайгаа нэн даруй захирах

¹⁵ Цагдаагийн албаны тухай хууль. 2017, УБ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2017, УБ

даргадаа мэдэгдэж гарч болзошгүй эрсдлийг бууруулах таслан зогсоох арга хэмжээ авдаггүй нь түгээмэл байна.

Судалгаанаас харахад АТГ, МБА-нд шалгагдсан гэмт хэрэг хамгийн түгээмэл байгаа нь цаашид алба хаагчдаас мэргэжлийн өндөр ур чадвар, шуурхай байдал, хуульч ажиллагаа, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглах, өөрсдийгөө бүхий л талаар хөгжүүлж, хүний эрхийг дээдэлсэн мэдрэмжтэй ажиллах хэрэгцээ шаардлагыг иргэд, олон нийтийн зүгээс илүү хурцаар тавих нь тодорхой харагдаж байна.

Дүгнэлт

1. Алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон талаар нэн даруй удирдлагадаа мэдэгдэх, ЦБҮАЖ-912”, “№ЦБҮАЖ-139” алба хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдсон тухай тэмдэглэлийг бичиж хэвшүүлэх

2. Мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хэсэг, тасгийн дарга нарт мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлогдвол зохих байдлыг тал бүрээс нь хуулийн анхны хугацаанд бүрэн дүүрэн шалгаж тогтоох чиглэлээр тавих хяналтыг сайжруулах, гурав ба түүнээс дээш хугацаа сунгасан хэргүүдийг чиглэлийн ахлах болон ахлах мөрдөгч нараар шалгуулах, үндэслэлгүйгээр хэргийн хугацааг сунгаж Мөрдөн шалгах ажиллагааг /зохиомлоор/ удаашруулдаг зөрчлийг таслан зогсоох, мэргэжил арга зүйгээр дэмжлэг үзүүлэх, Улс төр, нам, бизнес болон эрүүгийн нөлөө бүхий гэх тодотголтой бүлэглэл, этгээдүүдийн нөлөөлөлд автахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч хаагчид гэр бүл, найз нөхөд, хамаатан садны хүрээнд архиан согтуурч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэгт холбогдож байгаа нь алба хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага, биеэ авч явах зэрэг хувь хүний мэдлэг ур чадвар, сахилга батаас хамааралтай байгааг анхаарч үйл ажиллагааг явуулах.

4. Холбогдон шалгагдсан гэмт хэрэг нь шүүхэд шилжсэн, эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татагдсан, хэд хэдэн гэмт хэрэгт холбогдсон алба хаагчдын асуудлыг судлан шуурхай шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

5. Алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгэгдсэн, өртөж хохирсон тохиолдол бүрийг нэн даруй шууд удирдах албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэйг зохион байгуулалтын арга хэмжээ цаг алдалгүй мэдэгдсэнээр алба хаагчдыг хамгаалах нөхцөл бүрдэх талаар хүргэх.

Алба хаагчид Авлигын гэмт хэрэг, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт ихэвчлэн холбогдож байх тул мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд болон шууд удирдах дарга нарт хуулийг зөв хэрэглэх авлигын эсрэг давтан сургалтанд тогтмол хамруулж гэмт хэрэг, зөрчил, прокурорын шаардлага авсан алба хаагчдад явуулж байгаа сургалтыг үр дүнтэй явуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Цагдаагийн албаны тухай хууль. 2017, УБ
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2017, УБ
3. Аюулгүй байдлын салбар дахь парламентийн хяналт гарын авлага №05 2005, Женев
4. Тагнуулын албадыг хянах нь гарын авлага 2002., Женев
5. Санхүүгийн зохицуулах хороо “Байгууллагын хяналтын тогтолцоо, тэдгээрийн онцлог” 2021, УБ
6. Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газрын 2022, 2023 оны тайлан
7. Цагдаагийн ерөнхий газрын Дотоод аудитын тайлангын эмхтгэл 2022, УБ
8. www.Legalinfo;

ПИРАМИД ТОГТОЛЦООНЫ АРГААР ҮЙЛДЭГДДЭГ
ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫН ШИНЖ
IT WORKS AS A PYRAMID SYSTEM
CHARACTERISTICS OF SOCIAL DANGER IN FRAUD CRIME

В.Амарсанаа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш,
доктор (Ph.D), цагдаагийн хошууч
V.Amarsanaa
Police School at University of Internal Affairs,
Department of Public Law,
lecturer police major,

Хураангуй: Залилах гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, уламжлалт аргаар үйлдэгдэхээс гадна, цахим хэрэгсэл ашиглах, санхүүгийн пирамидын аргаар үйлдэгдэх зэргээр арга, хэлбэр нь нарийсч, улмаар иргэдэд ноцтой хохирол, хор уршиг учруулж байгаа өнөө үед уг гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлохыг зорилоо.

Abstract: The aim is to identify the nature of the social threat of fraud, which has increased sharply in recent years, and has been narrowed in its methods and forms by the use of electronic means and financial pyramids, resulting in serious harm and harm to citizens.

Түлхүүр үгс: Нийгмийн аюул, хохирол, хор уршиг, олон шатлалт маркетинг, өмчийн харилцаа, пирамид тогтолцооны луйвар, санхүүгийн пирамид.

Keywords: Social danger, damage, harm, multi-tiered marketing, property relations, pyramid scheme fraud, financial pyramid.

Монгол Улс чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжээд гуч гаруй жилийн нүүрийг үзжээ. Энэ багагүй хугацаанд шилжилтийн үеийн (1991-2000) хямрал, дэлхийн эдийн засгийн (2008-2010) хямрал, валютын зээлийн (2014 хойш) хямрал гэх гурван удаагийн эдийн засгийн хямрал тохиолдсон. Эдгээр хямралын сөрөг үр дагавар одоог хүртэл арилаагүйгээр барахгүй, цааш үргэлжилж, иргэдийн амьжиргааны түвшин буурах, орлогын эх үүсвэр хумигдах, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхэд шууд болон шууд бус байдлаар нөлөө үзүүлж байна.

Сүүлийн жилүүдийн төсвийн хэт тэлэлтийн үед аж ахуйн нэгжүүд болон өрхийн өрийн дарамт илт нэмэгдсэн. Орон сууцны 8 хувийн зээлийн хөтөлбөр 2013 онд хэрэгжиж эхэлснээс хойш өрхүүдийн дарамт нэмэгдэж, өрхийн өр дотоодын нийт бүтээгдэхүүн хоорондын харьцаа 40 хувьд дөхөж ирээд байна. Ийнхүү өртэй байдал нэмэгдэхийн хэрээр, иргэд хэрэглээгээ хумьж эхэлсэн нь эдийн засгийн уналтад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Орон сууцны зээлийн төлбөрийн дараа үлдэх хэсэг бусад хэрэглээний өсөлтийг хангахад хүрэлцэхгүй тул өрхүүд хэрэглээний зээл илүүтэй авч эхэлснээр өрхийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна. Энэхүү өрийн дарамт нь

дараагийн эдийн засгийн хүндрэлийн үед өрхийн санхүү улам муудаж, улмаар банкны салбарт зээлийн эрсдэл хүчтэй нэмэгдэх асуудал үүсгэж байна. Банкны зүгээс үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор амьжиргааны түвшин доогуур иргэдэд зээл олгох явдлыг хумих бодлого баримталж байгаагаас шалтгаалан, иргэд банк бус санхүүгийн байгууллагад хандаж, илүү өндөр хүүтэй зээл авч, өрхийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх явдал цөөнгүй гардаг.

Эдийн засгийн тогтворгүй байдал иргэдийн амьжиргаанд нөлөөлж, өрхийн санхүүд хүндрэл үүссэнээс шалтгаалан, ажилгүйдэл, ядуурал ихсэхийн хэрээр нийгмийн сэтгэл зүйн хямрал дэгдэж, гэмт хэрэг үйлдэгдэх явдал алгуур нэмэгддэг. Тэр дундаа амар, хялбар аргаар ашиг олох зорилго агуулж, бусдыг залилах гэмт хэрэг үйлдэх тохиолдол түлхүү өсдөг байна. Тэгэхээр эдийн засгийн тогтворгүй байдлаас шалтгаалсан төрийн хямралаас үүдэн, иргэдийн амьжиргааны түвшин буурах нь гэмт хэрэг, тэр дундаа залилах гэмт хэрэг ихээр үйлдэгдэх урьдчилсан нөхцөл болох явдал ажиглагдаж байна.

Залилах гэмт хэргийг “Бусдын эд хөрөнгө өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан, нийгэмд аюултай үйлдэл” гэж ерөнхий байдлаар тайлбарлаж болно. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж, эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол”¹⁶ гэж объектив талын шинжүүдийг тухайлан дурдсан.

Энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж нь иргэдийн эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах байдлаар илэрнэ. Бусдад их хэмжээний болон ноцтой хохирол учруулж залилах гэмт хэргийн үйлдлийн арга маш олон төрөлтэй болж, техник хэрэгсэл ашиглах, олон тооны хүнийг нэгэн зэрэг залилж, их хэмжээний эд зүйл, мөнгө, өмчийг төвлөрүүлэн авах зэрэг хэлбэрт шилжиж байна. Жишээлбэл, Д, Б нар нь амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор, урьдаас үгсэн тохиролцож, үргэлжилсэн үйлдлээр, бусдын дансны мэдээллийг хууль бусаар, тусгайлан бэлтгэсэн төхөөрөмж дээр хуулбарлаж, Малайз улсын иргэдэд мэдээллийг өгч, арилжааны банкуудын бэлэн мөнгөний машинаас 42 хохирогчийн данснаас нийт 71.790.800 (далан нэгэн сая долоон зуун ерэн мянга найман зуу) төгрөгийг авч, иргэдэд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Эдгээр этгээдүүдэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т заасан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон, нэмэлтээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцжээ¹⁷. Иргэн А нь бусдын фейсбүүк (Facebook) хаягт хууль бусаар нэвтэрч, тухайн цахим хаягийг ашиглан, хохирогч Ц-ээс 700.000 (долоон зуун мянга) төгрөг залилсан гэмт хэрэг үйлдсэн байна¹⁸. Цахим мэдээллийн хэрэгсэл ашиглаж, бусдын эд хөрөнгийг залилах, тодруулбал, фейсбүүк (Facebook), твиттер (Twitter) гэх мэт нийтээр өргөн ашигладаг платформуудад нэвтэрч, бусдыг залилах гэмт хэрэг нь шинэ хэлбэрийн үйлдлийн арга юм. Энэ мэтээр залилах гэмт хэргийн үйлдлийн арга нарийсаж, олон төрөл, хэлбэрт шилжиж

¹⁶ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7. 17.3 дугаар зүйл.


¹⁷ Фиделитас Партнерс ХХН. (2022). Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. (Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд). Нээлттэй нийгэм форум. УБ. 24 дэх тал.

¹⁸ Мөн тэнд. 24 дэх тал.

байгаа нь иргэдэд учруулах хохирлыг ноцтой хэмжээгээр нэмэгдүүлэхээс гадна, залилах гэмт хэргийн тоо жил бүр өсөн, нэмэгдэхэд нөлөөлж байна.

1996 онд улсын хэмжээнд нийт 22.368 гэмт хэрэг бүртгэгдсэнээс, 12.883 буюу 57.6 хувь нь бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг, үүнээс зөвхөн 373 буюу 4.1 хувийг, 1997 онд нийт бүртгэгдсэн, өмчийн эсрэг 13.347 гэмт хэргийн 416 буюу 3.1 хувийг, 1998 онд нийт бүртгэгдсэн, өмчийн эсрэг 11.568 гэмт хэргийн 438 буюу 3.8¹⁹ хувийг л залилах гэмт хэрэг эзэлж байсан бол 2019 онд бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг 18.341 гэмт хэргийн 4.688 буюу 25.5 хувийг, 2020 онд бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг 12.061 гэмт хэргийн 4.270 буюу 35.4 хувийг, 2021 онд бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг 13.632 гэмт хэргийн 6.558 буюу 48.1 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байна.

График 1. Өмчлөх эрхийн эсрэг нийт гэмт хэрэг дунд залилах гэмт хэргийн эзлэх хэмжээ (1996, 1997, 1998 – 2019, 2020, 2021 оны тоон мэдээн дээр)




Цагдаагийн байгууллагад одоогоос 20 гаруй жилийн өмнө бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн статистик, орчин цагт бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс төдийлөн ихсээгүй байтал, залилах гэмт хэргийн тоо 10 дахин нэмэгдсэн явдал нь сүүлийн жилүүдэд залилах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна гэж дүгнэхэд хүргэж байна. Зөвхөн 2021 онд бүртгэгдсэн, өмчлөх эрхийн эсрэг нийт гэмт хэргийн бараг 50 хувийг залилах гэмт хэрэг дангаараа эзэлж, хулгайлах гэмт хэргээс 1.979 гэмт хэргээр илүү бүртгэгдсэн нь анхаарал татаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2018 онд 7.182, 2019 онд 7.146, 2020 онд 6.209, 2021 онд 8.001, 2022 оны зөвхөн эхний 9 сарын байдлаар 11.353 залилах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, холбогдогчдыг яллагдагчаар татан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

График 2. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан залилах гэмт хэргийн тоо (2018-2022 он)

¹⁹ Булганхүү А. (2001). Залилан мэхлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ойлголт, криминологи шинж. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. Байлдааны гавьяаны одонт Цагдаагийн академи. 2 дахь тал.



Эндээс сүүлийн 5 жилийн байдлаар залилах гэмт хэргийн тоо өсөж, иргэдийн эд хөрөнгө өмчлөх эрхэд маш их хэмжээний хохирол учирсан болохыг харж болохоор байна. Залилах гэмт хэрэг сүүлийн жилүүдэд огцом өссөний нэг шалтгаан нь дэлхий нийтээр тархсан халдварт цар тахалтай (Ковид-19) шууд бусаар холбоотой байх үндэслэлтэй. Тодруулбал, цар тахлын үед улсын хэмжээнд хөл хорио тогтоож, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарласны үр дүнд нийтээрээ цахим харилцаанд шилжсэн.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон бусад өдөр тутмын хэрэгцээт зүйлсийн худалдаанаас эхлээд ихэнх харилцаа цахим хэлбэрт шилжсэн явдал нь цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг ихээр үйлдэгдэх нөхцөл болсон бөгөөд, залилах гэмт хэргийн үйлдлийн арга нарийсаж, олон төрөл, хэлбэрт шилжиж байгаа болохыг харуулж байна. Зөвхөн цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргээс гадна улсын эдийн засгийн хямралтай холбоотойгоор иргэд гэлтгүй, аж ахуйн нэгж байгууллагын амьжиргааны түвшин буурч, зарим нь дампуурах хэмжээнд хүрсэн эгзэгтэй үед амар хялбар аргаар ашиг олох зорилго агуулсан хүмүүсийн тоо урьд урьдынхаас ихсэж, залилах гэмт хэргийг байнга үйлдэж, амьдралын эх үүсвэр болгох, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдэхээс гадна олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэх явдал өргөн дэлгэрч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж өндөртэй болохын нэгэн илрэл юм.

Залилах гэмт хэргийн үйлдлийн аргууд дундаас хохирол, хор уршиг учруулах байдлаараа хавьгүй өндөрт тооцогддог, олон тооны иргэдэд богино хугацаанд, нэгэн зэрэг их хэмжээний хохирол учруулж, өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг богино хугацаанд алдагдуулж, сулран доройтуулдаг, нийгмийн аюулын шинж өндөртэй нь пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэгддэг залилах гэмт хэрэг юм.

Анхны өргөн хэмжээний санхүүгийн пирамид тогтолцоог Шотландын эдийн засагч, санхүүч Жон Ло (1671-1729) үүсгэн байгуулж, “Инфляцийн эцэг” гэх хоч авч байжээ. Санхүүгийн пирамид гэх ойлголт нь (англиар – pyramid scheme) 1970 оноос эхлэн нийтэд түгэн, дэлгэрсэн бөгөөд, 1975 онд “Merriam-Webster” толь бичигт уг ойлголтыг анх удаа тайлбарласан байдаг. Оросын Холбооны Улсын Төв банк “Санхүүгийн пирамид гэж пирамидын оролцогчдын орлогыг дараагийн оролцогчдын оруулсан мөнгөн дүнгээс бүрдүүлэх замаар, хөрөнгө оруулсан мөнгөн дүнгээс нь их хэмжээний орлогыг буцаан

олгох амлалт дор иргэдийн мөнгөн тэмдэгтийг татан төвлөрүүлдэг байгууллага”²⁰ гэж тодорхойлжээ. Санхүүгийн пирамидын аргаар залилах гэмт хэрэг үүсээд хэдэн зуун жил болсон бөгөөд, одоо үед ч энэ гэмт хэрэг үйлдэгдсэн хэвээр байна.

Дэлхийн улс оронд пирамид тогтолцооны аргаар үйлдэгдэж байсан том хэмжээний залилах гэмт хэргийн нэгэн жишээ нь ОХУ-ын иргэн С.П.Мавродийн үйлдсэн гэмт хэрэг байдаг. С.П.Мавродийн үүсгэн байгуулсан “МММ” буюу гурван М үсэгтэй залилангийн систем эд үедээ нэг өдөрт л 50 сая америк долларын орлого олж байжээ. Энэ залилангийн хохирогчдын тоо одоог хүртэл бүрэн тогтоогдоогүй байгаа бөгөөд 15 сая хүн хохирсон гэж үзэх ерөнхий тооцоолол бий. Тэрээр 1989 онд МММ гэсэн 3 үсэгтэй компани байгуулж, эхэндээ залилан, луйвартай ямар ч холбоогүй, жирийн аж ахуйн нэгж байдалтай үйл ажиллагаа явуулж, тухайн үедээ ашигтай, ирээдүйтэй компьютерийн программ худалддаг компани байжээ. 1993 онд Зөвлөлт засаг нуран унах үед МММ компани өргөжин тэлж, хөгжсөн байна. 1992 онд түүний компани улс орон даяар 300 гаран салбартай болсон байна. 1994 онд С.П.Мавроди пирамид тогтолцооны залилан үйлдсэн “МММ ИНВЕСТ” компаниа байгуулснаар луйврын эхлэл тавигджээ.

Зөвлөлт Холбоот Улс задран унаж, ард иргэд санхүүгийн хямралд орсон хүнд, хэцүү үед С.П.Мавроди иргэдийн амар хялбар аргаар ашиг олох гэсэн хүсэлд тулгуурлан, реклам, сурталчилгааг идэвхтэй хийж эхэлсэн байна. С.П.Мавроди өөрийнхөө зураг бүхий билет гэх тасалбар хийж, хүмүүст борлуулж, хууль зүйн үүднээс асуудал үүсгэхгүйн тулд уг билетийг худалдан авч байгаа хүмүүстэй гэрээ хийж, билетийн үнийг “МММ” компанид бэлэглэж буй явдал гээд, харин зөрүүлэн авч буй тасалбар нь компаний зүгээс бэлэглэгчдээ өгөх дурсгалын зүйл гэж, харин тодорхой хугацааны дараа хүмүүс билетээ “МММ”-д зарж, хүссэн мөнгөө буцаан авах үед нь өмнөх үйл ажиллагаа эсрэгээрээ эргэдэг байжээ. Энэ билетийн үнэ нь өнөөдрийн, өчигдөрийнхөөс үнэтэй гэсэн зарчмаар явж, С.П.Мавроди өөрөө үнээ тогтоодог байсан байна. Үүний үр дүнд хагас жилийн тодор тухайн тасалбарын үнэ анх гарсанаасаа 127 дахин өссөн юм.

“МММ” ажиллах зарчим бол санхүүгийн пирамидын ажиллах үндсэн зарчим юм. Билет худалдан авсан хүмүүс сарын дараа нөгөө билетээ зарахад үнэ нь өссөн байх ба үнийг өсгөж өгөх мөнгөө дараа дараагийн билет худалдан авагчдаас бүрдүүлэх энгийн зарчим буюу понзын схем юм. Энэ схем нь түрүүлж орсон хүмүүсийн мөнгийг сүүлд элсэн орсон хүмүүсийн мөнгөөр төлөх замаар явагдаж, оролцогч хүмүүсийн тоогоор хязгаарлагдах ба шинээр хүн ирэхээ болих үед л зогсох бөгөөд, тэр үед ихэнх пирамидын залилагчид мөнгөө аваад гадаад орон руу зугтдаг байсан. 1994 онд “МММ” компанид хийсэн татварын шалгалтаар 50 тэрбум рублийн татвараас зайлсхийсэн, мөн орлогоо нуун дарагдуулсан болох нь тогтоогдсон.

ОХУ-ын хууль сахиулах байгууллагаас С.П.Мавродийн үйлдлийг анзаарч байсан боловч, нотлох баримтгүйгээс гадна уг гэмт үйлдлийн арга нь тухайн үед анх нэвтэрсэн байсантай холбоотойгоор уг үзэгдлийг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байсан юм. Засгийн газар болон хууль, хяналтын байгууллагын зүгээс С.П.Мавродийн үйл ажиллагааг шалгаж эхлэхэд, хүмүүс ихээр сандарч эхэлсэн ба энэ үед түүний билетийн үнэ огцом унасан хэдий ч С.П.Мавроди “Билетийн үнэ огцом буурахад төрийн үйл ажиллагаа нөлөөлсөн. Удахгүй билетийн үнэ өмнөхөөсөө дахин өснө” гэсэн мэдэгдэл хийснээр үйл

²⁰ Хорунин А.Ю., Фильчакова Н.Ю., Рудченко Н.П. Финансовые пирамиды: к вопросу об актуальности и социальной опасности явления в современности. // Научная электронная библиотека «Киберленинка». URL: <https://cyberleninka.ru/article/n/finansovye-piramidy-k-voprosu-ob-aktualnosti-i-sotsialnoy-opasnosti-yavleniya-v-sovremennosti/viewer>.

ажиллагаанд нь шинэчлэлт (restart) хийсэн үйлдэл болжээ. Хэсэг хугацааны дараа иргэд мөнгөө бүр мөсөн алдсан гэдгээ ойлгож эхэлсэн ба үүнээс болж 50 гаруй хүн амиа хорлох үйлдэл хийсэн байна. С.П.Мавродид шүүхээс 4 жилийн хорих ял 20 сая рублийн торгууль оногдуулсан байна. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 70-120 тэрбум долларт хүрч байсан гэх мэдээ бий.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргийн нийгмийн аюулын шинжийг тодорхойлохын тулд нийгмийн аюулын шинжийн талаар ерөнхий ойлголтыг тодруулах шаардлагатай. Нийгмийн аюулын шинж нь хууль тогтоогч түүнийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөхөөс үл хамааран оршдог, объектив хүчин зүйл юм. Хэрэв хүнийг алах үйлдэлд Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхгүй боллоо гэхэд, нийгэмд хүнийг алах явдал энгийн үзэгдэл болж, хүч хэрэглэх явдал дээд цэгтээ хүрнэ. Хууль тогтоогч аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцоход нийгмийн аюулын хэр хэмжээ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Аюул нь байгалийн гамшгаас (газар хөдлөлт, үер, араатан амьтны довтолгоо) үүсэлтэй байж болно.

Хэрэв нийгмийн аюулын шинжийн мөн чанар нь хохирол учруулахад байдаг гэж үзвэл, хүн ам оршин суудаг газарт зэрлэг араатан ирж, хүмүүст хохирол учруулах, эсхүл тэнгэрээс солир унаж, хохирол учруулах нь нийгэмд аюултай үзэгдэл юм. Гэхдээ эдгээр үзэгдэл нь хүн хоорондын харилцааны хүрээнд явагддаггүй учир нийгэмд аюултай гэж үзэж болохгүй. Харин хүний санаатай, эсхүл болгоомжгүй үйлдлийн улмаас зэрлэг араатан амьтан хүмүүст хохирол учруулсан бол өөр хэрэг болно.

Энэ тохиолдолд араатан амьтны бус, хүний үйлдлийн нийгмийн аюулын шинжийн тухай асуудал хөндөгдөнө. Учир нь энэ үйлдлийн үр дүнд нийгмийн харилцаа, тодруулбал, хүн хоорондын харилцаа хөндөгдөж байгаа юм. Эндээс аливаа үйлдэл нь нийгэмд учруулсан хохирол, хор уршгийн хэр хэмжээнээс үл хамааран, хүний үйл ажиллагаа, оролцоо хамааралгүй, хүний эрэлт, хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахад чиглэгдээгүй тохиолдолд нийгэмд аюултай гэж үзэх үндэсгүй гэсэн дүгнэлт гарч байна.

Нийгмийн аюулын шинж нь аливаа үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх цорын ганц, найдвартай хэмжүүр юм. Профессор С.Жанцан “Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар гэдэг нь гэмт үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хуулийн хамгаалалтад авагдсан эрх, ашиг сонирхлын мөн чанар, үнэ цэнийг илэрхийлэх, хууль цаазын үнэлэмж юм”²¹ гэж, харин профессор Г.Совд “Гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ гэдэг нь гэмт хэргийн объектив тал буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгэмд хор аюул учруулсны эрчим ямар хэмжээнд байсан үр дагавар, хор уршиг, шалтгаант холбоо зэргээр тодорхойлогдоно. Үүнд: үйлдлээ хэрэгжүүлсэн арга, хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, орчин, цаг хугацаа, учруулсан хохирлын хэмжээ, түүнээс уламжлах үр дагавар зэрэг олон асуудлыг хамааруулж судалсны үндсэн дээр дүгнэлт хийж болно”²² гэж тус тус тодорхойлсон. Тэгэхээр гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж гэдэг нь прецедент (дараа дараагийн тохиолдлыг шийдвэрлэх туршлага болох анхны, үлгэрчилсэн жишээ) шинжийг агуулдаг, хүн, нийгэм, төрд мэдэгдэхүйц хохирол учруулдаг, шинэ гэмт халдлагын болзошгүй аюулыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авахуулахад хүргэдэг, зөвхөн гэмт хэргийн тухайд яригдах, объектив ба субъектив шинжийг агуулсан ойлголт гэж тодорхойлж болох юм.

Монгол Улсын түүхэнд пирамид тогтолцооны аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргийн улмаас олон мянган хүн хохирсон цөөнгүй тохиолдол бий. Үүний нэг жишээ нь

²¹ Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ. 2009. 192 дахь тал.

²² Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002. 77 дахь тал.

“Жи тайм (G TIME)” гэж алдаршсан, иргэн О нарын үйлдсэн хэрэг юм. Иргэн О нар нь “Жи Тайм корпорейшн компани эдийн засгийн хямралд өртөөд байгаа нийгмийн дундаж давхаргын хүмүүст туслах зорилгоор Казахстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаевын дэмжлэгээр 2012 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс өнөөг хүртэл хугацаанд дэлхийн 78 оронд амжилттай хэрэгжиж байгаа эдийн засгийн хямралын эсрэг олон улсын хамтарсан төслийн үйл ажиллагааны үр дүнд богино хугацаанд 8.000 ам.долларын урамшууллыг хэдэн ч удаа авах боломжтой, доороо хүн урьж, гишүүнээр элсүүлснээр багцаасаа хамаарч 268.000 – 20.000.000 төгрөг хүртэлх болон автомашины урамшуулал олгоно, хамгийн бага хөрөнгө оруулалтаар, хамгийн богино хугацаанд бүх боломжуудыг ашиглан, санхүүгийн эрсдэлгүйгээр, урьд өмнө байгаагүй амжилтад хүрэх боломжтой, хууль ёсны, найдвартай” гэсэн мэдээллийг олон нийтэд тараан, сурталчлах байдлаар бусдыг хуурч, зохиомол байдал зориудаар бий болгон, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулан, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 4-т заасан “Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж, ашиг хонжоо олох үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан, хуулиар хориглосон үйл ажиллагааг Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт явуулж, нийт 12.365 иргэнийг 27.965 хөтөлбөрт элсүүлж, 38.161.778.857 (гучин найман тэрбум, нэг зуун жаран нэгэн сая, долоон зуун далан найман мянга, найман зуун тавин долоо) төгрөгийн хохирол учруулан, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар залилах гэмт хэрэг үйлджээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар “Жи тайм корпорейшн” компанийн зарласан урамшуулал хөтөлбөрт нийт 12.367 иргэн, 38.2 тэрбум төгрөгөөр элсэн орсноос, 967 хүн иргэний хариуцагчаар тогтоогдсон. Тэгэхээр нийт элсэн орсон хүмүүсийн 967 нь буюу 7.8 хувь нь урамшуулал авсан, үлдсэн 91.2 хувь нь хохирч үлдсэн байна. Хэдийгээр “Жи тайм корпорейшн” компани нь гадаад худалдааны үйл ажиллагаа явуулж, иргэдэд бараа борлуулсан гэх боловч, гаалиар импортолсон барааны үнийн дүн нь иргэдээс цуглуулсан үнийн дүнгийн 10 хувьд хүрэхгүй байгаа явдал нь пирамид тогтолцооны аргаар үйлдсэн, залилах гэмт хэрэг гэж үзэх хангалттай үндэслэл болж байна. Мөн уг компани нь гадаад худалдааны чиглэлээр бодит үйл ажиллагаа явуулаагүй атал, сүлжээнд элсэгчдийн мөнгөнөөс татварт их хэмжээний мөнгө шилжүүлсэн нь хууль бус үйл ажиллагааг хууль ёсны мэт харагдуулсан үйлдэл юм.

Шүүхээс иргэн О нарын үйлдэлд “11.398 иргэнд 25.815.088.160 (хорин таван тэрбум найман зуун арван таван сая наян найман мянга нэг зуун жар) төгрөгийн буюу их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн” гэж үзэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2-т заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. “Жи тайм корпорейшн” компанийн үйлдсэн гэмт хэргийн үр дүнд иргэд, нийгэм, тэр дундаа залуу үед асар их хэмжээний мөнгөн ба мөнгө бус гэм хор, хохирол учирч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж өндөр болохыг тод харуулж байна.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэгддэг гэмт хэрэг сүүлийн гурван зууны туршид арга, хэлбэрээ өөрчлөн, нарийн зохион байгуулалтад шилжин, тархаж, их хэмжээний хохирол учруулсаар ирсэн түүхэн олон жишээ байдаг. Тухайлбал, Иргэн Б, Н, С, Сэ, Х, Ба, Т, Д нар бүлэглэж, 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 8 дугаар сарын хооронд Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Рокмон Бюлдинг компанийн байранд “Stamford trading Technologies нэртэй компанид хөрөнгө оруулалт хийвэл, долоо хоног бүр ногдол ашиг өгч, мөнгийг чинь өсгөнө” гэж зохиомол

байдлыг зориудаар бий болгон, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар залилах гэмт хэрэг үйлдэж, олон тооны иргэдэд 2.411.066.833 (хоёр тэрбум дөрвөн зуун арван нэгэн сая жаран зургаан мянга найман зуун гучин гурав) төгрөгийн (их хэмжээний) хохирол учруулсан байна²³. Уг аргаар үйлдэгддэг залилах гэмт хэрэг нь энгийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдэгддэг залилах гэмт хэргээс хохирлын хэмжээгээр харьцангуй өндөр, олон тооны хүнд нэгэн зэрэг хохирол, хор уршиг учруулдаг байдлаараа ялгагдаж байна. Энэ ч утгаараа нийгмийн аюулын шинж өндөртөйд тооцогдох гэмт хэрэг болох нь гарцаагүй юм.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1972 оноос хойш өдийг хүртэл хугацаанд, гадаад болон дотоодын 600 гаруй сүлжээний компани үйл ажиллагаа явуулж, дампуурах нь дампуурч, хариуцлага хүлээх нь хүлээсэн байна. Ийм олон тооны компани, байгууллага үйл ажиллагаа явуулж, маш олон хүнийг хохироосон байтал энэ төрлийн гэмт хэрэгт цагдаагийн байгууллагаас өөр хяналт тавьж, анхаарч байгаа төрийн байгууллага байхгүй нь харамсалтай. Үйл ажиллагааны чиг үүргээсээ хамаарч Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанк зэрэг байгууллагууд энэ тал дээр бүрэн хяналт тавьж ажиллах ёстой. Дан ганц цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх боломж, бололцоо тааруу учир иргэдийн гэнэн, итгэмтгий зан, амар, хялбар аргаар ашиг олох гэсэн хүсэл дээр тулгуурлаж, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар залилах гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй, цааш үргэлжлэх эрсдэл огт арилахгүй юм.

Дүгнэлт

Улс орны эдийн засгийн хямралаас үүдэлтэй, өрхийн санхүүгийн доройтол нөгөө талаас техник технологийн хөгжлийг дагаад залилах гэмт хэргийн үйлдлийн арга нарийсаж, олон төрөл, хэлбэрт шилжиж байгаа байдалтай нэгэн цэгт огтлолцох уулзвар дээр, амар хялбар аргаар ашиг олох гэсэн шунахайн сэдэлт сүлэлдэн нийлж, үр дүнд нь залилах гэмт хэрэг үйлдэгчдийн тоо урд урдны жилүүдээс огцом өссөн үзүүлэлттэй байгааг статистик дүн мэдээ харуулж байна. Зөвхөн 2021 онд бүртгэгдсэн, өмчлөх эрхийн эсрэг нийт гэмт хэргийн бараг 50 хувийг залилах гэмт хэрэг дангаараа эзэлж, хулгайлах гэмт хэргээс 1.979 гэмт хэргээр илүү бүртгэгдсэн болохыг дээр дурдсан билээ.

Хүн, нийгэм, төрд мэдэгдэхүйц хохирол учруулдаг, шинэ гэмт халдлагын болзошгүй аюулыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авахуулахад хүргэдэг, зөвхөн гэмт хэргийн тухайд яригдах, объектив ба субъектив шинжийг агуулсан, нийгмийн аюулын шинжийн тухай ойлголт дээр үндэслэн, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргийн нийгмийн аюулын шинж нь олон тооны иргэдэд богино хугацаанд, нэгэн зэрэг их хэмжээний хохирол учруулж, өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг богино хугацаанд алдагдуулж, дахин сэргэхэд хүндрэлтэй байдал үүсгэдэг, ихэнх тохиолдолд хохирол буцаан төлөгддөггүй, бусдын эд хөрөнгө өмчлөх эрхэд хууль бусаар халдаж, их хэмжээний хохирол учруулдаг байдлаар илэрнэ.

Өмнөх Эрүүгийн хуулиудад залилах гэмт хэргийн олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргыг хүндрүүлэх болон онц хүндрүүлэх нөхцөлд хамааруулан, эрүүгийн хариуцлага хүлээлгэх жишиг хараахан тогтоогүй байсан нь хууль тогтоогчдын зүгээс энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээг зохих түвшинд үнэлээгүй байсантай холбоотой юм. Улсын Их Хурлын чуулганаар 2015 оны 12 дугаар сарын 3-ны

²³ Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. Дугаар 685. 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдөр. https://shuukh.mn/single_case/48031?daterange=2001-01-01%20-%202023-03-05&id=1&court_cat=2&bb=1-ээс үзэв.

өдөр хэлэлцэн баталсан Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2-т “олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн” гэж анх удаа уг үйлдлийг онц хүндрүүлэх нөхцөлд хуульчилсан явдал нь олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдэгддэг залилах гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж өндөр болохыг хууль тогтоогчдын зүгээс онцгой анхаарсны үр дүн юм.

Ашигласан материал

1. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. Дугаар 685. 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдөр. https://shuukh.mn/single_case/48031?daterange=2001-01-01%20-%202023-03-05&id=1&court_cat=2&bb=1-ээс үзэв.
2. Булганхүү А. (2001). Залилан мэхлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ойлголт, криминологи шинж. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. Байлдааны гавьяаны одонт Цагдаагийн академи.
3. Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ. 2009.
4. Совд Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002.
5. Фиделитас Партнерс ХХН. (2022). Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. (Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд). Нээлттэй нийгэм форум. УБ.
6. Хорунин А.Ю., Фильчакова Н.Ю., Рудченко Н.П. Финансовые пирамиды: к вопросу об актуальности и социальной опасности явления в современности. // Научная электронная библиотека «Киберленинка». URL: <https://cyberleninka.ru/article/n/finansovye-piramidy-k-voprosu-ob-aktualnosti-i-sotsialnoy-opasnosti-yavleniya-v-sovremennosti/viewer>.
7. Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7.

--o0o--

**УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ БА ӨСВӨР НАСНЫ
ХҮҮХДЭЭС ҮЙЛДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ
PREVENTIVE WORK AND ADOLESCENT
CRIMES COMMITTED BY CHILDREN**

Г.Болор-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн
цагдаагийн удирдлага стратегийн профессорын багийн
ахлах багш доктор (Ph.D)

Bolor-Erdene.G

University of internal affairs,
Mongolia Academy of Management
teacher doctor Ph.D

Хураангуй: Энэхүү өгүүлэлээр өсвөр насны хүүхэд холбогдсон гэмт хэргийн хөдөлгөөн болон түвшин, өсөлтийг хэрхэн тогтворжуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг оновчтой зохион байгуулах, эрх бүхий төрийн байгууллагын хамтран ажиллах уяалдаа холбооны талаар үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тайлбарласан.

Abstract: This article explains the reasons for the rational organization of preventive measures to stabilize the movement, level and growth of crimes involving minors and the cooperation of competent government organizations.

Түлхүүр үгс: насанд хүрээгүй, гэмт хэргийн түвшин, өсөлт

Key words. Level and growth of juvenile crime

Үндсэн хэсэг. Эрүүгийн эрх зүйн судлагдахуунд 16 нас хүрсэн байвал хэрэг хариуцах бүрэн чадвартай субъект болно гэж үздэг. Зарим тохиолдолд 14 насанд хүрсэн байхдаа тодорхой тооны гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага оногдуулдаг.

2015 онд батлагдаж, одоо шинээр хүчин төгөлдөр мөрдөж буй хуульд нэр бүхий 12 гэмт хэргийг үйлдсэн байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Тодруулбал, хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл санаатай учруулах, хүчин, хулгай, эд хөрөнгийг устгах гэмтээх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, цахим мэдээллийн системд хууль бусаар халдах гэх мэтчилэн хэргүүд багтсан.

Эдгээр хуульд заасан нэр бүхий гэмт хэргийг үйлдсэн 14-16 насны этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт бий. Харин 14-өөс доош настай хүүхэд эрүүгийн болон бусад бүхий л төрлийн гэмт хэргийг үйлдсэн нөхцөлд ял оноодоггүй.

Хууль зүйн шинжлэх ухааны хүрээнд 14 нас хүрээгүй буюу бага насны хүүхэд нь өөрийн үйлдлийн хор уршгийг бүрэн ухамсарлах чадваргүй байдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, 14 насанд хүрээгүй бол тухайн хэргийг үйлдэгч эсвэл хохирогч ч бай бага насны хүүхэд л гэж үздэг учраас ял оноох эрх зүйн бололцоогүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлд хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгохыг заасан байдаг.

Дээрх зүйл ангийн 1.6 дугаар заалт дээр, Гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй байх юм бол прокурор тухайн хэргийг хэрэгсэхгүй болгодог.

Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэх үедээ хариуцлага оноох насанд хүрсэн бол ял онооно. Хэрвээ гэмт хэрэг хийх үедээ насанд хүрээгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Ийм л ойлголт. Түүнээс биш хүүхэд байхдаа гэмт хэрэг үйлдсэн гээд насанд хүрсэн хойно ялыг нь оногдуулна гэсэн зүйл хуульд байдаггүй.


Бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас хүлээлгэх ялыг өөр этгээдэд өмнөөс хүлээлгэхгүй гэсэн чухал зарчим байгаа. Хэдий гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй бол прокурор хэргийг хэрэгсэхгүй болгодог

Монгол Улсын хүн ам 2019 онд 3.296.866 болж өссөн бөгөөд нийт хүн амын 29.3 хувь буюу 1.969.070/ гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдийн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн бодлогыг Засгийн газраас тасралтгүй хэрэгжүүлсээр байгаа билээ. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчин сайжирч, тодорхой үр дүн гарч байгаа хэдий ч тулгамдаж байгаа шийдвэрлэх асуудал байсаар байна.²⁴

Насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдсон тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр нь авч үзэхэд нийт 2411 хэрэг, жилд дунджаар 756 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэрэг 2020 онд 811, 2021 онд 733 бүртгэгдэж өмнөх 2020 оноос 78 буюу 9,6 хувиар буурсан бол 2022 оны эхний 8 сарын байдлаар 867 гэмт хэрэг бүртгэгджээ. Үүнийг 2021 онд гарсан гэмт хэрэгтэй харьцуулбал одоогийн байдлаар 134 хэргээр буюу 15.4 хувиар өссөн дүнтэй байна.

Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн хөдөлгөөн




2020-2022 он хүртлэх хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөний хувьд авч үзэхэд тогтмол өсөлттэй хөдөлгөөн ажиглагдаж байна. 2021 онд буурсан үзүүлэлт харагдаж байгаа боловч энэ нь хүүхдийн эрхийг хамгаалах болон хууль сахиулах байгууллага сайн ажиллаж хүүхдийг гэмт хэргийн холбогдогч хохирогч болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг оновчтой явуулсан гэж дүгнэх нь учир дутагдалтай юм. 2021 онд дэлхий нийтийг хамарсан цар тахалын улмаас бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотой гадаад орчиноос тусгаарлагдаж сургалт, бусад үйл ажиллагаанд цахимаар оролцох болсон нь гэмт хэргийн хөдөлгөөнд шууд нөлөөлсөн.

2022 онд Монгол улсын нийт хүн ам 3.409.339 болж өссөн бөгөөд хүн амын өсөлт 2.6 хувийн өсөлттэй байна. Үүнээс 0-18 насны хүүхэд 1.316.054 сая буюу нийт хүн амын 38.5 хувийг эзэлж байх бөгөөд Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулинд хариуцлага хүлээлгэхээр заасан өсвөр насны хүүхэд 14-18 насны 276.930 буюу нийт хүн амын 8.2 хувийг эзэлж байна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдэж буй гэмт хэргийн түвшинг сүүлийн 3 жилээр Монгол улсын хэмжээнд /100000 хүн тутам/ авч үзэхэд огцом өсөх хандлагатай байна.


График №1. Гэмт хэргийн түвшин

²⁴ Үндэсний статистикийн мэдээллийн сан



2020 оноос хойш Гэмт хэрэг үйлдэж болзошгүй идэвхтэй насанд хүрээгүй хүмүүсийн түвшинг /10000 хүн тутам/ тодорхойлоход тогтмол өсөлттэй үзүүлэлт ажиглагдаж байгаан маш ихээр анхаарал хандуулах шаардлага үүсч байгаа харуулж байна.²⁵

График №2. Гэмт хэргийн өсөлт



Сургалт хүмүүжилийн байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдүүдийн 80 хувь нь 4-р ангийн боловсрол эзэмшсэн бол эдгээр хүүхдүүдийн 90 хувь нь гэмт хэрэг үйлдэхээсээ өмнө ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан байсан байна.

Гэмт хэрэг холбогдон шалгагдаж байгаа хүүхдүүдийн 12,3 хувь нь сургуульд суралцаж байгаагүй, 29,6 хувь нь 4 дүгээр ангийн боловсрол эзэмшсэн 39,3 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байсан.

Гэмт хэрэг үйлдэж байгаа хүүхдүүдийн 90 гаруй хувийг эрэгтэй хүүхэд эзэлдэг байсан бол эмэгтэй хүүхдүүдийн зүгээс үйлдсэн гэмт хэргийн хувь 2020-2023 оны хугацаанд 5-6 хувь, 7-8 хувь, 10 хувь болж өссөн хөдөлгөөн ажиглагдаж байна.²⁶

2020-2022 онд өсвөр насны 14-18 насны хүүхдийг гэмт хэрэг зөрчилд холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн байна.

2020 онд Улсын хэмжээнд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн 8 арга хэмжээ, 540 сургалт мэдээлэл, сурталчилгаа, 49 уулзалт, 557 хэлэлцүүлэг, ярилцлага, 13 өдөрлөг, 3 уралдаан тэмцээн зэрэг зохион байгуулж, нийт 445630 иргэнийг хамруулж, давхардсан тоогоор 345 телевизэд ярилцлага, мэдээлэл өгч, цахим орчинд 7280 мэдээлэл, зурагт контент, зах, дэлгүүр, худалдааны төв, нийтийн тээвэр, орон сууцны лифтэнд 112250 ширхэг зурагт хуудас байрлуулж, 7601 удаа нэгдсэн үзлэг шалгалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар иргэн, хуулийн этгээдэд 1350 мэдэгдэл өгч, 1210 буюу 89,6 хувьд нь хариу авч үр дүнг тооцсон.

2021 онд Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 160, уулзалт, хэлэлцүүлэг, сургалт 297 зохион байгуулж 2478 иргэнийг хамруулсан. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран

²⁵ www.police.gov.mn. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэлийн сан. //Татаж үзсэн: 10.06.2023

²⁶ Цагдаагийн байгууллагын ASAP сан.

давхардсан тоогоор 316 удаагийн мэдээ, мэдээлэл өгч, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар аж ахуйн нэгж байгууллагад 248 шаардлага өгч 196 буюу 79 хувийн хариуг авсан байна.

2022 онд Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүүхэд хамгаалал, Нуугдмал, Уусан бол бүү жолоод, Илрүүлэлт 2022, Хүүхэд таныг хамгаалъя, Эерэг хандлага гэрэлт ирээдүй, Хүүхэд бидний ирээдүй, Хүүхэд ба гэр бүл зэрэг ерөнхий чиглэлийн 7, Тамхины хяналт, Нэгдүгээрт хүүхэд, Дотуур байр аюулгүй орчин, Аюулгүй байдал бидний оролцоо зэрэг тусгай чиглэлийн 309, Хорт зуршилын хор уршиг, Хууль эрх зүйн мэдлэг, өөрийгөө хэрхэн хамгаалах зэрэг соён гэгээрүүлэх чиглэлийн 660 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан байна²⁷.

Дүгнэлт. Криминологийн шинжлэх ухааны хяналтын онолын үүднээс гэр бүл, найз нөхөд, сургууль, хууль сахиулах байгууллагын хяналт гэсэн хяналтуудаас аль нэг нь алдагдсанаас хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурч амьдралын бодитой зорилго төлөвлөгөөгүй болж ихэнх цагаа гудамжинд өнгөрөөх болдог байна. Ийм хүүхдүүд хэсэг бүлгээрээ нийгмийн сөрөг зан үйлд суралцах, харилцан гэмт зан үйл халдаах зэргээр сөрөг нийгэмшилд орж байна.

Тиймээс цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь сургалт мэдээлэл, сурталчилгаа, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, уралдаан тэмцээн зэрэг зохиох мэдэгдэл хүргүүлэх зэрэг арга хэмжээнүүд нь хараа хяналт сул байгаа хүүхдүүд рүү чиглэсэн бус хичээл сургуульд тогмол хамрагдаж ямар нэгэн гэмт явдалд холбогдохгүй гэмт зан үйлд автаагүй хүүхдүүд рүү чиглэж байгаа нь хүүхдийн гэмт явдлын түвшин, хөдөлгөөнөөс харагдаж байгаа тул сөрөг нийгэмшилд орж хүүхдүүд рүү чиглэсэн тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнд хүргэхээр байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Насанд хүрээгүй хүн холбогдсон гэмт хэргийн хөдөлгөөн болон түвшин огцом өсөлт ажиглагдаж байгаа тул энэ өсөлтийг тогтворжуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг оновчтой зохион байгуулах, 2020-2022 онд явуулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд болох сургалт мэдээлэл, сурталчилгаа, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, уралдаан тэмцээн зэрэг зохиох мэдэгдэл хүргүүлэх зэрэг нь үр дүнд хүрэхгүй байгааг өөрчлөн шинэлэг хэлбэрээ урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

2. Насанд хүрээгүй эмэгтэй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн хөдөлгөөн түвшин 2020-2022 он хүртэл өсөлттэй үзүүлэлт ажиглагдаж байгаа тул 14-18 насны эмэгтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг судлан тэдгээр хүүхдүүдийн онцлогт таарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Ашигласан материал

1. МУ-ын Эрүүгийн хууль \шинэчилсэн найруулга\
2. Цагдаагийн байгууллагын Asap сангийн гарын авлага цэс.
3. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэлийн сан
4. Үндэсний статистикийн мэдээллийн сан
5. Цагдаагийн ерөнхий газрын тайлан

²⁷ Цагдаагийн ерөнхий газрын тайлан

**МОНГОЛ УЛСАД АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХ
ЗАРИМ ШАЛТГААН НӨХЦӨЛ, ҮР ДАГАВАР
SOME CAUSES, CONDITIONS AND CONSEQUENCES
OF COMMITMENT OF CORRUPTION CRIMES IN MONGOLIA**

Б. Баярболд

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч,
/хууль зүйн магистр/

Bayarbold B.

Police School at University of Internal Affairs,
Department of Public Law,
lecturer police senior lieutenant,
/master of law/

Хураангуй: Монгол Улсад авлигын гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа ба цаашид ч өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь Монгол улсын хүн ам, үйлдвэрлэл, аж ахуй нэгжийн хөгжлөө дагах өсөлтэй холбогдохын сацуу монгол хүний тэр тусмаа оюутан, залууст тэдгээрийн гэр бүл, их сургуулийн орчин нөхцөлөөс шалтгаалан авлигач сэтгэлгээтэйгээр дээд боловсрол эзэмшиж, шинэ ажил, албан томилогдох хандлагатай байгааг харуулахыг зорьсон.

Abstract: The number of corruption crimes in Mongolia has been increasing in recent years, and the tendency to increase in the future is observed. It was intended to show the tendency of Mongolian people, especially students and young people, to acquire higher education and to be appointed to new jobs and positions with a corrupt mindset due to the environment of their families and universities.

Түлхүүр үг. Авлига, албан тушаалтан, хээл хахууль, иргэн

Key word. Corruption, officials, bribery, citizens,

Оршил. Монгол Улс Дэлхий даяар явагддаг авлигын индексийн судалгаагаар 2022 оны 12 дугаар сарын байдлаар 35 оноо авч нийт 179 орноос 110 дүгээр байранд жагссан үзүүлэлттэй байна²⁸. Монгол Улс хэдий ардаа 60 гаруй орныг орхисон боловч эх орны маань дийлэнх иргэд, албан тушаалтан авлигатай салшгүй, хүйн холбоотой болсон нь улсын маань хувьд томоохон эмгэнэлт асуудал болж байна.

Манай улсад хамгийн түгээмэл тохиолддог нөхцөл байдлууд буюу хүүхэд төрүүлэхэд эх баригч, сувилагч нарт гарыг нь цайлгах хөлс, төлбөр өгөх, төрүүлсэн хүүхдээ цэцэрлэгт, дунд сургуульд оруулахын тулд элдэв хандив нэрийдлээр багш нарт болон эрх бүхий албан тушаалтнуудад мөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг жишиг манай улсын иргэдийн хувьд нь гэм биш зан болоод байгаа билээ.

Ийм хэлбэрээр сурч, хүмүүжсэн хүүхдүүд насанд хүрч, оюутан болохын цагт багш нарт бусад оюутнуудаас ямар нэгэн зүйлээр ялгарч харагдахын тулд, эсхүл сурлага тааруу байлаа ч эцэг, эхээс уламжлан авсан буруу хүмүүжлээрээ багшдаа болон бусад танигдахын тулд авлига өгөх, албаны бус харилцаа үүсгэх, мөн их, дээд сургуулиа төгсөөд ажилд орохын тулд мөн л өнөөх хууль бус зан үйлээ хийсээр л байна. Ийм маягаар цаашид өөрсдийн үр хүүхдүүдээ хүмүүжүүлсээр эцэстээ шударга бус нийгмийг бүтээсээр байна.

Монгол Улсын хүн амын дийлэнх хэсэг нь энэ мэтчилэн гинжин хэлхээсээр гагнагдаж, аливаа зүйлийг хууль, дүрэм журмын дагуу бус харин асуудалд “зохицуулах” хэмээн ярьж заншсан буюу хууль бус, авлигач, хахуульч сэтгэлгээгээр хандаж байгаа нь Улсын хөгжлийг хойш татах,

²⁸ [Mongolia Corruption Index - 2022 Data - 2023 Forecast - 1999-2021 Historical - Chart \(tradingeconomics.com\)](https://tradingeconomics.com/mongolia/corruption-index)

төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн бус явагдах, шударга бус байдал, хүний эрхийн зөрчил үүсэх зэрэг олон асуудлуудын уг, үндэс нь болж байна. Монголд Улсад албан үүргээ гүйцэтгэж байгаа, зарим нэг эрх мэдэлтэй, нэр нөлөө бүхий, иргэд, олон нийттэй тогтмол харилцдаг ажилтан, албан хаагчид өөр, өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан, хууль бус үйлдлүүдийг шат шатандаа хийсээр байгаа нь нууц биш юм. Энэ хууль бус үйлдлүүдийг их, дээд сургуулиудын орчин нөхцөлд илрэх байдлаар нь авч үзье.

Их, дээд сургуулиудад элсэн суралцагчид нь ихэнхдээ тухайн сургуулийн босго, шалгуур үзүүлэлтүүдийг өөрсдийн авьяас, чадвараараа даван шалгарч, элсэн суралцаж эхэлдэг хэдий ч сургуульдаа тэнцэж орсны дараагаар маш их өрсөлдөөн үүсэж бий болох ба тэр их өрсөлдөөн дундаас сурлага сайтай, хичээнгүй, аливаа зүйлсийг цаг тухай бүрд хийх чадалтай суралцагчид маш бага хувийг эзэлдэг нь хэвийн, жирийн л нэг үзэгдэл. Харин үлдсэн суралцагчдын дийлэнхийг авлига, хээл хахуульд хөтөлдөг, тэдгээрийг өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэдэг зүйлийн нэг бол яахын аргагүй хичээлийн дүн, үнэлгээ билээ.

Монголын их, дээд сургуулиудад хахууль гэдэг зүйл нь бэлэг сэлт, бэлэн мөнгө өгөх зэрэг хэлбэрээр илрэхээс гадна багшийн зүгээс санал болгож буй “шахааны” гэх нэршилтэй номыг худалдан авах хэлбэрээр мөн илэрдэг.

Энэ нь их, дээд сургуулийн багш өөрийн эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж, өөрийн зүгээс санал болгосон номыг худалдан авсан оюутнуудад давуу байдал олгож, дүн үнэлгээг нь шударга бусаар өндрөөр үнэлж, тавьж буй явдал юм. Өөрөөр хэлбэл оюутнуудын хувьд багш нарын эрх мэдэл их дээд сургуульд их байдаг.

Эдгээр эрх мэдлээ урвуулан ашиглаж байгаа зарим нэг хэсэг бүлэг багш нар их сургууль бүрд байдаг нь үнэн бөгөөд, оюутнуудын аливаа шалгалтын дүн, мөн ирц, явц, хандлага гэх мэт тэднийг үнэлэх шалгуураас шалтгаалан, үнэлгээнд сэтгэл хангалуун бус байдлыг ашиглан, хясан боогдуулж шахааны гэх номыг нь худалдан авахаас өөр аргагүйд хүргэх тохиолдлууд элбэг байдаг. Багшийн зүгээс санал болгосон, оюутнуудын худалдан авахыг хүсээгүй номыг нэгэнт худалдан авсан оюутан суралцагчдад багшийн зүгээс дүн, үнэлгээний хувьд ч мөн хувийн харилцааны тал дээр ч давуу байдал олгож байдаг юм.

Хэрэгцээгүй ном, сурах бичгийг худалдан авахгүй байх сонголт оюутан, залууст байгаа хэдий ч шахааны гэх ном худалдан авсан бусад оюутан, суралцагчдаас дүнгийн хувьд харьцангуй доогуур үнэлгээтэй үлдэх хандлага ажиглагддаг. Мөн түүнчлэн удирдах, дээд шатны албан тушаалтнуудад энэхүү хууль бус үйлдлийн талаар хэлэх сонголт байгаа хэдий ч хэлсэн тохиолдолд оюутан, суралцагчид бидний өөрсдийн нуруун дээр ачаа, дарамт ирнэ гэсэн бодол, айдас байгаа нь уг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, түүнтэй тэмцэхэд хүндрэл учруулж буй гол шалтгаан юм.

Оюутан залуус их, дээд сургуулийн орчинд ном албадан зардаг асуудлыг авлигын гэмт хэргийн шинжтэй болох талаар тэр бүр мэдэхгүй байгаа нь тухайн асуудал нийгэмд энгийн үзэгдэл мэт болсон байгааг харуулж байна.

Судлагдсан байдал:

Их дээд сургуулиудад ил, далд аргаар үйлдэгдэж байгаа ном албадан борлуулах асуудлыг одоогоор судалсан ном, сэтгүүл, судалгааны ажил, өгүүлэл гэх мэт зүйл байхгүй байгаа ба цахим орчинд буюу фейсбүүк, твиттер гэх мэт олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн хувь хүмүүсийн үзэл бодол, нийтлэл төдий байсаар байна. Энэ нь тус асуудлын хохирогчид болох оюутнууд уг асуудлыг нэг талдаа шийддэггүй, ил гаргахгүй, тэмцэхгүй, өөхшүүлж байгааг харуулж байна.

Зорилго, зорилт:

Сүүлийн 2022 оны Олон Улсын авлигын индексийн судалгаагаар Монгол Улс хойгуур байр эзлээд байгаа билээ. Энэ нь маш олон хүчин зүйлсээс шалтгаалж байгаа ба тухайн хүчин зүйлсийн нэг нь их, дээд сургууль дах “номын шахаа” хэмээн нэрлэгддэг асуудал яахын аргагүй мөн юм. Тус асуудал нь оюутнууд болон багш нарын дунд энгийн үзэгдэл мэт болсон байгаа нь маш харамсалтай. Гэвч тухайн үйл ажиллагаа нь эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргүүдийн зарим

нэг шинжийг өөртөө агуулсан ба үүнийг оюутан, суралцагчдад түгээн танин мэдүүлэх, шийдэх арга замыг бусад Улс орны их, дээд сургуулийн тогтолцоотой харьцуулан олохыг зорьж байна.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах алхмуудыг хийнэ:

1. Авлигын гэмт хэргийн төрөл, хэлбэрийн талаар товч ойлголт өгөх
2. Төрийн их, дээд сургуулиудын оюутан суралцагчдаас судалгаа авна
3. Судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийнэ


Судалгааны арга зүй:

Энэхүү өгүүлэлд судалгааг анкетын, асуулгын, харьцуулалтын аргыг ашигласан болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Судалгаа:


Энэхүү судалгааг Монгол Улсын төрийн өмчийн их, дээд сургуулийн 120 гаруй оюутан суралцагчдаас авсан ба тухайн тулгамдаад байгаа асуудлууд нь тэдгээр их, дээд сургуульд байгаа эсэхийг нотлох, хэрэв нотлогдсон тохиолдолд судалгааны үр дүнд үндэслэн тухайн асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгааг олохыг зорьж хийсэн болно.



Дээрхи график нь судалгаанд оролцогчдын суралцаж байгаа их дээд сургуулийн эзлэх хувь хэмжээг харуулсан судалгаа юм.

Албан шахалтаар ном авч байсан уу?


120 responses



“Албан шахалтаар ном авч байсан уу?” гэсэн асуултад судалгаанд оролцсон суралцагчдын 55% нь тийм гэсэн хариултыг өгсөн ба энэ асуултын хариултаас харахад 7 их, дээд сургуулийн төлөөлөл 120 гаруй оюутан, суралцагчдын талаас илүү нь “шахааны” номыг авсан гэдэг нь батлагдах ба их, дээд сургуульд энэхүү асуудал нь түгээмэл байгааг харуулж байна.

Хичээлийн семистерт дунджаар хэдэн ном авах шаардлагатай болдог вэ? энэ семистерт авсан номны тоо байж болно.


120 responses



“Хичээлийн семистерт дунджаар хэдэн ном авах шаардлагатай болдог вэ?” /энэ семистерт авсан номны тоо байж болно/ гэсэн асуултад суралцагчдын дийлэнх нь хичээлийн жилийн зөвхөн нэг семистерт 1-ээс 2 ширхэг ном авдаг бол хамгийн ихдээ 6 ба түүнээс дээш ном багшийн шахалтаар дамжуулан авч байгаа нь батлагдаж байна.

Тухайн ном нь таны хэрэгцээг хангаж чаддаг уу?

122 responses



“Тухайн ном нь таны хэрэгцээг хангаж чаддаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 79 суралцагч “шахааны” ном нь өөрт ямар нэг байдлаар хэрэг болдоггүй гэж үзсэн. Энэ нь судалгаанд оролцогчдын 64.8% буюу 65% болно.


Ном авснаар танд гарах үр дүн юу байдаг вэ? (1ээс дээш хариулт сонгож болно)

120 responses




“Ном авснаар танд гарах үр дүн юу байдаг вэ?” гэсэн асуултад маш олон төрлийн хариулт ойролцоо хэмжээстэй ирсэн. Голчлон сонгогдсон судалгааны хариулт нь бие даалтаас чөлөөлөх, ирцийн оноо нэмэгдэх, дүн нэмэгдэх гэсэн хариултууд байна.

Ном шахсан багш, албан хаагчдыг сургуулийн захиргаандаа мэдээлэх боломж байдаг уу?
байхгүй бол яагаад?
120 responses



“Ном шахсан багш, албан хаагчдыг сургуулийн захиргаандаа мэдээлэх боломж байдаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 62% нь удирдах албан тушаалтанд албадан ном борлуулсан талаар мэдээлэх боломжгүй байдаг гэсэн хариултыг сонгожээ.

таны таньдаг, ойр дотны хүнээс дээрх асуудлын талаар сургуулийн захиргаандаа мэдэгдэж байсан хүн байгаа юу?
120 responses



“Таны таньдаг, ойр дотно хүнээс дээрх асуудлын талаар сургуулийн захиргаандаа мэдэгдэж байсан хүн байгаа юу?” гэсэн асуултад судалгаанд оролцсон 120 оролцогчийн 79 нь өмнөх асуултад хариулахдаа өөрсдөө удирдах албан тушаалтанд мэдэгдэх боломжгүй гэж үзсэн бол энэ асуултад оюутнуудын 112 нь таньдаг, ойр дотно хүн нь ном шахалтаар борлуулах, борлуулсан асуудлыг мэдэгдэж байгаагүй гэж хариулсан байна.

Түүнчлэн “Ном авахад багадаа хэдэн төгрөг зарцуулдаг вэ?” гэсэн асуултад оюутнууд 1 номыг албан шахалтаар худалдан авахад ихэвчлэн хорин мянгаас гучин мянган төгрөгийг зарцуулдаг гэсэн бол ерөнхийдөө гучаас дөчин мянган төгрөгийг зарцуулж байна.

Дээрх судалгаанд оролцсон 7 их дээд сургуулийн 120 суралцагчдын төлөөлөл болох арван нэгэн суралцагчаас ярилцлагын аргаар судалгаа авсан.

Асуулт 1. Та хэн нэгэнд авлига өгч байсан уу? Ямар шалтгаанаар өгч байсан бэ?

Асуулт 2. Суралцагчдад ном албадан борлуулах, түүнийг авах нь авлига гэдгийг мэдэх үү?

Асуулт 3. Хэрэв сургуулийн захиргаанд мэдэгдэх боломжтой бол хэлэх үү? Үгүй бол яагаад?

Асуулт 4. Таны хувьд шийдэх гарц гаргалгаа нь юу байж болох вэ?

Судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын ихэнх нь албан шахалтаар ном авсан гэж байгаа ч түүнийгээ авлигын гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл хэмээх ойлголтгүй байна. Түүгээр зогсохгүй нэг суралцагч 1 семестрт 2 ба түүнээс дээш номыг тус бүрд 20,000 төгрөг ба

түүнээс дээш үнийн дүнгээр худалдан авч байна. Мөн тус ном нь өөрт ямар нэг байдлаар хэрэг болдоггүй гэж үзсэн суралцагчид их байгаагаас дүгнэхэд оюутан залуус тогтсон ажил, орлогогүй цаашлаад семестр бүрд 2-оос дээш номыг авч байгаа нь тэдэнд давхар санхүүгийн дарамт үзүүлж байна.

Шахааны гэх номыг оюутан суралцагчид авахгүй өнгөрч болох ч дүнгийн хувьд асуудал үүсэх, багшийн зүгээс тухайн суралцагчид чиглэсэн сөрөг хандлага өгөх зэрэг тааламжгүй үр дагаврыг үүсгэх эрсдэлтэй байдаг. Хэрэв тухайн номыг авахгүйгээр удирдах албан тушаалтанд хэлэх, арга хэмжээ авхуулах сонголт байгаа ч 120 суралцагчдын 62% нь мэдээлэх боломж олддоггүй, 112 суралцагчийн ойр дотно, танил хэн нэгэн энэ асуудлаар өргөдөл, гомдол зэргийг гаргаж байгаагүй гэх сонголтыг хийснээс үзвэл их, дээд сургуулиудад энэ төрлийн хууль бус ажиллагааг мэдээлэх боломж хомс, мэдээллээ ч дорвитой арга хэмжээ авч чаддаггүйг харуулж байна. Оюутнуудад тулгамдаад буй энэ асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгаа нь албадаж борлуулах гэж буй номыг нийтээрээ худалдан авахгүй байх, сургуулийн захиргаанаас багш нарт тавих хяналтыг энэ тал дээр улам чангатгах шаардлагатай гэж үзэж байгаа хэдий ч энэ нь өөрөө тухайн асуудлын гаралтыг бууруулах, таслан зогсоох арга болж чадахгүй л байсаар байна.

Гадаад улсын жишээнээс харахад:

- ✓ ОХУ дахь Уралын В.Ф.Яковлевын нэрэмжит хууль зүйн улсын их сургууль нь оюутнууддаа хэрэглэгдэх бүх шаардлагатай ном, сурах бичгийг тарааж өгдөг;
- ✓ ОХУ-ын Санкт-Петербург дахь Зам харилцааны их сургууль нь оюутан, суралцагч нарт хэрэглэгдэх ном, сурах бичгийг номын санд нь хангалттай хүрэлцэхүйц тарааж өгдөг;
- ✓ БНХАУ-ын Chong qing дахь Xi Nan их сургууль нь багш нарыг хувиасаа ном албадан борлуулахыг хориглодог зэргээс үзвэл эдгээр их сургуулиуд нь багш нарыг ном албадан борлуулах нөхцөл байдлыг бий болгож өгдөггүй байна.

Тиймээс манай улс их, дээд сургуулиудад багш нарыг ном албадан борлуулахгүй байх бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй.

Мөн ОХУ-ийн “tabiturient.ru” сайтад тавигдсан доорх судалгаанаас харахад 2020 оны 4 дүгээр сард өрнөсөн их сургуулийн оюутнуудын дунд явагдсан нээлттэй санал асуулгад нийт 1125 оюутан оролцож үүнээс 8.27% нь авлигатай нүүр тулж байсан, 15.44% нь их сургууль дахь авлигатай нүүр тулж байгаагүй ч хэн нэгнээс сонсож байсан, харин 76.26% нь их сургууль дахь авлигатай огт нүүр тулж үзээгүй, энэ талаар огт сонсож ч байгаагүй гэсэн үр дүн гарсан байна.

Регион	Лично сталкивались с коррупцией	Слышали о коррупции	Никогда не сталкивались с коррупцией
Москва и Московская область	6.53%	11.84%	81.63%
Санкт-Петербург и Ленинградская область	10.53%	21.05%	68.42%
Регионы	12.28%	21.05%	66.67%
Общая картина	8.27%	15.47%	76.26%

В опросе приняли участие 1125 студентов

Үүнээс үзэхэд ОХУ-ын их сургууль дахь авлигал харьцангуй бага мэт юм шиг боловч тухайн оюутан суралцагчдын авлигын талаарх ойлголт хангалтгүй байгааг харуулсан үр дүн гарсан байна. Ойлголт хангалтгүй байна гэдэг нь авлига нь түгээмэл үйлдэгдэхээс гадна багш нарын зүгээс оюутан, суралцагчдад ном, сурах бичгийг хүчээр худалдан авахыг шаардах, анги танхимын тохижуулалт, их сургуульд хандив өгөх гэсэн арга хэлбэрээр өнөөх авлигын гэмт хэрэг

маань хэлбэрийнхээ хувьд хувьсан өөрчлөгдсөөр байгаа тухай мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг харуулж байна. Энэхүү үр дүнг дарах хүснэгтээр харуулав²⁹.

ОХУ-ын их, дээд сургуулиуд нь авлигатай тэмцэх зорилгоор зөвхөн авлигын гэмт хэргийн талаар, түүний бүхий л төрөл, хэлбэр зэргийг нарийвчлан судлуулах түүнчлэн их, дээд сургуулийн багш, алба хаагчид оюутан суралцагчдын авлигын эсрэг зан төлөв, хүмүүжлийг төлөвшүүлэх мэдлэг мэдээллийг олгох зорилготой цогц хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, хичээлийн нэг бие даасан судлагдахуун болгон үзэж, судалж байна. Энэ нь манай улсын нөхцөлд ч мөн хэрэгжих бүрэн боломжтой учир их, дээд сургуулиудад, оюутнуудын сонгон суралцаж ангийн чиглэл харгалзахгүйгээр зөвхөн авлигын гэмт хэргийн төрөл, хэлбэр, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх чиглэл бүхий бие даасан хичээлийн хөтөлбөр боловсруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

“Номын шахаа” гэх зүйл нь багш нар суралцагчдыг шахан боогдуулж оюутнуудад хэрэгцээгүй, чанарын шаардлага хангаагүй ном, сурах бичгийг өөрийн албан тушаал, эрх мэдлийг ашиглан борлуулж буй явдал хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл энэ нь эрүүгийн хуулийн 22.1 болон 22.4-т заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл юм. Тухайлбал тус гэмт хэргүүдийн субъект нь: нийтийн албан тушаалтан, төрийн үйлчилгээний гүйцэтгэх, туслах төрлийн албан тушаалтнууд (эмч, багш, соёл, урлагийн байгууллагын ажилтан гэх мэт) зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан тушаалтан байна³⁰.

Энэ нь багш өөртөө эдийн ашигтай байдлыг албадан үүсгэж нөгөө талаараа ном авсан оюутан суралцагчдыг ном аваагүй суралцагчидтай харьцуулахад илүү давуу байдалтай харилцахаас эхлээд дүн үнэлгээг шударга бус тавих нөхцөл байдлууд гарч байна. Эндээс үүсэж буй сөрөг үр дагавруудын нэг нь авлига гэдэг зүйлийг энгийн үзэгдэл мэтээр хүлээн авч, ойлгох, аливаа зүйл дээр шударга бус хандах зэрэг эргээд нийгэмд томоохон хохирол үзүүлж болох дадал зуршлыг багш нарын зүгээс мөн оюутан залуусын өөрсдийнх нь зүгээс ч бий болгож буй явдал юм.

Албан байгууллагын ажилтан, иргэд, олон нийттэй харьцах чиглэлийн хүмүүс нь зайлшгүй их, дээд сургуульд боловсрол эзэмшин бэлтгэгдэн ажилд гардаг бөгөөд оюутан байх хугацаандаа дээрх нийгэмд хортой зан үйлийг энгийн л нэг, байж болох харилцаа мэтээр ухамсарласан нь түүний ирээдүйд авлигач, хүнд суртал үзүүлэгч, хууль зөрчигч нэгэн болгож байна. Энэ асуудал нь Монгол Улс авлигын индексээр хойгуур байранд орж байгаагийн томоохон шалтгаан юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. [Mongolia Corruption Index - 2022 Data - 2023 Forecast - 1999-2021 Historical - Chart \(tradingeconomics.com\)](https://tradingeconomics.com)
2. С.Гантулга., Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй тусгай анги., 2020он., УБ., [Коррупция в вузах. Миф или реальность? \(tabiturient.ru\)](http://tabiturient.ru)

²⁹ [Коррупция в вузах. Миф или реальность? \(tabiturient.ru\)](http://tabiturient.ru)

³⁰ С.Гантулга., Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй тусгай анги., 2020он., УБ., 332 дах тал

АШИГТ МАЛТМАЛ ХУУЛЬ БУСААР ОЛБОРЛОХ ГЭМТ ЯВДАЛД ХИЙСЭН
ТҮҮХ-ЭРХ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
HISTORICAL-LEGAL ANALYSIS OF THE CRIME OF ILLEGAL MINERAL
EXTRACTION AND CURRENT ISSUES

Батбаярын Цогтбаатар

ДХИС-н ЦС-ийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, Хууль зүйн доктор, (Ph.D), цагдаагийн хурандаа

Tsogtbaatar Batbayar

Criminal Procedure Department of Police Academy
Head of Department, Ph.D, Police colonel

Хураангуй. Уул уурхайн салбар дагасан ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт явдалд түүх-эрх зүйн дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид анхаарах асуудлаар санал дэвшүүлсэн болно.

Abstract:. A historical and legal analysis of the crime of illegal mineral extraction in the mining sector was carried out, current issues were determined, and proposals were recommended for future attention.

Түлхүүр үг. Ашигт малтмал, хууль бус олборлолт, гар аргаар олборлогч, олзворлох, малтас бүхий, иргэчүүд.

Keyword. Minerals, illegal mining, artisanal miners, gained, excavated, citizens

Нэг. Удиртгал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд байгаль орчны тэнцвэрийг хадгалах, усны нөөцийг хамгаалах, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын ховордлоос сэргийлэх нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс³¹ хэмээн заасан билээ.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, иргэдийн амьжиргаанаас хамааран, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралт 2016 онд 165, 2017 онд 330, 2018 онд 366, 2019 онд 489, 2020 онд 626, 2021 онд 601, 2022 онд 559 гэмт хэрэг үйлдэгдэн³², түүний улмаас учирч буй хохирол нь жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Үүний дотор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг өсөж, учруулах хохирол, хор уршиг нь тухайн нутаг дэвсгэрээс хальж хилийн бүс болон улсын хэмжээнд нөлөөлөх болсон нь дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72 хувь, экспортын 90 хувийг дангаар эзэлдэг³³ манай улсын хөгжлийн үндэс болсон ашигт малтмал олборлох салбарт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилд эрчимтэй үйлдэгдэх болсон ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн хамгаалал талаас нь анхаар байгаа хэдий ч улсын хил хамгааллын бодлоготой уялдуулан авч үзэх талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, дүн шинжилгээ хангалтгүй байна.

³¹ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (Монгол Улсын Их Хурлаас баталсан 1994 оны 56, 2010 оны 48 дугаар тогтоол) Уб., 2010. 38 дахь тал.

³² ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2023. Уб., 2023. 216 дахь тал.

³³ Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2019 он. Уб., 15 дахь тал.

Ашигт малтмал хууль бусаар олборлох үйлдлийн онцлогийг дурдвал, зохион байгуулалттай, “нуугдмал, далд³⁴” хэлбэрээр хэрэгждэг бөгөөд түүнийг нотлоход бэрхшээлтэй байдаг нь судалгаагаар тогтоогдсон. Тиймээс ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг түүх-эрх зүйн хувьд судалж, мөрдөн шалгах болон нотлох ажиллагаанд улсын хил хамгаалах байгууллагыг татан оролцуулах, хамтран ажиллах, энэ талаарх хил хамгаалалтын үр нөлөөг дээшлүүлэх нь энэхүү сэдвийг хөндөх үндэслэл боолсон.

Энэхүү сэдвийн хүрээнд хамруулан Б.Одонгэрэл³⁵, Я.Цэлмэн³⁶, П.Очбадрах³⁷ нар, хохирол тогтоох ажиллагааны талаар биологийн доктор Г.Эрдэнэбаясгалан³⁸ өөрсдийн бүтээлээ туурвисан байна. Түүнчлэн проф Х.Пэрлээ, Г.Сүхбаатар, Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Ч.Далай, Ш.Бира, Г.Совд³⁹, Б.Содовсүрэн, Т.Сэнгедорж, О.Амархүү, Д.Лүндээжанцан зэрэг эрдэмтэн судлаачид өөрсдийн бүтээлүүдэд байгаль хамгаалах асуудлыг төр, эрх зүй, түүхэн уламжлал талаас авч үзсэн байна. Дагнасан эрдэмтэн судлаачдаас док. Ц.Цэлмэг, Ж.Нямдулам⁴⁰, С.Гантулга, Б.Энхболд⁴¹, Д.Батболд⁴² нарын бүтээлийг дурдаж болно.

Улс орнуудын хил дамнасан, ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Үндэстэн дамнасан зохион байгууллагатай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага нь энэ төрлөөр дагнасан судалгаа явуулдаг⁴³.

Хоёр. Үндсэн хэсэг

Манж-Чин гүрний үед Монголын газрын өмчлөлийн дээд субъект нь Манжийн хаан болон солигдож, албан баримтад Монголын газар нутгийг “Эзний (Манжийн) албан газар” гэж нэрлэснээс өөр газар, түүний хэвлийн ямар нэгэн өмчлөгчийн эрхийг хөндсөн зүйл, заалтгүй ажээ.

Зарим хятад иргэд тухайн үеийн хил хязгаарын зарлиг зөрчиж, суурьшин тариа тарих болсноор Монгол газарт урьд өмнө үзэгдэж байгаагүй “ашигт малтмал хууль бусаар олборлох”-той холбоотой гэмт явдал гарах болсон нь манай улс Манж Чин улсын эрхшээлд байх үеэс эхэлжээ. Тухайлбал, хятад иргэд хулгайгаар алт ухсан тухай Сайн ноён аймгийн чуулганаас их жургаанд явуулсан бичгээс⁴⁴: “...Эдүгээ чуулганы дарга миний газар хэрэгтэн засаг нарыг зарлан авч Засагт хан аймгийн гүн Сандавдорж, харьяат аймгийн гүн Ойдовдорж нарын хамт нийлж шүүвээс, засаг Дамринжавын мэдүүлэх нь миний бие урьд тушаалаар алт гарах газрын харуулыг захирч бүхүйд төр гэрэлтийн тавдугаар он (1825) хавар цаг Онгон Улаан хэмээх газарт иргэчүүд алт малтахаар ирэв хэмээн Тайж Дамиранжаваас мэдүүлээр ирсэнд, тус хошууны тайж Шагдарыг тэдгээр иргэдийг хөөн явуул хэмээн тушааж мордуулсны дараа Шагдарын хойш ирж хэлсэн үг: миний бие тайж

³⁴ Асуулгад оролцсон 172 ажилтны 150 буюу 85 хувь нь энэ гэмт хэрэг “нуугдмал, далд буюу төвөөс алсмагдал, сууршилын бүсээс хол, хөдөө хээр, очиход бэхшээлтэй газарт үйлдэгддэг ба ихэвчлэн бүртгэгдээгүй хэргийн шинжтэй” гэж хариулсан болно.

³⁵ Б.Одонгэрэл. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2020.

³⁶ Я.Цэлмэн. Хуулийн этгээдэд холбогдох хэргийн нотолгоо. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2021.

³⁷ П.Очбадрах. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2021.

³⁸ Г.Эрдэнэбаясгалан. Амьдрах орчны үнэлгээнд тулгуурлан байгаль орчны хохирлыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох нь. Биологийн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2019.

³⁹ Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. УБ., 1997. 63 дахь тал.

⁴⁰ Ж.Нямдулам. Уголовно-правовая охрана отношений в сфере добычи полезных ископаемых по законодательству Монголии и Российской Федерации. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2015.

⁴¹ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018.

⁴² Д.Батболд. Ашигт малтмал өмчлөл, ашиглалтын Үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2020.

⁴³ 2016 global initiative against transnational organized crime. All rights reserved

⁴⁴ Ар Монгол дахь хятадын худалдаа-мөнгө хүүлэл (1751-1911). Баримт бичгүүд. УБ., 1988. 219-220 дахь тал. БНМАУ. ТТА, ФМ. 58, Д.1, ХН. 26, Х.28-31/

Дамиранжавын хамт Онгон Улаан хэмээх газарт очвоос жаран долоон иргэн, наян гурван тэмээ, жаран таван илжигтэйг олж цааш хөөж явуулаад ирэв хэмээн хэлсэн” ...засаг Дуламжавын мэдүүлэх нь: “төр гэрэлтийн хоёрдугаар онд (1822) засаг би харуулыг захирч бүхүй тус хошууны тайж Жалцан, Жамц нарыг зарж харуулыг байцаалгасанд тэдний ирж хэлсэн нь: зуух харуулын тайж Гонгор нь таван сард Онгон Улаан хэмээх газарт тавь гаруй иргэчүүд алт малтахаар ирснийг Гонгор би хөөж явуулсан.” Тайж Санрай, харц Цэвэг нарын хамтаар мэдүүлэх нь: Сайшаалт ерөөлтийн хорьдугаар онд (1815) гүн агсан Минжүүрдорж харуулыг захирч бүхүйд Онгон Улаан хэмээх газарт хорин таван иргэчүүд алт малтахаар ирснийг Санрай, Цэвэг бид нар захирсан гүнд мэдүүлсэнгүй, шууд хөөж явуулаад, дараа гүн агсан Минжүүрдоржид мэдүүлсэн хэмээн мэдүүлнэ... Төр гэрэлтийн наймдугаар он долоон сарын арван хоёр (1828.08.22)⁴⁵.

XVIII зууны сүүлчийн хагаст Монгол нутагт алт, эрдэнийн чулуу, бусад ашигт малтмалыг малтан авч ашиглахыг манж нар хориглож, Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн нутагт халх Монголын хилийн орчимд байх Алтан ууланд тусгай харуул гаргадаг болсон байна. Алтны харуул анхандаа 8 суурь, хожим нэмэгдсээр 20 гаруй суурь болж, Засагт хан, Сайн ноён хан аймгаас 105 өрх, түүнийг ээлжлэн захирах, засаг, туслагч түшмэд нэжгээд, хөтөл хоёрыг тогтмол дайчлан суулгаж цагдуулах арга хэмжээ авч байсан байна. Энэ нь өнөөгийн хилийн бус зурваст ашигт малтмал, уул уурхайн салбарын нөлөөлөл нь эрт ч эдүгээ ч илэрч байсны нотолгоо байх үндэслэлтэй. Алтны харуулын нэг өрх жилд 90 лан, захирах засаг 80 лан, туслагч 80 лан, хөтөл 10 лангийн зардал хэрэглэж⁴⁶ байсан талаар эх сурвалжид тэмдэглэгджээ.

Ийнхүү 1800 оны дунд үеэс манай улсад ашигт малтмалын нэгэн төрөл алтыг хууль бусаар олборлох явдал хятад иргэдээс, хил дамнуулан үйлддэг, зохион байгуулалтын шинжтэй болсон бол, манай улсын хувьд хамгаалалтын шинжтэй харуул гарган хил хязгаараас хөөдөг байснаас бус барьж хорих, ял шийтгэх, эрүү шүүлт тулгах явдал байгаагүйг нотолно.

Богд хаант Монгол Улсын үеийн гол хууль “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т “Түшмэлийн засаг” хэмээх 51 дүгээр дэвтэрт нийт нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хариуцан хамгаалж байх үүргийг харьяа засаг нарт ногдуулж, тэдгээрийн хариуцлагыг заажээ. Мөн Богд хаант Монгол Улсаас 1913 онд “Хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгүүлэх дүрэм хэмжээ” баталсан байна. Энэ дүрмээр тус улсын ба Орос улсын, жич бусад аль ч улсын хүн уурхай нээхийг гуйх, уурхай нээхийг эрж үзэх, малтаж үзэх, малтаж олсон уурхайн хөрөнгө, түүнээс улсын санд тушаах гааль, хүлээх хариуцлагыг зохицуулжээ⁴⁷. Энэ дүрэм нь 38 зүйлтэй⁴⁸ бөгөөд бүлэглэн, ангилаагүй байна. Энэ журмын 32 дугаар зүйлд: “Хааяа тэмдэгт бичиг хүлээн аваагүй хүн уурхайн хороон дор үйлдвэр хийх ба сул оршин суух нь буй аваас харьяат түшмэлийн газраас тэд нарыг даруй хөөн зайлуулан, хэрэг будилаан өдүүлэх гэмийг арилгаваас зохимуй” гэж зааснаас үзэхэд, тухайн үед ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэгтэй тэмцэж байжээ дүгнэж болохоор байна.

Ардын хувьсгал ялж 1923 оны 8 дугаар сарын 20-ны өдөр “Ардын засагт Монгол Улсын уурхайн дүрмийг ардын засгийн газраас батлан гаргасан байна. Энэ дүрэмд уурхайг захирах, уурхайг шинжлэн эрэх, уурхайг битүүгээр тэмтрэн үзэх, уурхайг малтах, уурхайн дотоод байдлын тухай асуудлыг зохицуулжээ. Дүрмийн 36 дугаар зүйлд зааснаар: “аливаа хүмүүс зохих тэмдэгт бичгийг үл аван уурхайг шинэчлэн эрэх буюу нарийвчлан тэмтрэн үзэх ба малтас аваас хууль ёсоор шийтгэж, Монголын хязгаараас үлдэн явуулмой⁴⁹” гэсэн нь улсын хил хязгаараас хөөх уламжлал хадгалагдаж ирснийг харуулж байна.

⁴⁵ Мөн тэнд

⁴⁶ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 1206-1910. I. Уб., 554 дэх тал.

⁴⁷ Монгол Улсын ашигт малтмалын хуулиуд. 1910-2010. (эмхэтгэл: Б.Өлзийбаяр, Б.Цэцэнбилэг) Уб., 2010. 5-10 дахь тал.

⁴⁸ Б.Гүнбилэг, И.Идэш, Г.Банзрагч нар. Эрдэс баялгийн эрх зүйн тойм. Уб., 2012. 11 дэх тал.

⁴⁹ Монгол Улсын ашигт малтмалын хуулиуд. 1910-2010. Уб., 2010. 18 дахь тал.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхны Эрүүгийн хууль болох “Шүүх цаазын бичиг”⁵⁰-ийн 103 дугаар зүйлд: “Алт мөнгөний зэрэг эрдэнийн зүйл, элдэв эрдэнийн чулууг жич: чулууны тос, чулууны нүүрс зэргийг зоргоороо тэмтрэн үзэх буюу малтагсдыг 3 сараас 3 жил хүртэл хугацаагаар гянданд хорьж, олсон зүйлүүд ба элдэв хэрэгслийг албадан хураана⁵¹” гэж заасан нь ашигт малтмалын хууль бус олборлолтыг хязгаарлах шаардлага тулгарч байсныг харуулж байна.

Эрдэс баялгийг олборлох үйл ажиллагаа нь 1930-1990 оныг хүртэл 60 гаруй жилийн хугацаанд зөвхөн төрийн оролцоотой явагдаж байсантай холбоотой тул хил орчмын бүсэд ашигт малтмал олборлохтой холбоотой зохицуулалт шаардагдаж байгаагүй бөгөөд сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд уг асуудал улсын хил хамгаалалтад сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн шинжийг өнөөгийн Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд:

1.Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан;

2.Тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учирсан;

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн;

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн” гэж тодорхойлсон байна.

Ашигт малтмал хууль бусаар олборлох талаар түүх-хэл зүйн сурвалжид Я.Цэвэл: “ашигт малтмал” гэдгийг “газрын хөрсөн доороос малтаж авах элдэв баялгийн зүйл⁵²” гэсэн утгаар, “малтмал” гэдгийг “малтаж авсан юм; ашигт малтмал⁵³” гэж “олзворлох, олзолворлох” гэдэг нь ижил утгыг агуулсан гэж үзсэн байх бөгөөд тайлбар хэсэгт “уурхайн баялгийг эрэн малтаж ашиглах, олзолворлох үйлдвэр, олзолворлох эрх⁵⁴” гэсэн утгаар тайлбарласан байх ба түүний бүтээлд “олборлох” гэсэн үг ороогүй байна.

Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэж тухайн хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгох, үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөх зэрэг ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэсэн ойлголтыг агуулж байна. Хууль бусаар газрын хэвлийд халдах шийдвэрийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргасан байж болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл тодорхойлогдоно.

Ашигт малтмалыг ердийн, түгээмэл тархацтай, цацраг идэвхт гэх зэргээр ангилдаг бөгөөд түгээмэл тархацтай ашигт малтмалд элс, хайрга, дайрга, шороо, чулуу, шавар зэрэг байгаль дээр түгээмэл байдаг барилга үйлдвэрлэлийн салбарт ашиглагддаг зүйлс ордог. Үүнийг Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйлд заасан “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих” зүйлээр шалгана.

Мөн зөрчил болгон заасан “Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: олборлосон, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, хадгалсан” үйлдлийн хувьд хилийн бус зурваст үйлдэгдэх явдал ихэссэн бөгөөд хэдийгээр тусгай зөвшөөрөлгүй гэдгээрээ эрүүгийн хуульд заасан шинжийг агуулах боловч

⁵⁰ Д.Адьяабазар. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. Уб., 1998. 7 дахь тал.

⁵¹ Дурдсан бүтээл. 21 дэх тал.

⁵² Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. (нэмж дэлгэрүүлсэн гуравдугаар хэвлэл). : Мөнхийн үсэг. Уб., 2021. 73 дахь тал.

⁵³ Дурдсан бүтээл. 483 дахь тал.

⁵⁴ Дурдсан бүтээл. 601 дэх тал.

халдлагын зүйл нь ердийн ашигт малтмал бус “байгалийн өнгөт, үнэт чулуу” байдгаараа зөрчилд тооцон хуульчилсан байна.

Мөн “техникжсэн” гэх тодотголтой, хөрөнгө орлогоор давуу, хангамж хэрэгслээ шийдвэрлэх боломжтой, мэдээлэлд ойрхон, албан тушаалтны дэмжлэг авах боломжтой нэг хэсэг нь хайгуулын тусгай зөвшөөрөл болон нөхөн сэргээлт хийх гэрээг халхавч болгон ашиглах, техник хэрэгслийн хүчин чадлаар, харьцангуй өндөр ашиг олох зорилгоор, зохион байгуулалтын хэлбэрт орж бусдыг гэмт хэрэг үйлдэх “хэрэгсэл” болгон үйлддэг зэргээрээ улсын хил хамгаалалтад үзүүлж буй нөлөөллийн шинж илэрдэг.

Дэлхийн зарим улсад учирсан ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн нөлөөлөл

Латин Америкийн улс орнуудыг жишиг болгон сонгож, нарийвчлан судлах нь хожим Монгол Улсад ямархуу хэмжээний хохирол сүйрэл учирч болох таамаглалыг дэвшүүлэх, урьдчилан харах, үүсэх нөхцөл байдлаас гарах гарцыг эрэлхийлэх нэг чиглэл болох юм.

XXI зууны эхний арван жилд дэлхийн хамгийн том кокайн үйлдвэрлэгчид хууль бус алтны экспортын үнэ кокайны экспортын үнээс илүү болсныг анхаарах болжээ⁵⁵. АНУ болон бусад оронд ялангуяа Колумб, Мексиктэй “хар тамхины эсрэг дайн” зарлаж, Латин Америкаас АНУ-руу мансууруулах бодис худалдаалах гэмт хэргийн ашиг орлого огцом буурч байсан үед алтны үнэ өссөнөөр алтны уурхайн ашиг орлого ихээхэн нэмэгдсэн. Үүний үр дүнд, гэмт хэргийн бүлэглэлүүд мансууруулах бодисын худалдаанаас алт олборлолт руу шилжих явц ажиглагдаж байна.

Бүс нутгийн хувьд авч үзвэл, алт олборлолтын нэлээд хувийг хууль бус олборлолт эзэлж байна. Тухайлбал; Перугийн алт олборлолтын 28 хувь, Боливийн 30 хувь, Эквадорын 77 хувь, Колумбын 80 хувь, Венесуэлийн 80-90 хувь нь тус тус хууль бусаар олборлож байна.

Колумбын засгийн газрын эрх баригчдын үзэж байгаагаар Колумбын хувьсгалт цэргийн хүчний гэмт бүлэглэл⁵⁶ нь хууль бусаар алт олборлож улсын хил зөрчиж нэвтрүүлэн борлуулах замаар санхүүжилтийнхээ 20 хувийг бүрдүүлдэг, энэхүү бүлэглэлийн нэг “34 дүгээр фронт” дангаараа хууль бус олборлолтоос сар бүр 1 тэрбум ам.долларын ашиг олдог гэж тооцсон байна⁵⁷.

Перу улсаас 2014 онд тэрбум гаруй ам.долларын үнэтэй 35 тонн алтны контрабандын хэрэг үйлдэгдэж, Лима улсаар дамжуулан АНУ, Швейцар луу усан онгоцоор тээвэрлэгдсэн бол, Болив улсаас хууль бусаар олборлосон 68 тонн орчим алтыг Амазон болон хойд хилийн нутгаар гаргасан зэрэг нь манай улстай харьцуулахад 15-30 дахин өндөр хэмжээнд байна.

Судалгаанаас үзэхэд, Колумб улс 4.9 сая хүн амыг нүүлгэн шилжүүлснээс (10 колумб хүн тутмын нэг) 87 хувь нь ашигт малтмалын хууль бус олборлолт явагддаг Амазоны хилийн бүс нутгаас нүүлгэсэн болохыг харуулж байна. “Карнеги Амазон Мөнгөн ус” төслийн гар аргаар алт олборлогчид жил бүр Амазоны бүс нутагт байгаа гол мөрөн, нууруудад 30 гаруй тонн мөнгөн усыг хаядгаас нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувьд аюулгүйн хязгаараас 34 дахин өндөр түвшинд хүрч, тархины гэмтэлтэй хүүхэд төрж байна. Мөн Амазоны ширэнгэн ой их хэмжээгээр сүйрч ойролцоогоор 1680 км² ой устсан байна. Ихэнх ой чийглэг ойн эко бүс нутагт байгаа бөгөөд Гайана, Перугийн баруун урд хил, Амазоны сав, Бразилын Тапажос-Хингугийн чийглэг ой, Колумбын Магдалена хөндийн Урабагийн чийглэг ой устаж үгүй болж байна.

Гэмт хэргийн бүлэглэлүүд хүрэхэд хэцүү, хил орчмыг хязгаар бүс, газар нутгийг олж авч, хууль бус алт олборлолтыг харьцангуй бага эрсдэлтэй, өндөр ашигтай хийх, ашгаа хадгалах зуураа орон нутгийн газар нутаг, хүн амын дунд өөрийн эзэмшлээ хадгалахыг чармайдаг байна.

Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн дотоод нөхцөл байдал

⁵⁵ www.GlobalInitiative.net (Хандалт: 2019 оны 5 сар)

⁵⁶ FARC-Revolutionary Armed Forces of Colombia https://en.wikipedia.org/wiki/Revolutionary_Armed_Forces_of_Colombia (Хандалт: 2019 оны 6 сар)

⁵⁷ www.GlobalInitiative.net (Хандалт: 2019 оны 7 сар)

Судалгаанаас үзэхэд, цагдаагийн байгууллагын бүртгэсэн хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн 12-15 хувийг “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэг эзэлж байна.

Хууль бус олборлолтын гэмт хэргийн үйлдлийн арга сүүлийн жилүүдэд улам нарийсаж, бүлэг зохион байгуулалттай, нууц далд хэлбэрт шилжсэн, хүн очиход бэрх хөдөө хээрийн нөхцөлд, хилийн бүс зурваст хяналтгүй үйл ажиллагаа явуулах, орон нутгийн төр, захиргааны алба хаагч нарыг ашиглан тэдний туслалцааг авах байдлаар ял шийтгэлгүй өнгөрч байгаа нь бүртгэсэн нэг хэргийн ард нуугдмал 2-3 хэрэг байна гэж дүгнэх үндэслэлтэй бөгөөд сүүлийн 5 жилд 624 гэмт хэрэг бүртгэсэн бол үүний цаана бүртгээгүй 1200 гаруй хэрэг үйлдэгдсэн гэж үзэхээр байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн 26-38 хувийг (624) хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг эзэлжээ. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг он дарааллаар авч үзвэл: 2016 онд 35, 2017 онд 104, 2018 онд 126, 2019 онд 136, 2020 онд 223, 2021 онд 175, 2022 онд 155 гэмт хэрэг үйлдэгдсэн⁵⁸ нь энэ төрлийн гэмт хэрэг төдийлөн буурахгүй байх хандлагатайн илрэл.

Ашигт малтмал олборлох, ашиглахтай холбоотой хилийн дэглэмийн зөрчил 2010 оноос хойш хилийн зурваст 44, хилийн бүсэд 48 удаа үйлдэгдсэн⁵⁹.

Бид дээрх тоо баримтад тулгуурлан энэ төрлийн гэмт хэрэг өсөхөд нөлөөлсөн дараах хүчин зүйл байгааг дурдвал:

1. Судлаачид “Орон нутгийн удирдлагын хувийн сонирхол, авлига, хээл хахуулийн асуудлаас үүдэж, хил орчмын нутаг дэвсгэрт байгалийн баялаг ашиглах, олборлох, түрээслэх, газар нутгийн маргаантай асуудал ихээр гарч байгаа нь дотоодоос үүсэх аюулыг ихэсгэж байна⁶⁰” гэж дүгнэсэн нь үндэслэлтэй. Тухайлбал, Баянхонгор⁶¹, Дорноговь⁶², Төв⁶³, Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, шат шатны засаг даргын захирамж, гэрээний заалтыг судлахад эвдэгдсэн газар нутгийг нөхөн сэргээхийн тулд, тусгай зөвшөөрөлгүйгээр олборлолт явуулахыг зөвшөөрсөн хэм хэмжээг тусгасан шинжтэй акт гаргасан байна.

2. Сүүлийн жилүүдэд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Газрын тухай, Ойн тухай, Усны тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2015 оны 151, 2022 оны 296-р тогтоолоор баталсан “Бичил уурхай ашиглах журам” зэргийг илт зөрчсөн “Нөхөн сэргээлт хийлгэх тухай” олон тооны тогтоол, шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэр нь сөрөг үр дагавар үүсгэсэн байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга, ИТХ-ын дарга нар 2015 онд 82 аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөлтэй нөхөн сэргээлт хийх, зардлаа эвдэгдсэн газарт байгаа ашигт малтмалыг дахин олборлож олох эрх олгосон шийдвэр гаргасан.

Өнөөгийн байдлаар 20 аймгийн 78 суманд 214 газарт хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж байна.

2017 онд Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас орон нутагт явуулсан судалгаагаар хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлгүй 12 аж ахуйн нэгж 112.1 кг алтыг стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монголбанкинд тушаасан, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй гэх 19 аж ахуйн нэгж 597.9 кг алтыг

⁵⁸ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2019. УБ., 2020. 226 дахь тал.

⁵⁹ Хууль сахиулахуй. (Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2020. №02 (24). 229 дэх тал.

⁶⁰ Хил судлал. (Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, сургалт, арга зүй, танин мэдэхүйн улирал тутмын сэтгүүл) УБ., 2019. №01. 20 дахь тал.

⁶¹ Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 8/4 дугаар тогтоол, мөн аймгийн засаг даргын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн №4 тоот Бөмбөгөр сумын нутагт нөхөн сэргээлт хийх гэрээний 1.4., 1.5-д “өөрөө болон үйл ажиллагаанаас олсон орлогоороо санхүүжүүлэх, утгуур ачигч 4, угаах төхөөрөмж 4 ширхэг” ажиллуулах заалт нь олборлолт явуулахыг дэмжсэн.

⁶² Дорноговь аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/626 тоот захирамж. 2017 оны 01 тоот гэрээ,

⁶³ Төв аймгийн Заамар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03, 05 дугаар тогтоол, мөн сумын засаг даргын 2014 оны 02 тоот “Заамархаан ХХК-ийн гэрээт талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гурвалсан гэрээ”-ний 2 дахь заалт.

стандарт хэмжил зүйн газраар сорьцлуулан Монголбанкинд тушаасан, мөн стандарт хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын хэлтсээр 5603.9 кг алтанд сорьц тогтоолгосноос 55.5 хувь (3039.6кг) нь л Монголбанкинд тушаажээ⁶⁴. Үлдсэн алт хаагуур хэрхэн шингэсэн нь тодорхойгүй байгаа нь улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн гэх таамаглалд ч хүргэж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт “дэлхийн 23 улс, 687 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас гадна манай улсын хуулийн этгээдийн нэр дээр гадаадын 11 улсын хуулийн этгээд 1000 орчим ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг⁶⁵” нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд шинэ боломжийг олгох болсон ч түүний хажуугаар шинэ эрсдэлийг дагуулах болсон. Тухайлбал, судлаачид “манай улсын хилийн бүс, зурваст гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал, газрын тос олборлох явдал эрс нэмэгдэж, гадаадын ажиллах хүч олноор байрлаж ажиллах болсон нь орон нутгийн ард иргэдийн дургүйцлийг төрүүлж гадны иргэд, байгууллагын үйл ажиллагааг саатуулах, зогсоох, нутгаасаа хөөхийн зэрэгцээ ард иргэдийн үзэл бодол, үйл ажиллагааг дэмждэг зохион байгуулалттай бүлэг, эвсэл, холбоо байгуулагдсан⁶⁶” талаар дүгнэлт хийсэнтэй санал нэг байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Монгол Улсад ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт явдал XVIII зууны үеэс эхлэн түүхэнд тэмдэглэгдэж, Богд хаант Монгол Улсын хууль тогтоомжоос эхлэн хуульчлагдан, нийгмийн хөгжилтэй уялдан эрх зүйн зохицуулалтад тусгагдаж иржээ.

2. Эрүүгийн хуулиар “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалыг багтааж, түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг зөрчлийн хуулиар зохицуулжээ. Энэ нь байгалийн элемент, газрын хэвлийд учруулдаг хохирлыг төдийлөн тооцолгүй журамласан нь өмнөх хуулиас ухарсан зохицуулалт болжээ.

3. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийн холбогдогчтой нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан “нөхөн сэргээлтийн гэрээ”-ээр халхавчлан хууль бус олборлолт явуулах боломж олгож байгаа нь ялангуяа хилийн бүс, зурваст ажиллаж байгаа цагдаа, хил хамгаалах байгууллагын хяналт шалгалтаас хөндийрүүлэх гарц болж байна.

4. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаа, хил хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Санал: Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна.

1.1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “...тээврийн хэрэгсэл ...тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд...” гэсэн заалтыг: “...гэм буруутай этгээдийн өмчлөлд байгаа эсэхээс үл хамааран хураан авах” гэж өөрчлөх;

1.2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт ердийн болон цацраг идэвхт ашигт малтмал дээр түгээмэл тархацтай ашигт малтмалыг нэмж эрүүгийн эрх зүйн хамгаалалтад авах.

1.3. Хил орчмын бүсэд ашигт малтмалын хууль бус олборлолт явуулж байгааг илрүүлж, нотлох ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хил хамгаалах байгууллагатай харилцан мэдээлэл солилцон, хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2023. Уб.
2. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2019 он. Уб.

⁶⁴ П.Очбадрах. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2021.

⁶⁵ Хууль сахиулахуй. (Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл) Уб., 2020. №02 (24). 230 дахь тал.

⁶⁶ Д.Дашдаваа., Ц.Ганболд., А.Муратхан. Хилийн аюулгүй байдал. Нэг сэдэвт бүтээл. Уб., 2021. 92 дахь тал.

3. Б.Одонгэрэл. Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.
4. П.Очбадрах. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа. Диссертаци. Уб., 2021.
5. Г.Эрдэнэбаясгалан. Амьдрах орчны үнэлгээнд тулгуурлан байгаль орчны хохирлыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох нь. Диссертаци. Уб., 2019.
6. Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. Уб., 1997.
7. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. Уб., 2018.
8. Д.Батболд. Ашигт малтмал өмчлөл, ашиглалтын Үндсэн хуулийн үндэслэлийг хөгжүүлэх нь. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.
9. 2016 global initiative against transnational organized crime. All rights reserved
10. Ар Монгол дахь хятадын худалдаа-мөнгө хүүлэл (1751-1911). Баримт бичгүүд.
11. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 1206-1910. I. Уб.

**БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДЛЫГ МӨРДӨГЧИЙН АЖЛЫН
МӨН ЧАНАРААР ТОДОРХОЙЛОХ НЬ**
THE NATURE OF INDEPENDENCE AND IMPARTIALITY
OF DETECTIVES



Х.Буянтүмэн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах
хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, ДХИС-н докторант

Mr. Buyantumen Khaltar, Commissioner in Charge, Head of
Investigation Department of the Independent Authority Against
Corruption, PhD candidate of the University of Internal Affairs

Товч агуулга: Эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан, хараат бус байдал түүний ойлголт, мөн чанар зэрэг нь өнөөг хүртэл маргаантай, шийдэгдээгүй байгаа тул уг асуудлыг хөндөж, зарим зүйлд хэсэгчлэн дүн шинжилгээ хийсэн.

Abstract: The concept and nature of the independence and impartiality of the detective in the criminal process are still controversial and unresolved, so this issue was raised and some aspects were partially analyzed.

Түлхүүр үг: мөрдөгчийн бие даасан байдал, **Keyword:** Detective's independence

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт: “мөрдөн шалгах ажиллагаа гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах ...хуульд заасан ажиллагааг” хэлнэ гэжээ. Мөн хуулийн 6.2 зүйлийн 2.5 дахь хэсэгт зааснаар “прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах” гэжээ. Үүнээс үзэхэд мөрдөгчийн бие даасан байдлыг түүний эрхийн хүрээнд хуульчилсан байна.

Эрүүгийн процесс болон түүний дотор мөрдөн шалгах ажиллагаа дахь мөрдөгчийн бие даасан байдал (цаашид мөрдөгчийн бие даасан байдал гэх) нь Монгол Улсын Эрүүгийн процессын шүүхээс өмнөх шатын нэг чухал институт бөгөөд өнөөдөр эрүүгийн процессын зохион байгуулалт, эрх зүйн зүй зохистойгоор шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Мөн эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдлын ойлголт, мөн чанар зэрэг нь өнөөг хүртэл маргаантай, шийдэгдээгүй байна.

Эрүүгийн процессын онолын эрдэмтэд мөрдөгчийн бие даасан, хараат бус байдлыг тэдгээрийн эрх зүйн байдал; процессын эрх, үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрх; эрүүгийн процессын ажиллагаанд тэдний гүйцэтгэх чиг үүрэг, байр суурь, процессын эрх зүйн зарчим талаас нь авч үзэх хандлага зонхилж байна.

ОХУ-ын эрдэмтэн С. Н. Хорьяков: “эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал”, “мөрдөгчийн эрх хэмжээ” гэсэн ойлголт нь өөр хоорондоо философийн “шалтгаан”, “үр дагавар” гэсэн ухагдахуунд хамаарна”⁶⁷ гэжээ. Эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал нь түүний процессын эрх хэмжээг тодорхойлох үндсэн эх үндэс мөн. Хаана мөрдөгчийн бие даасан байдал хязгаарлана, мөн түүний эрх хэмжээ хязгаарлагдах үндэстэй. Нөгөө талаас мөрдөгчийн бие даасан байдал нь түүний эрх хэмжээгээ хэрэгжүүлэх процессын баталгаа болно.

Монгол Улсын эрүүгийн процессын хууль тогтоомжид мөрдөгчийн бие даасан байдлын тухай нэг ч тодорхойлолт өгөөгүй байна. Энэ нөхцөл байдал нь эрүүгийн процессын шинжлэх ухаанд тухайн ойлголтын талаар үзэл санаа нэгдмэл бус байгааг харуулж байна. Зарим судлаачид

⁶⁷ Хорьяков С. Н. Процессуальная самостоятельность следователя: дисс. ... канд. юрид. наук. М, 2006. С. 21.

мөрдөгчийн шийдвэр, үйл ажиллагаанд тавих хэт их хяналтын шалтгаанаар тухайн бие даасан байдлыг үгүйсгэх ч хандлага ажиглагдаж байна⁶⁸.

Эрдэмтэн Н. И. Кулагин⁶⁹ “эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал нь гэмт хэргийн хохирогчийн төдийгүй, мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашгийг үр нөлөөтэй хамгаалахад тусална”⁷⁰ гэжээ.

Эрдэмтэд мөрдөгчийн бие даасан байдлын талаар зөрүүтэй байр суурийг илэрхийлж байна.

Тухайлбал В. Л. Будников, Е. В. Волколупов нар: “мөрдөгчийн бие даасан байдал гэдэг нь мөрдөгчид хуулиар олгосон бүрэн эрхийг дотоод итгэлээрээ хэрэгжүүлж, хариуцлагаа биечлэн хүлээх боломж олгосон бодит үндэслэл”⁷¹ гэжээ. Энэ үзэлтэй санал нийлэмгүй байна. Бидний үзэж буйгаар мөрдөгчийн дурдсан боломж нь төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж, төрөөс баталгаажсан эрх хэмжээ мөн.

Мөрдөгч бие даан хэрэгжүүлэх мөрдөн шалгах ажиллагааны явцад гаргасан алдааны төлөө хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь эрүүгийн материаллаг болон процессын хууль тогтоомж, түүний зарчмуудын хэрэгжилт, эдгээр хуулиудын шүүхийн өмнөх шатны, тухайлбал, мөрдөгчийн, прокурорын хууль хэрэглээний алдаа “шүүхийн алдаа” болон өрнөх зүй тогтолтой⁷².

А. А. Клейны үзэж буйгаар эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдлын хамгийн түгээмэл тодорхойлолт нь “мөрдөн шалгах болон процессын бусад ажиллагаа явуулах, энэ талаар шийдвэр бие даан гаргах эрх, түүнийг хуулийн дагуу шуурхай бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын цогц, түүний эрх зүйн байдлын нэг чухал бүрдэл хэсэг”⁷³ гэжээ.

Мөрдөгчийн бие даасан байдал нь түүний эрх зүйн байдлын нэг чухал элемент гэж хүлээн зөвшөөрч болох боловч, энэ нь түүний эрх үү, аль эсвэл үүрэг үү гэдэг нь тодорхой бус байгаа юм. Тухайлбал Г. М. Ясинский: “мөрдөгчийн бие даасан байдал нь мөрдөн шалгах ажиллагааны шийдвэл зохих асуудлыг үнэн зөв, шуурхай хэрэгжүүлэхийн тулд хуулийн дагуу, хэргийн материалд үндэслэн дотоод итгэлээрээ шийдэх эрх. Бие даасан байдал нь нөгөө талаас мөрдөгчөөс мөрдөн байцаах ажиллагааг үнэн зөв, шуурхай шийдвэрлэх бүх талын хүчин чармайлт санаачилга гаргах үүрэг хүлээлгэнэ”⁷⁴ гэжээ. А. Р. Вартанов тухайн үедээ эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал гэж эрүүгийн процессын зорилгыг хангахын тулд хуулиар тогтоосон шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох, байцаан шийтгэх ажиллагааны явцыг чиглүүлэх, мөрдөн шалгах болон процессын бусад ажиллагааг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой шийдвэрийг нотлох баримтыг чөлөөтэй үнэлэх үндсэн дээр өөрийн үзэмжээр гаргах, хэрэгжүүлэх эрх мөн”⁷⁵ гэж томъёолжээ.

Бидний үзэж байгаагаар мөрдөгчийн бие даасан байдал нь Монгол Улсын эрүүгийн процессын хуульд шүүх, прокурорын зөвшөөрөл шаардахаас бусад мөрдөн шалгах болон

⁶⁸ Горюнов В. В. Процессуальная самостоятельность следователя в свете реформы следственного аппарата // Российский следователь. 2012. № 19. С. 13-16; Кругликов А. П. Единый следственный аппарат в России: понятие, проблемы образования и функционирования // Российская юстиция. 2014. № 3. С. 62-65.

⁶⁹ Цаашид эрдэмтэн, профессорыг зөвхөн нэрээр нь дурдах болно.

⁷⁰ Кулагин Н. И. В защиту прав и законных интересов следователя // Права человека и правоохранительная деятельность. Волгоград, 1995. С. 105-106.

⁷¹ Будников В. Л., Волколупов Е. В. Проблема процессуальной самостоятельности следователя как субъекта доказывания по уголовному делу // Современные проблемы уголовно-процессуального доказывания. Сборник статей. Волгоград: Изд-во ВолГУ, 2000. С. 141.

⁷² Ч.Нямсүрэн. Шүүхийн алдааг тандахуй//Шударга ёсны хэмжүүр. 2018.12. №2/022

⁷³ Клейн А. А. Правовые и организационные аспекты процессуальной самостоятельности и независимости следователя органов внутренних дел : дисс. ... канд. юрид. наук. М., 1992. С. 14.

⁷⁴ Ясинский Г. М. О процессуальной самостоятельности следователя // Советское государство и право. 1964. № 9. С. 64.

⁷⁵ 85 Вартанов А. Р. Проблемы процессуальной самостоятельности следователя по УПК РФ: Автореф. дис. ... канд. юрид. наук. Краснодар, 2012. С.8-9.

процессын бусад ажиллагааны тухай шийдвэр гаргах, мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах бүрэн эрх мөн гэж үзэж байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагааг хөтлөн явуулах, мөрдөн шалгах ажиллагааг болон процессын бусад ажиллагааны тухай шийдвэр гаргах мөрдөгчийн шууд үүргийг хуульчлан баталгаажуулах шаардлагатай юм.

А. Б. Соловьев, Н. А. Якубович нар процессын бие даасан байдал гэж “хуулиар тусгайлан эрх олгосон байгууллага, албан тушаалтнаас гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тохиолдол бүрд өөрийн эрх хэмжээний хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэх, гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлж, тэдэнд ял оногдуулахын тулд хуульд заасан бүхий л арга арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг өөртөө багтаасан чиг үүрэг мөн”⁷⁶ гэж тодорхойлжээ.

Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн⁷⁷ 1.4 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэгт “мөрдөгч гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг” хэлнэ. Хуульд мөрдөгчийн “бүрэн эрх”-ийн талаар дурдаагүй, зөвхөн “эрх бүхий” гэжээ. Жишээ нь Монгол Улсын шүүхийн тухай 2021 оны хуулийн⁷⁸ 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт шүүгчийн нийтлэг бүрэн эрхийг хуульчилсан байна. Прокурорын тухай Монгол Улсын 2017 оны хуулийн 15 дугаар зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих прокурорын бүрэн эрхийг тусгайлан хуульчилжээ.

Хууль зүйн шинжлэх ухаанд эрх хэмжээ (competence), бүрэн эрх (authority), объектив эрхийн талаар янз бүрийн тодорхойлолт өгчээ. “Компетенци” буюу “эрх хэмжээ” гэсэн ойлголт нь латины competere буюу зохицох, тохирох, олж авах гэсэн утгатай үгнээс гаралтай. Хууль зүйн шинжлэх ухааны толь бичгээс үзэхэд эрх хэмжээ нь “төрийн байгууллага, олон нийтийн байгууллага, ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллага албан тушаалтны эрх зүйн хэм хэмжээний актаар тогтоосон зорилт, чиг үүрэг, эрх, үүрэг (бүрэн эрх)-ийн цогц”⁷⁹ ажээ.

Хэл зүйн тайлбар толь бичигт бүрэн эрхийг “хэн нэгэнд албан ёсоор олгосон ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх эрх”⁸⁰ гэжээ. Эрх зүйн онолын шинжлэх ухаанд “бүрэн эрх” гэж энгийн нэг эрх биш, харин эрх, үүргийн нэгдэл талаас нь авч үзэж байна.

Эрүүгийн процессын шинжлэх ухаанд ч мөн адил “мөрдөгчийн бүрэн эрх” гэсэн нэр томъёог нэг мөр ойлгох нэгдсэн хандлага үгүй байна. Зарим эрдэмтэд энэ ойлголт, нэр томъёог явцуу утгаар нь эрүүгийн процесс дахь мөрдөгчийн эрхийн цогц⁸¹, харин нөгөө нэг хэсэг нь процессын эрх үүргийн цогц⁸² гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэм хэмжээнд дүгнэлт хийж үзэхэд мөрдөгч нь шүүх, прокурорын хамт тухайн хуулийн 1.6 дугаар зүйлд заасан эрүүгийн процессыг хэрэгжүүлж байгаа этгээд бөгөөд хуулийн 6.2 дахь хэсэгт зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулна.

Монгол Улсын эрүүгийн процессын зорилт нь “гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч

⁷⁶ Соловьев А.Б., Якубович Н.А. К вопросу о концепции правового обеспечения функции уголовного преследования // Современные проблемы уголовного права, процесса, криминалистики. М. Кемерово, 1996. С. 79 -80.

⁷⁷ Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // <https://www.legalinfo.mn/law/details/12694>

⁷⁸ Монгол Улсын шүүхийн тухай хууль // <https://www.legalinfo.mn/law/details/16047>

⁷⁹ Юридическая энциклопедия / под ред. М.Ю. Тихомирова. — М., 2001.

⁸⁰ Ожегов С.И., Шведова Н.Ю. Толковый словарь русского языка. — М., 1998. С 554.

⁸¹ 93 См.: Карев Д. С., Савгирова Н. М. Возбуждение и расследование уголовных дел. М., 1967. С. 25-26; Советский уголовный процесс/ Под. ред. Н. С. Алексеева, В. З. Лукашевича. Л., 1989. С. 214 и др.

⁸² См.: Власов А. А. Полномочия следователя в советском уголовном процессе: автореф. дисс. ... канд. юрид. наук. М., 1979. С.10; Эйсман А. А. Вопросы структуры и языка уголовно-процессуального закона // Вопросы борьбы с преступностью. Вып. 15. М., 1972. С. 86; Тихомирова Л. В., Тихомиров М. Ю. Юридическая энциклопедия. Изд. 5-е, доп. и перераб. /под ред. М. Ю. Тихомирова. — М., 2005. С. 654 и др.

гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино⁸³.

Эрүүгийн процессын зорилтоос үзэхэд хуульд зааснаар мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулах, процессын зохих шийдвэр гаргах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ “гэмт хэргийг шуурхай, бүрэн дүүрэн илрүүлэх” үүрэг хүлээнэ. Энэ үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд шүүх, прокурорын хяналт тавина. Бидний үзэж байгаагаар гэмт хэргийг шуурхай бүрэн дүүрэн илрүүлэхийн тулд мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой шийдвэр бие даан гаргах, өөрөөр хэлбэл, мөрдөгч нь эрүүгийн процессын хуулийн шаардлага, өөрт байгаа цаг хугацаа (мөрдөн шалгах ажиллагааны хугацаа), мэдээлэл (мэдээ, нотлох баримт гэх зэрэг), зохион байгуулалтын (процессын тодорхой ажиллагаа хийх шаардлага байгаа эсэх) нөөцөө идэвхтэй ашиглан бусад оролцогчдын тусламжгүйгээр шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Дээр дурдсанаас үзэхэд мөрдөгч нь мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэн бий болсон тохироог шийдвэрлэх арга замыг сонгох шаардлагатай болно. Хууль зүйн шинжлэх ухаанд тохироог шийдвэрлэх арга замын талаарх мөрдөгчийн сонголтыг “мөрдөгчийн дотоод итгэл”⁸⁴ гэсэн нэр томъёогоор тайлбарлана. Энэ нь бидний үзэж байгаагаар процессын бие даасан байдлын нэг илэрхийлэл мөн.

Судлаач эрдэмтдийн бүтээл, тэдний байр суурийг судалж үзэхэд С. Н. Хорьяковын “мөрдөгчийн процессын бие даасан байдал гэж тухайн албан тушаалтны процессын ажиллагаа ба процессын шийдвэрийг эрх зүйн зарчим, хүмүүнлэг чанарт (совесть) тулгуурлан өөрийн дотоод итгэлээр хэрэгжүүлэх боломжийг хангасан хэм хэмжээ”⁸⁵, Ю. В. Деришевын “төр, нийгмээс хүлээн зөвшөөрөх шийдвэрийг бусдаас хараат бус, бие даан батлан гаргах талаарх тодорхой субъектийн дотоод мөн чанар”⁸⁶ гэсэн үзэл санааг дэмжүүштэй байна.

Монгол Улсын эрүүгийн процессын хууль тогтоомжийн институционал байгууламж, эрүүгийн процессын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээдийн гүйцэтгэх чиг үүргээс харахад мөрдөгч нь өөрийн бүрэн эрхээ прокурор, шүүхээс гадуур хуулийн хэм хэмжээ, хүмүүнлэг чанарт үндэслэсэн өөрийн дотоод итгэлээрээ процессын шийдвэр гаргах бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байна.

Шүүх, прокурорын хяналт нь иргэдийн эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мөрдөгчөөс дураар авирлах, эрхээ хэтрүүлэхээс хамгаалах механизм мөн.

Мөрдөгчийн бие даасан байдал нь түүний хараат бус байх гэсэн ойлголттой нягт холбоотой.

А. П. Гуляев: “процессын захирах захирагдах ёс, хараа хяналтын дор байх шинж чанараас ургуулан” мөрдөгчийн хараат бус байдлыг үгүйсгэжээ⁸⁷. А. И. Михайлов эсрэгээр “эрүүгийн процесс дахь мөрдөгчийн хараат бус байдал нь түүний процессын бие даасан байдлыг хангах нэг нөхцөл”⁸⁸ хэмээжээ.

Бидний үзэж байгаагаар “хараат бус байх”, “процессын бие даасан байдал” гэсэн ойлголтууд нь төсөөтэй боловч, өөр өөр ойлголт юм. Хараат бус байх нь зөвхөн эрүүгийн процессын төдийгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт-удирдахуйн ухагдахуун мөн.

Мөрдөгчийн хараат бус байх нь дараах үндсэн хандлагаар илэрч байна: 1)төр, төрийн бус байгууллага, олон нийтийн ашиг сонирхлын нэгдэл, түүний төлөөлөгчдийн нөлөөнөөс ангид байх; 2)дээд шатны албан тушаалтны тодорхой хэрэг мөрдөн шалгах ажиллагаатай холбоотойгоор мөрдөгчид нөлөөлөх, дарамт шахалтаас ангид байх; 3) хяналт тавих, мөрдөн шалгах ажиллагаа

⁸³ Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //https://www.legalinfo.mn/law/details/12694

⁸⁴ Лазарев В. В. Социально-экономические аспекты применения права. Казань, 1982. С. 49–50; Васильев Л. М., Ярославский А. Б. Усмотрение следователя при расследовании преступлений и его влияние на установление истины по делу. Краснодар, 2000. С. 8;

⁸⁵ Хорьяков С. Н. Процессуальная самостоятельность следователя: автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2006. С. 9-10.

⁸⁶ Деришев Ю. В. Проблемы организации досудебного производства по УПК РФ. Омск, 2003. С. 91.

⁸⁷ Гуляев, А. П. Следователь в уголовном процессе. М., 1981. С. 99.

⁸⁸ Михайлов А. И. Проблема эффективности предварительного следствия: дисс. ... докт. юрид. наук. М., 1979. С. 66.

явуулахаас бусад байгууллага, албан тушаалтнаас хараат бус байх; 4) мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа мөрдөн шалгах бусад байгууллагаас хараат бус байх зэрэг.

Тухайн ойлголтын талаар тодорхой оновчтой тодорхойлолт үгүйлэгдэж байгаа учир энэ талаар хууль тогтоогч, хэрэглэгч, эрдэмтэн судлаачдын анхаарлыг хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Мөрдөгч нь хэнээс ч хараат бус байж л өөрийн процессын бие даасан байдлыг бодитой хэрэгжүүлэх боломжтой. Мөрдөгч нь ялангуяа зохион байгуулалт, удирдлагад шууд хамааралгүй, эсхүл эрүүгийн процессыг хэрэгжүүлэгч бус этгээдээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа, журам байнгын хараат байх нь процессын шийдвэр бие даан гаргахад туйлын хүндрэлтэй.

Эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээнд заасан хариуцлагаар хангагдана. Монгол Улсын эрүүгийн хуулийн Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэсэн 21 дүгээр бүлэгт мөрдөгчийн гэмт үйлдэлтэй холбоотой 21.1 (Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах); 21.5 (Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх); 21.6 (Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх); 21.9 (Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах); 21.12 (Эрүү шүүлт тулгах) зэрэг үйлдлүүдийг эрүүгийн хэрэгт тооцож ялтай болгожээ. Мөн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын холбогдох гэмт хэрэг ч үүнд хамааралтай.

Эрүүгийн процессын хуульд хамгийн эхний ээлжид прокурор шүүх мөрдөгчийн хууль бус үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааг таслан зогсоох зэрэг процессын хариуцлагыг заасан байна.

Дээр дурдсан хариуцлагаас гадна мөрдөгч хүлээх сахилгын хариуцлага ч мөн үүнд хамаатай.

Бидний үзэж байгаагаар эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдлыг төрөөс тодорхой баталгаажуулснаар мөрдөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн дээр эрүүгийн процессын зорилгыг бүрэн хангах боломжтой. Мөрдөгч нь хэргийн тодорхой нөхцөл байдлаас хамаарч гаднын ямар нэгэн нөлөөгүйгээр байцаалт (мэдүүлэг) авах, мөрдөн мөшгөх ажиллагааг төлөвлөх, явуулах шаардлага бий болно. Энэ талаар прокурор, мөрдөн шалгах байгууллагын дарга хэн ч байсан энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь ямар нэгэн зааварчилга өгөх эрхгүй. Хэрэв мөрдөгч албан үүрэгтээ хайнга идэвхгүй хандсан, материаллаг болон процессын зөрчил гаргасан бол мөрдөгчид хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно.

Хууль зүйн бүтээлүүдэд мөрдөгчийн бие даасан байдлыг мөрдөн шалгах ажиллагааны урьдчилсан нөхцөлд хамааруулсан тохиолдол⁸⁹ цөөнгүй ажиглагдана.

Энэ байр суурийг А. П. Гуляев и А. А. Клейн нар няцааж, мөрдөгчийн процессын бие даасан байдал нь мөрдөн мөшгөх ажиллагааны нэг урьдчилсан нөхцөл хэдий ч, эрүүгийн процессын нэг чухал институци, эрүүгийн процессын зорилгыг хангах нэг зарчим учраас түүнийг энэ явуу хүрээгээр ойлгох боломжгүй⁹⁰ гэжээ.

Мөн зарим эрдэмтэн судлаачид эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал нь эрүүгийн хэргийг мөрдөн байцаах явцад түүний хариуцлага, идэвх санаачилгыг хангахад зайлшгүй шаардлагатай нөхцөл⁹¹ гэжээ.

Доктор, профессор Б.Бат-Эрдэнэ: “ЭБШ ажиллагааны зарчим гэдэг нь Үндсэн хууль болон бусад хуулиудад бэхжиж тусгалаа олсон бөгөөд ЭБШ ажиллагааны ерөнхий журам, зохион байгуулалтыг тодорхойлж улмаар уг ажиллагааны мөн чанарыг илэрхийлж буй нийтлэг заалт мөн” хэмээн тодорхойлсон байна.

Эрх зүйн зарчим (principium-эхлэл, үндэс гэсэн утгатай латин гаралтай үг) нь төрийн хууль цаазын бодлогын мөн чанарыг илэрхийлэх, хууль цаазын шинжлэх ухааны хамгийн тэргүүлэх үзэл санааг агуулсан байх, хууль тогтоомжид хэм хэмжээний хэлбэрээр тусгагдсан байх, эрх зүйн хийдэл, зөрчилдөөн, алдаа (хуулийн цоорхой), түүнчлэн эрх зүйн зохицуулалтгүй орчныг (эрх зүйн

⁸⁹ Никандров В. И. Общие условия предварительного следствия в советском уголовном процессе: дисс.... канд. юрид. наук. М., 1973. С. 18, 71.

⁹⁰ Гуляев А. П. Указ. соч. С. 161.; Клейн А. А. Указ. соч. С. 37.

⁹¹ Квелидзе Г. А. Процессуальная самостоятельность и организация работы следователя// Социалистическая законность. 1969. № 11. С. 45.

вакум) арилгах үндсэн арга замыг чиглүүлэх зэрэг шинжтэй. Эрх зүйн зарчим нь: нэг талаас эрх зүйн зүй тогтлыг илэрхийлэх, нөгөө талаас эрх зүйн зохицуулалтын бүх хүрээнд үйлчилж байдаг хамгийн нийтлэг хэм хэмжээ байдаг⁹².

Францын алдарт эрдэмтэн Р.Давид эрх зүйн нийтлэг зарчмыг: хуулийн үндсэн томьёолол (хуульд бэхжигдсэн нийтлэг зарчмууд) ба хууль тогтоомжид тусгагдаагүй нийтлэг зарчмууд (эрх зүйн шударга ёсны тухай уламжлалт үзэл санаа)⁹³ гэж ангилан авч үзжээ. Эрх зүйн нийтлэг зарчим нь хуульд бэхжигдсэн эсэхээс үл хамааран эрх зүйн бие даасан эх сурвалж болно.

АНУ-ын эрдэмтэн Р.Дворкин зарчмууд нь хууль зүйн ач холбогдол бүхий асуудлыг шийдвэрлэх гол үндэслэл учраас эрх зүйн бүрэлдэхүүн нэг хэсэг мөн гэж үзсэн байна. Дворкин зарчим, стратеги болон стандарт гэсэн ойлголтыг авч үздэг. Стратеги нь нийгмийн ямар нэгэн үр дүнд хүрэх стандарт, зарчим нь ёс суртахууны шаардлагуудыг илэрхийлсэн стандарт юм. Тэр зарчмуудыг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт тулгуурлан тайлбарлана. Эрх зүйн хэм хэмжээ нь зан үйлийн хатуу загварыг тогтоодог бол зарчим нь тодорхой хэрэг хянан шийдвэрлэхэд биш, харин ерөнхий чиг баримжаа, үнэлэмжийн үндсийг зааж өгнө⁹⁴.

Эрүүгийн процессын зарим зарчим тэргүүлэх байр суурьтай байж бусад зарчмууд (мэтгэлцэх, эрүүгийн процессын ажиллагаа хууль ёсны байх) болон процессын зарим институтын агуулгыг илэрхийлсэн зарчмуудын агуулга, ач холбогдлыг тодорхойлно⁹⁵. Үүнээс үзэхэд эрүүгийн процессын зарчмууд нь эрүүгийн процессын бүх үе шатанд бус харин аль нэг шатанд, эсхүл тодорхой ажиллагааны явцад үйлчилнэ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал”-ын зарчмыг тунхаглажээ. Энэ хуульд зааснаар шүүгчийн бие даасан, хараат бус байдлын талаар зарчмын шаардлагуудыг хуульчилжээ.

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 3 дугаар зүйлд прокурорын үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлын зарчмыг тунхаглажээ.

Өмгөөллийн тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлд өмгөөллийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тунхагласан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална” гэжээ.

Бидний үзэж байгаагаар эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг үндсэн зарчим гэж үзэж байна. Хэдийгээр мөрдөгчийн бие даасан байдал нь ихэвчлэн шүүхийн өмнөх шатанд хэрэгжих хэдий ч түүний хэрэгжилт нь шүүн таслах ажиллагаанд нөлөөлөхгүй гэсэн үг биш. Мөрдөгч нь өөрийн дотоод итгэлээр шийдвэр гаргаж үйл ажиллагаа явуулах ёстой. Үүнээс үндэслэн мөрдөгч нь шүүгч буюу прокурорын зөвшөөрөл шаардахаас ч өмнө шийдвэрээ бие даан гаргасан байна.

Өнөөдөр мөрдөгчийн шийдвэр, чиг үүрэг нь прокуророос бүрэн хамааралтай нь процессын хууль тогтоомжид хийсэн судалгаанаас харагдаж байна.

Бидний хийсэн ажиглалтаар эрүүгийн процессын шинжлэх ухаан нь мөрдөгчийн эрүүгийн процессын чиг үүргийн талаар нэгдсэн зөв ойлголт төлөвшөөгүй байна. Энэ нь судалгааны тухайн объектын нарийн төвөгтэй байдалтай нягт холбоотой гэж үзэж болно.

Профессор С. А. Шейфер “чухамдаа процессын чиг үүрэгт процессын оролцогчийн эрх зүйн байдал илрэх төдийгүй, эсрэгээр эрх зүйн байдал нь аль нэг оролцогчийн процессын чиг үүргийг бүрдүүлж, эрүүгийн шүүн таслах ажиллагаанд түүний гүйцэтгэх үүргийг тодорхойлно” гэж бичжээ.

⁹² Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол., Уб.2017. дахь тал

⁹³ Давид Р. Основные правовые системы современности. И., 1999. С. 108-109.

⁹⁴ Дворкин Р. О правах всерьез. Перевод с английского М.Д.Лахути, Л.Б.Макеевой. М., 2004. С. 76.

⁹⁵ Уголовно-процессуальное право: учебник для бакалавриата и магистратуры / под общ. ред. В. М. Лебедева. 2-е изд. перераб. и доп. – М.: Издательство Юрайт, 2015. С. 117.

Зарим эрдэмтэн судлаачид “мөрдөгчийн үйл ажиллагаа дахь процессын чиг үүргийг яллах, өмгөөлөх, хэрэг шийдвэрлэх гэсэн гурав ангилах нь учир дутагдалтай”⁹⁶ гэж үзэж байна.

А. М. Ларин эрүүгийн процесст мөрдөгчийн гүйцэтгэх чиг үүргийг харьцангуй өргөжүүлсэн байна. Тэр бичихдээ “мөрдөгч нь хэргийн нөхцөл байдлыг шинжлэн судлах, эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, гэм хорыг арилгах, нөхөн төлөх, иргэний нэхэмжлэлийг няцаах, хэргийн оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, процессын удирдлага ба хэргийг шийдвэрлэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ”⁹⁷ гэжээ.

Бидний үзэж байгаагаар мөрдөгч гэмт хэргийг мөрдөн шалгах явцад шийдвэрлэх талаар дээд дурдсан эрдэмтдийн зорилтуудыг процессын нэг чиг үүрэгт нэгтгэн, гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг гэж тодорхойлж болохоор байна.

Манай орны эрдэмтэд эрүүгийн процессын оролцогчдын нийтлэг чиг үүргийг янз бүрээр авч үзсэн нь бий. Жишээ нь доктор Т. Оюунчимэг “Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны оролцогч дараах нийтлэг чиг үүрэгтэй:

1) мөрдөх; 2) яллах; 3) өмгөөлөх; 4) эрүүгийн хэрэг шийдвэрлэх.

Эдгээр чиг үүргийг оролцогчдод жигд хуваарилснаар эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчим хангагдана”⁹⁸ гэжээ.

Мөн энэ үзэл санааг Б.Лхагварачаа нар дэмжжээ⁹⁹. Мөн тэд “мөрдөх чиг үүрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад чиглэсэн үйл ажиллагааны чиглэл юм. Уг чиг үргийн хүрээнд мөрдөгчөөс гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэргийн яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх болон шалгах ажиллагаа хамаарна” гэж зөв зүйтэй тэмдэглэжээ.

Мөн судлаачид эрүүгийн процессын оролцогчид, түүний дотор мөрдөгчийн процессын чиг үүргийн талаар онолын болон практик судалгаа үгүйлэгдэж байна.

Бидний ажиглалтаар хууль зүйн эрдэмтэд бүтээлдээ мөрдөгчийн чиг үүргийг яллах чиг үүрэгт хамааруулан тодорхойлох, мөн мөрдөгчийн эрх зүйн байдал, хүлээх үүрэг, эдлэх эрхийн хүрээнд бүрхэгдүүлэх чиг хандлага ажиглагдаж байна.

Энэ асуудал нь өнөөдөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрлийг шүүх биш, харин прокурор ихэвчлэн өгөх эрх зүйн хуучин дэг журам ноёрхож байгаатай холбоотой. Манай орчин үеийн эрүүгийн процессын онол практикт ихэвчлэн мөрдөх, яллах, өмгөөлөх, эрүүгийн хэргийг шийдвэрлэх гэсэн гол гурван чиг үүргийг ялган авч үзэх чиг хандлага, ноёрхсон хэвээр байна. Бидний үзэж байгаагаар яллах, өмгөөлөх, эрүүгийн хэргийг шийдвэрлэх нь зөвхөн эрүүгийн процессын шүүхийн шатанд хэрэгжих чиг үүрэг гэдэгт л учир байгаа юм. Эдгээр дурдсан гурван гишүүнт чиг үүрэг нь зөвхөн шүүхийн шатанд ямар нэгэн саад тогторгүйгээр үйлчилж байна. Шүүхийн шатанд дахь мэтгэлцэх зарчмын хэрэгжилт нь энэ эдгээр чиг үүргийн хэрэгжилтээр хангагдана. Гэвч энэ схемийг мэтгэлцэх зарчмын хамт шүүхийн өмнө шатанд хэрэгжүүлэх оролдлого нь онол, практикийн хувьд ихээхэн зөрчилтэй байна.

Харин шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах буюу инквизиц чиг үүргийг бие даасан, хараат бус мөрдөгч хэрэгжүүлнэ. Мөрдөн шалгах чиг үүрэг нь онцгой, нийлмэл шинжтэй явц дундын гэж болохоор өвөрмөц, шинжтэй, яллах, өмгөөлөх, хэргийг шийдвэрлэх чиг үүргийн зарим шинжүүдийг өөртөө агуулсан байдаг. Профессор В.Т. Томин “мөрдөгч нь гэмт буруутныг олж тогтоон илчилснээр гэм буруугүй этгээдийг хамгаалдаг” гэжээ.

Бидний үзэж байгаагаар мөрдөн шалгах чиг үүрэг нь эрүүгийн процессын зорилгоор тодорхойлсон өндөр идэвхжүүлэлттэй, дээд эрхэм зорилготой гэж хэлж болно. Хэрэв энэ чиг

⁹⁶ О Даев В. Г. Процессуальные функции и принцип состязательности в уголовном судопроизводстве// Правоведение. 1974. № 1. С. 72; Гуляев А. П. Следователь в уголовном процессе. М., 1981. С. 11; Головкин Л. В. Новый УПК Российской Федерации в контексте сравнительного уголовно-процессуального права // Государство и право. 2002. № 5. С. 52.

⁹⁷ Ларин А. М. Расследование уголовного дела: процессуальные функции. М. : Юридическая литература, 2006. С. 12.

⁹⁸ Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. УБ.,2020.39-40 дэх тал.

⁹⁹ Эрүүгийн процессын эрх зүй. Сурах бичиг. Ерөнхий ба тусгай анги. Хамтын бүтээл. УБ.,2021. 86 дахь тал.

үүргийн оронд яллах, өмгөөлөх чиг үүргээр орлуулах гэж үзвэл дээд зорилго мөн адил үгүй болно. Яллах, өмгөөлөх чиг үүрэгч мөн өөрийн гэсэн дээд эрхэм зорилго, идэвхжүүлэлттэй. Нөгөө талаас дурдсан мэтгэлцэх зарчмаас урган гарсан үндсэн чиг үүргийн тогтолцоонд өмгөөлөх чиг үүргийн мотивацийн эх сурвалж нь харьцангуй өөр шинжтэй, ихэвчлэн өмгөөлөгчийн хөлс, эдийн засгийн ашиг сонирхолд тулгуурладаг нь нууц биш. Мөрдөгч нь эрүүгийн процесст төрийн албан үүргээ гүйцэтгэж байгаа бол өмгөөлөгч нь хувийн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх байдлаар тайлбарлаж болох юм. Өнөө үед шүүхээс өмнөх шатанд мөрдөн шалгах чиг үүргийг дэлхийн улс орнууд “инквизиц” чиг үүрэг, мөрдөгчийг “инквизитор”-той адилтган нэрлэх нь цөөнгүй байна. “Инквизитор” (лат. Inquisitor — мөрдөгч, эрүүлч) гэх нэр томъёог анх Римийн хожмын эзэнт гүрний хуульчид бодож олсон төдийгүй, XII зууны үед римийн эрх зүйг дахин судалж, сэргээх замаар дундад зууны үед энэ нэр томъёог дахин хэрэглэх болжээ. Анх Римийн эзэн хаан 1382 онд инквизитор гэсэн албан тушаалыг бий болгож, шашны манихейн урсгалын төлөөлөгчдийг илрүүлж шүүх хэргийг хариуцуулсан түүхтэй байна. Хожим инквизитор нь инквизицийн шүүгч гэж нэрлэгдэх болсон. Венецийн бүгд найрамдах улсад анх төрийн инквизитор (Inquisitori di stato) буюу төрийн мөрдөгч бий болжээ¹⁰⁰.

Манай эрүүгийн процессын хууль тогтоомжид мөрдөгчийн эрх зүйн байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг нарийвчлан тогтоогоогүйгээс мөрдөгч нь “ямар шалгуур, шаардлага хангасан хүн байж болох талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Эрүүгийн процессын Монгол Улсын тухай хуульд зааснаар мөрдөгч нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ихэвчлэн прокурорын зөвшөөрөлгүйгээр явах ямар ч боломжгүй байна.

Байнга бусад этгээдийн зөвшөөрөл, үзэл бодол, нотолгооны хандах нь мөрдөгчөөс өөрийн дотоод итгэлээр процессын шийдвэр гаргах боломжгүй байна.

Энэ бүхэн нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд болон мөрдөгчөөс өөрийн идэвх санаачилгаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зорилтыг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг процессын хувьд бэхжүүлж, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгамдаж байна.

Хэдийгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “мөрдөгч гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг хэлнэ” гэж заасан боловч практикт ажиллаж байгаа олон мөрдөгч өөрийн зорилго, чиг үүргээ яллах талын гэж хариулж байна. Бидний хийсэн судалгаагаар мөрдөгч нь мөрдөн шалгах чиг үүрэгтэй гэж 33% нь, харин яллах чиг үүрэгтэй гэж 66.7% нь хариулжээ.

Цаашид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хяналтын шатанд мөрдөгчийн үйл ажиллагааны баталгааг хангахгүй бол мөрдөгчийн энэ мэргэшлийн нэр хүнд олон нийтийн дунд унах, хууль хэрэгжүүлэгч энэ этгээдийн чиг үүрэг яллах тал руу хэлбийх, прокурорын хэлсэн үг үйлдлийг дагагч болох төлөв ажиглагдаж байна.

Үүнээс гарахын тулд ЭХХШХ-ийн прокурорын зөвшөөрөл шаардаж буй хүний үндсэн хуулийн эрх хөндөж буй ажиллагаанд шүүхийн зөвшөөрөл олгох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь прокурорын хяналтын үүргийг бууруулахгүй, харин мөрдөгчийн процессын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлж, тэдний ажлын үр нөлөөг дээшлүүлэх болно.

Урьдчилсан үнэлэлт: Хууль тогтоогч Цагдаагийн албаны тухай хууль болон бусад мөрдөн шалгах байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуульд мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн зарчмын шинжтэй хэм хэмжээг тусгаагүй байна.

Хууль тогтоомжийн энэ харьцуулалтаас үзэхэд эрүүгийн хэрэг хянан шалгах гол ачааллыг үүрч байгаа мөрдөгчийн бие даасан, хараат бус байх зарчим, түүний зохих шаардлагууд үгүйлэгдэж байна.

¹⁰⁰ Энциклопедический Словарь Ф.А.Брокгауза и И.А.Ефрона (В 86 томах с иллюстрациями и дополнительными материалами) // <http://www.vehi.net/brokgauz/index.html>

Мөрдөгч нь шийдвэрээ хуульд нийцүүлэн хараат бусаар гаргах, мөрдөгч шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, түүний хуульд заасан үндэслэл журмын дагуу гаргасан шийдвэрийг хүн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлэх зэрэг хараат бус бие даасан байх зарчим, түүний шаардлагууд үгүйлэгдэж байна.

Дүгнэлт. Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эрүүгийн процессын онолын эрдэмтэд мөрдөгчийн бие даасан, хараат бус байдлыг тэдгээрийн эрх зүйн байдал; процессын эрх, үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрх; эрүүгийн процессын ажиллагаанд тэдний гүйцэтгэх чиг үүрэг, байр суурь; процессын эрх зүйн зарчим талаас нь авч үзэх хандлага зонхилж байна.

2. Монгол Улсын эрүүгийн процессын бүтээл, хууль тогтоомжид мөрдөгчийн бие даасан байдлын тухай нэг ч тодорхойлолт өгөөгүй байна. Энэ нөхцөл байдал нь эрүүгийн процессын шинжлэх ухаанд тухайн ойлголтын талаар үзэл санаа нэгдмэл бус байгааг харуулж байна. Зарим судлаачид мөрдөгчийн шийдвэр, үйл ажиллагаанд тавих хэт их хяналтын шалтгаанаар тухайн бие даасан байдлыг үгүйсгэх ч хандлага ажиглагдаж байна.

3. Мөрдөгчийн бие даасан байдал нь Монгол Улсын эрүүгийн процессын хуульд шүүх, прокурорын зөвшөөрөл шаардахаас бусад мөрдөн шалгах болон процессын бусад ажиллагааны тухай шийдвэр гаргах, мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах бүрэн эрх мөн гэж үзэх бүрэн үндэстэй байна.

4. Мөрдөгчийн “хараат бус байх”, “процессын бие даасан байдал” гэсэн ойлголтууд нь төсөөтэй боловч, өөр өөр ойлголт. Хараат бус байх нь зөвхөн эрүүгийн процессын төдийгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт-удирдахуйн ухагдахуун төдийгүй, “мөрдөгчийн процессын хараат бус байдал нь түүний процессын бие даасан байдлыг хангах нэг нөхцөл” мөн.

5. Мөрдөгч нь шийдвэрээ хуульд нийцүүлэн хараат бусаар гаргах, мөрдөгч шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, түүний хуульд заасан үндэслэл журмын дагуу гаргасан шийдвэрийг хүн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлэх зэрэг хараат бус бие даасан байх зарчим, түүний шаардлагууд үгүйлэгдэж байна.

Санал. Бид хийсэн судалгаанд үндэслэн эрүүгийн процесс дахь мөрдөгчийн бие даасан байдлыг зарчмын хувьд дараах байдлаар томъёолох нь зүйтэй гэж үзэж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуульд: “6.2¹ дугаар зүйл. Мөрдөгчийн бие даасан хараат бус байх” гэсэн зүйлийг шинээр дараах агуулгатай тусгах саналтай байна. Үүнд:

1. Мөрдөгчийн шийдвэр, үйл ажиллагаа нь бие даасан хараат бус байна.

2. Мөрдөгч бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахад нь шүүгч, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга нь хуульд заасан үндэслэл журам зөрчиж хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, хууль бус шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

3. Мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагаанд хүн, хуулийн этгээд, албан тушаалтан хууль бусаар нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

4. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан мөрдөгчийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

5. Хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, мөрдөн шалгах мөрдөгчдийн багт аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон тохиолдол бүрийг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө”.

Үндэслэл: Энэхүү заалт нь шүүгч, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга болон бусад албан тушаалтан, нөлөө бүхий этгээдийн зүгээс мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагаанд хуульд заасан үндэслэл журмаас гадуур хөндлөнгөөс оролцох, тухайн хэрэгтэй холбоотойгоор хууль бус шинжтэй заавар, чиглэл өгөх, удирдамжаар хангах, мөрдөгчид тодорхой

хэргийг нэр заан хуваарилах зэрэг сөрөг үзэгдлүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой болно. Нөгөө талаас мөрдөгчийн бие даасан, хараат бус байдлын баталгаа болно.

Ашигласан ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1
2. Прокурорын тухай (Шинэчилсэн найруулга) Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24
3. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23
5. П.Батбаатар. Гэрч хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. -Уб., 2019.
6. Будников В. Л., Волколупов Е. В. Проблема процессуальной самостоятельности следователя как субъекта доказывания по уголовному делу // Современные проблемы уголовно-процессуального доказывания. Сборник статей. Волгоград: Изд-во ВолГУ, 2000.
7. Вартанов А. Р. Проблемы процессуальной самостоятельности следователя по УПК РФ: Автореф. дис. ... канд. юрид. наук. Краснодар, 2012.
8. Хорьяков С. Н. Процессуальная самостоятельность следователя: дисс. ... канд. юрид. наук. - М, 2006.
9. Грохольский К. В. Понятие и сущность процессуальной самостоятельности следователя // Ученые записки: Сборник научных трудов юридического факультета Оренбургского государственного университета. -Оренбург, 2004. Выпуск 1.
10. Ясинский Г. М. О процессуальной самостоятельности следователя // Советское государство и право. 1964. № 9.
11. Клейн А. А. Правовые и организационные аспекты процессуальной самостоятельности и независимости следователя органов внутренних дел : дисс. ... канд. юрид. наук. -М., 1992.
12. Кулагин Н. И. В защиту прав и законных интересов следователя // Права человека и правоохранительная деятельность. Волгоград, 1995.
13. Нямсүрэн, Ч. Шүүхийн алдаг тандахуй//Шударга ёсны хэмжүүр.-Уб.,2018.№02(022)
14. Нямсүрэн, Ч. Шүүхийн алдаг тандахуй//Шударга ёсны хэмжүүр. 2018.12. №2/022.

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫГ, ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНААС ЯЛГАХ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА
ACCEPT CRIMINAL RESPONSIBILITY FOR PERSONS WHO COMMIT
DOMESTIC VIOLENCE, DISTINCTION FROM DISPUTE RESOLUTION,
AND WITH REQUIREMENT.**

Б.Батзаяа
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч
Batzaya.B (Police Major)
*Senior Teacher, Criminal Procedure Law Department,
School of Police, University of Internal Affairs*

Хураангуй: Гэр бүлийн эрх зүй нь бусад нийгмийн харилцаан дундаас өвөрмөц, өөрийн гэсэн онцлогтой салбар эрх зүй билээ. Өөрөөр хэлбэл, гэр бүл нь оюун санаа болон материаллаг хэрэгцээ хосолсон сэтгэл зүй, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүй зэрэг харилцааг өөртөө агуулах нарийн нийлмэл тогтолцоотой байдаг нэг ёсны цогц харилцааг бүрдүүлж байдаг¹⁰¹. Гэр бүлийн харилцаа хоёр хүний хоорондын сайн дурын үндсэн дээр үүсдэг ч нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл их үйлдэгдэж, нэг нь нөгөөгөө сэтгэл санааны дарамтанд байлгаж, санхүүгээр шахан боож байгаа нь өөрөө хүний эрхийн асуудал ноцтой зөрчигдөж байгаагын илрэл билээ. Үүнийг зохицуулахаар эрүүгийн хуульд эрх зүйн зохицуулалт орсон ч энэ нь зөрчлөөс ялгагдахгүй байгаа тул холбогдогч шүүхийн шатанд эрүүгийн хариуцлага хүлээхгүй байгаа нь энэ асуудлыг хөндөх болсон шалтгаан юм.

Abstract: Family law is a branch of law that is unique and has its own characteristics among other social relations. In other words, the family forms a unified and complex relationship that has a complex system containing psychological, moral, economic, and legal relationships that combine spiritual and material needs. Family relationships are formed on a voluntary basis between two people, but there is a lot of domestic violence in society, where one person keeps the other under emotional pressure and squeezes them with money, which is a sign of serious human rights violations. Although there are legal regulations in the criminal law to regulate this, it is not distinguished from a violation, so there is no criminal liability at the relevant court level, which is the reason for raising this issue.

Түлхүүр үгс: Гэр бүл, хүчирхийлэл, хамтран амьдрагч, зөрчигдөж буй эрх, хууль

Key words: Family, violence, cohabitation, violated rights and laws

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт

Монгол Улс гэр бүлийн хүчирхийллийн дийлэнх тохиолдлыг зөрчлийн хэмжээнд авч үзэж байсныг өөрчилж гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах зэрэг хүчирхийллийн зарим ноцтой үйлдлийг гэмт хэрэгт тооцон ял шийтгэх зохицуулалтыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн хуульд тусгаж, гэмт этгээдийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, мөн хугацааны хорих ялаар шийтгэхээр хуульчилсан нь дэвшилттэй алхам болсон. Мөн Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар мэдээлээгүй болон түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, өөр зориулалтаар ашигласан, хамгаалах байрны журмыг зөрчиж нэвтэрсэн этгээдэд хариуцлага тооцох, гэр бүлийн хүчирхийллийн зарим тохиолдлыг зөрчилд тооцохоор заажээ.

¹⁰¹ А.Батбаатар, “Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал”, 2021 он 9-р тал

2000-иад оны эхээр гэр бүлийн хүчирхийлэл байдаг л мэт нийгэм хүлээж авдаг байсан нь хаалттай хаалганы цаана хэн нэгний зандрах, орилох нөгөө нэгний уйлах, гаслах чимээнд нийтээрээ дөжирсөн гэж ойлгож болохоор.

Энэ бүхэн эцгийн эрхт ёсоос өвлөгдөн ирсэн байж болох юм. Учир нь бидний мэдэх зарим нэг зүйр үгс уг хүчирхийллийг байх л зүйл мэтээр бидний сэтгэл зүйд суулгаж өсгөсөн. Жишээ нь сайн эхнэрийг сардаа нэг зод, зодвол барцад арилна гэх мэтээр шалтаг гаргаж бие махбодын хүчирхийлэл үйлдэж ирсэн. Тэгвэл энэ нь ганц бие махбодиор зогсохгүй дараах дөрвөн хэлбэрээр хамтрагчийнхаа эрхэд халддаг байна:

1. бие махбодын хүчирхийлэл;
2. сэтгэл санааны хүчирхийлэл;
3. эдийн засгийн хүчирхийлэл;
4. бэлгийн хүчирхийлэл.¹⁰²

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч эрх мэдлээр давамгайлж, бие болон сэтгэл санааны хувьд доромжлон, дарамтлах эд хөрөнгийн гэм хор учруулж байгаа зан үйлийг хэлдэг.¹⁰³ Гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан нь эрх мэдлийн тэнцвэртэй бус харилцаа. Энэ үйлдэл нь хүчирхийлэгч талын гэм буруугын санаатай сэдэл, зорилготойгоор үйлдэгдэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль¹⁰⁴ болоод гэр бүлийн тухай хуульд заасан гишүүдийн тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаагаараа эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох юм. НҮБ-аас баталсан хүний эрхийн түгээмэл Тунхаглалын¹⁰⁵ гуравдугаар зүйлд “хүн бүр ... эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” , мөн МУ-н Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дах хэсэгт “...халдашгүй чөлөөтэй байх эрхтэй...”¹⁰⁶ гэж хувь хүний өөрийнх нь жам ёсны халдаж үл болох эрхийг баталгаажуулсан байдаг. Энэхүү жам ёсны эрх нь гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрээр ноцтой зөрчигдөж байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс тэдгээрийг төрийн зүгээс хамгаалах шаардлагатай байгааг харуулсан юм.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай цаг алдалгүй цагдаагийн байгууллагад хандаагүйгээс болж өмнөх хэргүүдийг нотлох баримт устаж үгүй болох, зарим ул мөр тодорхой хугацааны дараа арилах, зарим тохиолдолд хүчирхийллийг гэрчлэх хүнгүй болох зэргээр мөрдөн шалгах ажиллагааг түвэгтэй болгодог. Зарим иргэдийн хувьд гэмт хэрэг үйлдэгдсэн тухай мэдээлэл өгөх үүрэг, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх буюу эрх, үүргийн хоорондын ялгаа заагийг ойлгоогүйгээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа талаар мэдсэн ч зохих байгууллагад ханддаггүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хохирогч, түүний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүс, хөршүүд, эмнэлгийн байгууллагын ажилтан, хүчирхийллийн хохирогчид тусламж, дэмжлэг, үзүүлсэн болон, хамгаалах байраар үйлчилсэн төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэхээс гадна тохиолдлын чанартай үл таних хүмүүс өгөх нь ч бий. Мөн цагдаагийн байгууллагын тухайд мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс ч олж авах боломжтой.

Анхны мэдээллийн нэг хэлбэр нь дуудлагаар очсон алба хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэх магадлалтай эсэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтоохын тулд аюулын зэргийн үнэлгээг зайлшгүй хийх шаардлагатай байна.

¹⁰² Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, 2016., 6 дугаар зүйл

¹⁰³ А.Батбаатар, “Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал” , 2021 ., 206 дах тал

¹⁰⁴ ҮХ-ийн 16 дугаар зүйлийн 11./ Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ/.

¹⁰⁵ Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл, 2012., 7 дах тал

¹⁰⁶ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх, 1999., 50 дах тал

Аюулын зэргийн үнэлгээг оновчтой асуултаар богино хугацаанд хийх, алба хаагчдад ойлгомжтой, ашиглахад хялбар байдлаар найруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэж ХЗДХ-ийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, 2 дугаар хавсралтаар “Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэлийн загвар”-ыг тус тус баталсан байна.

Аюулын зэргийн үнэлгээ гэдэг нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах

Статистик үзүүлэлт		2017 Он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	
Аюулын үнэлгээ хийгдсэн эсэх	Улсын дүн	-	796	894	1,080	1,489	1,663	
	УБ	-	418	437	566	845	863	
Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн	Улсын дүн	1,100	796	893	1,082	1,489	1,664	
	УБ	642	418	437	567	845	864	
Ү н э	Бие	Улсын дүн	802	547	565	784	1,082	1,395

эрсдэлийг урьдчилан таамаглахад чиглэсэн арга хэрэгсэл юм. Аюулын зэргийн үнэлгээ нь аюулгүй байдлын хамгаалатын арга хэмжээг шуурхай авах болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх үндэслэл болно¹⁰⁷. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 111 буюу (9,8%) нь Эрүүгийн тухай хуулийн 11.7 дугаар зүйлээр зүйлчлэгдсэн байна.¹⁰⁸

¹⁰⁷ ХЗДХС-ын 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар батлагдсан Аюулын зэргийн үнэлгээ хийх журмын 1.3, 1.4 дэх хэсэг

¹⁰⁸ ҮСХ, “Гэр бүлийн хүчирхийллийн статистик 2020”, 2021., 28 дах тал

	махбодын	УБ	430	233	205	360	531	693
	Сэтгэл санааны	Улсын дүн	314	163	248	196	275	317
		УБ	142	46	98	58	78	103
	Бэлгийн	Улсын дүн	31	16	28	31	79	78
		УБ	8	2	7	8	32	31
	Эдийн засгийн	Улсын дүн	8	4	3	4	6	7
		УБ	3	2	3	2	2	4

Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж буй байдал

Зөрчлийн тухай хууль	Эрүүгийн хууль
...Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 1.зодсон; 2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: 1.1.зодсон; 1.2.харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; 2.2.асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; 2.3.таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуульд зааснаар гэр бүлийн хамаарал бүхий хүнийг **байнга** сэтгэл санаа, бие махбодь, бэлгийн, эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байна. Тэгвэл байнга гэдэг үгийг юу гэж ойлгох вэ? Байнга гэж удаа дараа хохирогчийн эрхэд халдсан идэвхитэй үйлдэлийг ойлгоно. Эрүүгийн хуульд 3 удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заажээ. Тэгэхээр энэ нөхцөлд эрүүгийн журмаар шийдвэрлэгдэх хүртэл хохирогч гурван удаа эрх нь хөндөгдөхийг хүлээн зөвшөөрөх ёстой юу? Эрүүгийн хууль болон зөрчлийн тухай хуулинд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудлын ялгаа заагыг зөв томъёолж чадаагүйн улмаас мөрдөгч, прокурор шүүхийн зүгээс хуулийг ялгаатай тайлбарлан хэрэглэж байна. Энэ нь нөгөө талаас эрх зүйн хийдэл байна гэж үзэх үндэслэл байна.

¹⁰⁹Практикт холбогдогчид зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага тооцсон ч холбогдогч давтан зөрчил үйлдэх нь элбэг байна. Энэ гэмт хэрэгт өртөж буй хүмүүсийн дийлэнх нь эхнэр, хамтран амьдрагч гээд эмэгтэй хүмүүс байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлыг прокурор хариуцах ёстой. ¹¹⁰

¹⁰⁹<http://legaldata.mn/b/785>

¹¹⁰ Прокурорын тухай хууль, 2017., 5 дугаар зүйл

Эрүүгийн хэргийн анхан шатны журмаар шийдвэрлэгдэж буй байдал¹¹¹

2017	51
2018	106
2019	165
2020	84
2021	93
2022	106

Шүүхийн шатанд орж шийдвэрлүүлсэн хэрэг маргааны тухайд дандаа давхар зүйлчлэлээр орж шийдвэрлүүлж байгаа нь 102 тусгай дугаарт орж ирж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага мэдээллээс эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр орж шийдвэрлэгдсэн тоо харьцангуй бага байгаа нь хуулийн байгууллагын зүгээс хуулийг ялгаатай хэрэглэж байгаа нь харагдаж байна. Дийлэнх нь Хүний биед хүнд хохирол санаатай учруулах Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1., Хүний биед хөнгөн хохирол санаатай учруулах Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6.- гаар давхар зүйлчлэгдэж байна.

Практикт удаа дараа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж давтамж нь 3 удаа болсон тохиолдолд эрүүгийн журмаар шийдвэрлүүлэхгээд холбогдогчийг зөрчлийн хэргээс эрүүгийн хэрэг лүү явуулахад авдаггүй хэрэг үүсдэггүй зэрэг тохиолдол их байна. Энэ нь мэдээж тухайн хохирогчийг илүү ихээр эрх нь зөрчигдөөд, амь нас, эрүүл мэндэд нь асар их хохирол учирсны дараа л шүүх түүнийг хүлээж авах байх гэсэн үг. Гэвч эхнэр, хүүхэд, хамтран амьдрагч нар гэр бүлийн хүчирхийллийн нэг удаагийн үйлдлээс болж гэмт хэрэгт өөрсдөө холбогдох нь цөөнгүй. Ийм нөхцөл байдалд хуулийн байгууллага тодорхой арга хэмжээ аваагүйн буруугаас ч болсныг үгүйсгэхгүй.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудал

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийг мөрдөн шалгах явцад хамгийн нийтлэг тохиолддог хүндрэл бэрхшээл нь хохирогч гомдлоосоо татгалзах, анх өгсөн мэдүүлгээсээ буцах, гэр бүлийн хүчирхийллийг “Байнга” үйлдсэн гэдгийг нотлоход төвөгтэй байдаг. Хохирогч нарын хувьд хүчирхийлэл үйлдэгч дахин ийм үйлдэл хийхгүй гэж амласан, гомдлоо буцаахыг ятгасан, айлгаж сүрдүүлсэн, хоорондоо эвлэрсэн, гэр бүлийн эдийн засаг уналтад орох, салахаас айсан, хүүхдээ өнчрүүлмээргүй байна гэх зэрэг шалтгаанаар гомдлоо буцаах хүсэлт гаргадаг байна.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь гэрч, хохирогч болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдод сөргөөр нөлөө үзүүлснээр тэд хуулийн байгууллагатай хамтран ажиллахаас татгалзах болсон нь хэргийн мөрдөн шалгах ажиллагаа болон гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг сулруулах нэг хүчин зүйл болсныг тэмдэглэх хэрэгтэй. Гэмт этгээдүүд гэрч, хохирогчид шан харамж өгч өөртөө татах, заналхийлэх, сүрдүүлэх зарим тохиолдолд амь насыг нь хохироох, шууд хүч хэрэглэх зэрэг янз бүрийн арга замаар нөлөөлөх нь хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах, гэрчийн мэдүүлэг өгөх шударга хүмүүс гэмт халдлагын золиос болох нь байнгын шахуу үзэгдэл болсон. Чухамдаа энэ нөхцөл байдал нь гэрч, хохирогч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид хуулийн байгууллагуудтай хамтран ажиллахаас татгалзах үндсэн шалтгаан болж байна.¹¹²

Гэрч, хохирогчид нөлөөлөх тохиолдол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэлээдгүй гардаг боловч энэ нь ихэвчлэн далд хэлбэртэй байна. Учир нь гэрч, хохирогч гэнэт мэдүүлгээ өөрчлөх тохиолдол нэлээд байдаг нь ямар нэг байдлаар нөлөөнд автсантай холбоотой гэж

¹¹¹ <http://shuukh.mn>

¹¹² П.Батбаатар. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал. УБ., 2021 он.

үздэг байна. Мөн ихэвчлэн хэргийг хянан шийдвэрлэх үүрэг бүхий албан хаагчид хохирогчоо анхаарсан байдлаар үйл ажиллагаагаа явуулаагүйгээс шалтгаалж дахин хохироход хүргэж байдаг.¹¹³

Гэр бүлийн аль нэг гишүүн гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох, бусад гишүүдийг эрхшээлдээ байлгах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргүүдийг судлан үзэхэд сэтгэл зүйн хүчирхийлэл нь биеийн хүчирхийллээс илүү шаналгаатай, илүү урт хугацаанд үйлчилдэг байна.

Статистик үзүүлэлт		2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Хугацаа	0-1 жил	743	538	575	791	1,093	1,329
	1-3 жил	142	139	167	143	206	189
	3-5 жил	25	25	37	26	33	20
	5-8 жил	10	13	9	9	7	8
	8-с дээш жил	25	6	12	10	12	10
Давтамж	Жилд 1-2	746	613	688	864	1,193	1,376
	Улиралд 1-2	108	88	109	95	127	126
	Сард 1-2	45	49	42	38	38	52
	14 хоног тутам	13	8	8	10	12	3
	7 хоног тутам	3	5	9	6	4	5
	3 хоног тутам	-	1	1	-	1	-
	Байнга	31	16	15	5	11	8

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгддэг гэмт хэргүүд нь ихэвчлэн хүнд хор уршиг учруулсан, эсхүл тийм хор уршиг учруулж болох нөхцөл байдал бүрдсэн буюу хожуу үедээ хууль хяналтын байгууллагад ханддаг. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үргэлжилсэн давтамжаар нь авч үзэхэд сүүлийн 3 жилийн дунджаар жилд 0-1 удаа 1,145, улиралд 1-2 удаа 116, сард 1 удаа 47, 14 хоног тутам 9, 7 хоног тутам 6, 3 хоног тутам 1, байнга 11 тохиолдол байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч хэргийг анх удаа үйлдэхэд нь хууль хяналтын байгууллагад ханддаггүй болох нь харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээтэй, нийгмийн бүх давхарга, салбарт нэгэн зэрэг чиглэсэн, хүний зан үйлд нөлөөлөх төрөл бүрийн арга хэрэгслийн тусламжтайгаар хэрэгжүүлж байдгаас хамаарч түүнийг хэрэгжүүлэх чиглэлийг олон шалгуураар төрөлжүүлэн ангилахад хүргэдэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тогтоох нь чухам юунаас, ямар үндэслэлээр эхлэх, ямар хүрээнд зохион байгуулах, ямар арга, хүч хэрэгслийг ашиглах зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Дүгнэлт, санал

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад доорх гурван түвшинд анхаарал хандуулах шаардлагатай хэмээн үзэж байна. Тодруулбал, хувь хүний түвшинд гэр бүл төлөвлөлт, амьдралын арга ухаанд суралцах, ёс суртахуун, зөв дадал, зан үйлд суралцах, өөрийн үнэт зүйл, зорилгоо төлөвлөх, стресс менежментийн талаар мэдлэгтэй болох, бусдыг хайрлах, хувь хүний зохион байгуулалтаа нэмэгдүүлэх шаардлагатай. Иймд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг,

¹¹³ Гэмт хэргийн болон хүчирхийллийн хохирогчдод зориулсан шударга ёсны зарчмуудыг хэрэглэх НҮБ-ын гарын авлага. 1999 он.

гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагаар дамжуулан тасралтгүй хэлбэрээр явуулах. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд түгээмэл тулгарч байгаа нэг асуудал бол гэрч хохирогчийг хамгаалах тухай юм.

Гэрч хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал эрүүгийн эрх зүйн практикт гарсаар байна. Үүний үр дагавар нь гэрч, хохирогч нөлөөнд орж мэдүүлэх өгөхгүй байх эсвэл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх, амиа хорлох тохиолдол¹¹⁴ гарч байна. 2014-2019 оны эхний хагас жилд гэрч, хохирогчийг хамгаалах албанаас 24 гэрч, 205 хохирогч, 95 хамаарал бүхий этгээд, 5 мэдээлэгч, 12 шүүгч, 8 прокурорыг хамгаалтад авсан байна. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар эрүүгийн хэрэг гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд болон гэмт хэрэг илрүүлэхэд үнэтэй мэдээлэл өгч, тусалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэгт мэдүүлэг өгөөгүй хүний аюулгүй байдлыг ханган ажиллах зохицуулалттай боловч сүүлийн үед олны анхаарал татсан хэргийг хянаж байгаа прокурор, шүүж байгаа шүүгч нар хамгаалалтад орох хүсэлт гарган Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрийн дагуу, гэрч, хохирогчийг хамгаалах хэлтчийн албан хаагчид прокурор, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж байгаа нь хуулиар зохицуулаагүй үйл ажиллагаа явуулж байна гэж үзэхээр байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогч болон тэдний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд халдах, халдахаар завдсан, заналхийлсэн тохиолдол нэлээдгүй байгаа нь манай улсад гэрч, хохирогчийг хамгаалах нэгдсэн тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий болсон нь харагдаж байна. Тиймээс гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох, гадаад орны сайн туршлагыг өөрийн хөрсөнд буулгах, тэдэнтэй хамран ажиллах, хохирлын үнэлгээг зөв, тооцоолох, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих, хүчирхийлэл үйлдсэн этгээдэд шийтгэл ногдуулах ажиллагаа, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Харин Зөрчлийн тухай хуулийн тухайд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж, 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулдаг. Баривчлах шийтгэлийг тэнсэх тухай ойлголт хуулинд байхгүй учир шийтгэлээ биечлэн эдэлж байна. Гэтэл Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийг “Байнга” үйлдсэн эрүүгийн хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой байгаа нь давтагдаж даамжирсан үйлдэлд хариуцлагын үр нөлөөг бууруулж, гэмт этгээдэд ял завших боломж олгосон гэж үзэж болохоор байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн шинжийг “...Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...” гэж хуульчилсан байдаг.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар тусгай ангийн арван нэгдүгээр бүлгийг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг гэж хуульчилсан байдаг ба гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн үндсэн шинжид байх “...Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан...” гэсэн хоёр шинж нь энэхүү бүлгийн объектын шинжийг хангаж байх бөгөөд 11.7 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэгдэн байгаа хэргүүдийн диалэнх нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар шалгагдаж хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Харин энэ хэсгийн 3 дахь заалтад заасан “...хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол...” гэсэн диспозиц шинж нь “Хүний эрүүл мэндийн

¹¹⁴ Судалгааны тайлан. Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал. УБ., 2010 он.

халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн объектын шинжийг хангахгүй байна гэж үзэж байна. Энэхүү эрх зүйн зохицуулалтын улмаас уг зүйл хэсгээр хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болж буй нэг шалтгаан болж байна гэж үзэж байна. Мөн “Тарчлаах”¹¹⁵, “харгис хэрцгий харьцах” гэх мэт үгс нь өөрөө “байнга” гэсэн шинжийг агуулдаг тул эдгээр үйлдлийг байнга, давтан үйлдсэн байхыг шаардахгүй гэж Эрүүгийн хуульд тусгах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

➤ Хууль, эрх зүйн хэм хэмжээний акт

1. “Монгол Улсын Үндсэн Хууль” УБ, 1992
2. “Тэр бүлийн тухай” УБ, 1999
3. “Тэрч хохирогчийг хамгаалах тухай хууль” УБ, 2013
4. “Эрүүгийн хууль” УБ, 2015
5. “Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, УБ, 2016
6. “Зөрчлийн тухай хууль”, УБ, 2017
7. “Прокурорын тухай хууль, УБ, 2017

➤ Сурах бичиг, ном, гарын авлага

1. В.А Рясенцев: Советское семейное право, М.,1982
2. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх, УБ, 1999
3. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл, УБ, 2012
4. ХСИС, ШШГС “Сонсогч, оюутны илтгэлийн эмхэтгэл” 2015
5. А.Батбаатар, “Тэр бүлийн эрх зүйн зарим асуудал”, УБ, 2021
6. Монголын Хуульчдын холбоо, “Тэрч хохирогчийн хамгаалалт”, УБ, 2021
7. Ч.Нямсүрэн, “Эрх зүйн ерөнхий онол”, УБ, 2021

➤ Бусад эх сурвалж

1. ҮСХ, “Тэр бүлийн хүчирхийллийн статистик 2020”, УБ, 2021
2. <http://police.gov.mn>
3. <http://legaldata.mn/b/785>
4. <http://shuukh.mn>
5. <https://www.bundestag.de/dokumente/textarchiv/2017/kw22-de-haeusliche-gewalt-507528>
6. <https://www.bundesregierung.de/breg-de/aktuelles/gegen-gewalt-an-frauen-1817254>

¹¹⁵<https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D1%82%D0%B0%D1%80%D1%87%D0%BB%D0%B0%D0%B0%D1%85> Тарчлаах-Байнга тамлан зовоох, амар заяа үзүүлэхгүй байх гэсэн утгатай үг.

**ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛЭЭР ШУУРХАЙ АЖИЛЛАХ
МӨРДӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**
LEGAL REGULATION OF ACTIVITIES OF DETECTIVES TO WORK QUICKLY
WITH CALLS AND INFORMATION ABOUT CRIMES

Г.Саранхүү
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн хошууч
G.Sarankhuu
Graduate student of the
University of Internal Affairs,
police major

Хураангуй. Гэмт хэргийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, хэргийн газарт хамгийн түрүүн очиж, мэдээлэл үнэн бодитой эсэхийг нягтлан шалгах, хэргийн газрыг хамгаалалтад авах, нотлох баримт устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх, хэргийн газрын үзлэгийн багийг ирэх хүртэлх хамгаалалт авах, бусад шаардлагатай хойшлуулшгүй ажиллагааг ихэвчлэн хэв журмын алба хаагчид явуулдаг. Харин мөрдөгч нь хэргийн газрын үзлэгийн багийг удирдан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт этгээдийг илргэмүүлэх, олж тогтоох ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Энэхүү өгүүлэлд а)Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн төлөв байдал; б)гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн орчны талаар товч авч үзсэн болно.

Abstract.. Receiving crime calls and information, going to the crime scene as soon as possible, verifying the accuracy of the information, securing the crime scene, preventing the destruction of evidence, securing protection until the arrival of the crime scene inspection team, and other necessary urgent actions are usually routine. sent by officers. On the other hand, the detective leads the investigation team of the crime scene and takes measures to detect and stop the crime, identify and identify the perpetrator.

In this article, a) state of crimes committed in Mongolia; b) the legal framework of the detective's action to respond to calls and information about crime is briefly discussed.

Түлхүүр үг. Гэмт хэргийн дуудлага, мэдээлэл, мөрдөгч, хэргийн газрын үзлэгийн баг, шинжээч,

Key word. Crime calls and reports, detective, crime scene investigation team, analyst

Нэг. Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн төлөв байдал

Цагдаагийн байгууллага 2022 онд иргэн, аж ахуйн нэгжээс 657.650 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 309.572 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 42.351 буюу 15.8 хувиар өсч, гэмт хэргийн шинжтэй 97.007 /31.3%/, зөрчлийн шинжтэй 206.840 /66.8%/ гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байна.

2022 онд 5725 гомдол, мэдээлэл буюу нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 1.9 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.¹¹⁶

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг. Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 35340, Улаанбаатар хотод 24310 /68.8%/, орон нутагт 11019 /31.1%/, бусад газар /хилийн чанадад/ үйлдэгдсэн 11 /0.1%/ гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 9911 хэрэг буюу 39.0%,
- Нийслэлийн хэмжээнд 7776 хэрэг буюу 47.0%,
- Орон нутгийн хэмжээнд 2139 хэрэг буюу 24.1%-аар тус тус өсч, бусад газар /хилийн чанадад/-т 4 хэрэг буюу 26.7%-аар буурсан байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 30628 буюу 86.7 хувь нь хөнгөн, 4712 буюу 13.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 38.6 хувиар, хүнд гэмт хэрэг 41.2 хувиар тус тус өссөн байна.

График №1. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Бүртгэгдсэн гэмт хэргийн 5821 буюу 16.5 хувь нь согтуугаар, 5249 буюу 14.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1540 буюу 4.4 хувь нь бүлэглэн, 1258 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 1729 буюу 4.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгджээ.

Гэмт хэргийн илрүүлэлтийн хувьд 2022 онд улсын хэмжээнд 54.2 хувь, нийслэлд 52.0 хувь, орон нутагт 60.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 1.5, нийслэлд 1.7, орон нутагт 1.6 нэгжээр тус тус өсчээ. Хэрэг бүртгэлтийн 29900 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10595 хэрэг буюу 54.9, үүнээс 16209 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 6036 буюу 59.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн. Нийт 23665 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5587 буюу 30.9 хувиар өссөн. Холбогдогчдын 4470 буюу 18.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1543 буюу 52.7 хувиар, 1540 буюу 6.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 619 буюу 67.2 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 35220 хүн, 87 хуулийн этгээд хохирч, үүнээс 766 хүн нас барж, 10310 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 10226 буюу 40.9, гэмтсэн хүн 2011 буюу 24.2, нас барсан хүн 83 буюу 12.2 хувиар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 347900.1 сая төгрөгийн хохирлын 183243.9 сая төгрөг буюу 52.7 хувийг нөхөн төлүүлж, 5695.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 167526.2 сая төгрөг буюу 92.9 хувиар, нөхөн

¹¹⁶ <https://police.gov.mn>. //Татаж үзсэн: 15.10.2023. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал. /ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба/

төлүүлсэн хохирол 92841.1 сая төгрөг буюу 2.0 дахин тус тус өсч , битүүмжилсэн хөрөнгө 846.2 сая төгрөг буюу 12.9 хувиар буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 220663 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 73631 буюу 33.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 147032 буюу 66.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 35252 буюу 19.0 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 24838 буюу 50.9 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 10414 буюу 7.6 хувиар тус тус өссөн. Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 17132 буюу 23.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 52921 буюу 71.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 462 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлжээ.

Нийт 24.310 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7776 буюу 47.0 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 69.0 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 19.174, сард 1597, хоногт 53, цагт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл нийт гэмт хэргийн 8401 буюу 34.6 хувь нь гэр орон сууцанд, 5718 буюу 23.5 хувь нь гудамж талбайд, 2913 буюу 12.0 хувь нь олон нийтийн газарт, 146 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 379 буюу 1.6 хувь нь төрийн байгууллагад, 123 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 2638 буюу 10.9 хувь нь аж ахуйн нэгжид, 622 буюу 2.6 хувь нь авто замд, 3370 буюу 13.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.¹¹⁷

Монгол Улсад 2022 онд үйлдэгдсэн гэмт хэргийн төлөв байдлыг авч үзвэл дийлэнхи буюу нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 70.6% нь гэр, орон сууц болон гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдсэн нь нэг талаараа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй, нөгөө талаараа эргүүлийн чиглэл, гарах цагийг оновчтой тодорхойлж, нэгдсэн байршилд тусгаж чадаагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Хоёр. Мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.

Гэмт хэргийг таньж мэдэх гол нөхцөл нь чухамхүү нотлох баримтыг олж тогтоохоос шууд хамаардаг бөгөөд нотлох баримтын шалгуурын агуулгаар тодорхойлогдоход чиглэгдэнэ.

Гэмт хэргийн тухай мэдээлэл нь нэг талаас гэмт хэрэг гарсан болон түүнийг үйлдсэн этгээдийн талаар хэн нэгний хэлсэн болон бичгээр ирүүлсэн мэдээ, сэлт, өргөдөл, гомдол байдаг тул тэдгээр эх сурвалж нь гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдолтой.¹¹⁸

Мөрдөгчийн хийх ёстой үндсэн ажил бол гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр хэргийн газарт “хэргийн газрын үзлэгийн баг”¹¹⁹-ийн хамт очиж, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт /мэдээлэл, нотлох баримтын эх сурвалж/-ыг хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр эрж хайх, олж илрүүлэх идэвхитэй үйл ажиллагаа явуулах явдал юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8-д ““мөрдөгч” гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг”¹²⁰ хэмээн тодорхойлсон байдаг.

¹¹⁷ <https://police.gov.mn>. //Татаж үзсэн: 22.10.2023. цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал. /ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба/

¹¹⁸ Нандинцэцэг, М. Эрүүгийн процесст нотлох баримт цуглуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт /магистрын зэрэг горилсон дипломын ажил/. УБ.2023. 15 дахь тал

¹¹⁹ “Хэргийн газрын үзлэгийн баг” - хоногийн хугацаанд холбогдох томилгоо, хуваарийн дагуу Шуурхай удирдлагын бүрэлдэхүүнд ажиллаж, хэргийн газрын үзлэг хийх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах үүрэг бүхий эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах албаны мөрдөгч, зөрчил шалгах эрх бүхий алба хаагч, шинжээч, нохой хөтлөгч, цагдаа-жолооч зэрэг албан тушаалтнуудаас бүрдсэн бүрэлдэхүүнийг

¹²⁰ Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь дараах хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

- **Цагдаагийн албаны тухай хууль**

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйл /гэмт хэрэгтэй тэмцэх/-ийн 10.1.2-д “гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх”, 10.1.3-д “гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах” 10.1.4. “хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах”¹²¹ гэж заасан байдаг.

Дээрх зохицуулалт нь цагдаагийн алба хаагчаас гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, таслан зогсоох, шалгах, шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн үндсэн эх сурвалж болж байна.

- **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**

Тус хуулийн Зургадугаар бүлэг /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан/-ийн 3-д “Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна” гэж заасан нь мөрдөгчийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийн дагуу хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болж байна.

ЭХХШТХ-ийн 6.2 дугаар зүйлд “Мөрдөгч”-ийн эрх зүйн байдлыг тодорхой тусгаж өгчээ. Тухайлбал: хуулийн 6.2.1-д “Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна” гэж заасан байна.

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор мөрдөгч дараахь эрх эдлэхээр 6.2.2-д тусгажээ. Үүнд:

1. хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;
2. хуульд заасны дагуу сэжигтнийг баривчлах;
3. прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах;
4. шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;
5. мөрдөгч авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, шүүх, прокурор авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх тухай саналыг прокурорт гаргах;
6. сэжигтнийг баривчлах шүүхийн зөвшөөрөл авах тухай саналыг прокурорт гаргах;
7. оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;
8. прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;
9. өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд

¹²¹ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх зэрэг эрхүүдийг үүнд хамааруулан авч үзэж болохоор байна.

Мөн хуулийн 6.2.4-д “Мөрдөгч гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулна”¹²² гэж мөрдөгчийн явуулж болох эрх зүйн үндсийг зааж өгсөнөөс гадна 6.2.5-6.2.7-д “тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээчийн эрхийг хэрэгжүүлж, магадлагаа гаргаж болох, шинжилгээ хийлгэхээр томилогдсон шинжээчтэй хамтран ажиллах, холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болох” зохицуулалтуудыг давхар тусгаж өгчээ.

Түүнчлэн мөрдөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээг тусгайлан зохицуулж өгчээ. Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаанд эрх бүхий албан тушаалтан /Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга/-ы эрх хэмжээг түүвэрлэн авч үзвэл:

1. мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх;

2. мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгах;

3. шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх;

4. хавтаст хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах¹²³ зэрэг болно.

Эндээс үзвэл мөрдөгч хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор явуулж болох бүхий л ажил, арга хэмжээнүүд хуулиар зохицуулагдаж, эрх зүйн орчин бүрдсэнээс гадна мөрдөгч хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэл гарахаас сэргийлэх зорилгоор хяналт тавих субъектын эрх хэмжээг тусгайлан зааж өгсөн байна.

- **Эрүүгийн хууль**

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн нөлөөлөл орохоос урьдчилан сэргийлэх, хууль бус нөлөөлөл оролдлого хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл /Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх/-д тусгаж өгчээ.

Тухайлбал, уг хуулийн 21.6.1-д “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”¹²⁴ гэж заасан нь гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт хийгдсэн гэж үзэж болохоор байна.

¹²² Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

¹²³ Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

¹²⁴ Төрийн мэдээлэл. 2016. №07. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/

- **Зөрчлийн тухай хууль**

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаанд санаатай саад учруулах аливаа үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж болох зохицуулалт үйлчилж байна.

Зөрчлийн тухай хуулийн арван тавдугаар бүлэг /Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил/-ийн 15.1 дүгээр зүйл /Эрүүл мэндийн байгууллага, хууль сахиулах байгууллагад туслалцаа үзүүлэхгүй байх/-д мөрдөгчийн үйл ажиллагаанд саад учруулах үйлдлүүдийг тусгайлан зааж өгсөн байна. Тухайлбал:

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр:

1. гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих;
2. гэмт хэрэгтнийг мөрдөн хөөх;
3. амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүнийг эмнэлэгт хүргэх;
4. гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх;
5. гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг мөрдөн хөөх, баривчлах;
6. гэмт хэрэг, зөрчил гарсан тухай яаралтай мэдээллийг дамжуулахад тээвэр, холбоо, эсхүл мэдээллийн хэрэгслээ төрийн албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, хууль сахиулагчид ашиглуулахаас татгалзах¹²⁵ зэрэг үйлдлүүдийг хамааруулан оруулсан байна.

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр саад учруулсан хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгаж өгчээ.

Дээрхи зохицуулалт нь гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаа хэвийн явуулах боломж нөхцлийг бүрдүүлсэн зохицуулалт гэж үзэж болохоор байна.

- **Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам**

Гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаа нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

- **Шуурхай удирдлагын үйл ажиллагааны журам /код 200/**

Энэхүү журамд гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой нэр томъёоны тодорхойлолтуудыг тусгаж өгсөн байх бөгөөд доорхи тодорхойлолтууд нь мөрдөгчийн хийх ёстой ажлуудыг илүү тодорхой болгох агуулгыг илэрхийлсэн байдаг. Тухайлбал:

“Шуурхай удирдлагын үйл ажиллагаа”, “Шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгж”, “Хэргийн газрын үзлэгийн баг”, “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага”, “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл”, “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол”, “Хойшлуулшгүй ажиллагаа”, “Тодорхой ажиллагаа”, “Даруй”, “үндэслэл бүхий сэжиг”¹²⁶, “Хэргийн газрын үзлэг”¹²⁷, “Бүрэлдэхүүн”¹²⁸ зэргийг хамааруулж байна. Дээрх нэр

¹²⁵ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

¹²⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. –УБ.2022. 346 дахь тал

¹²⁷ 206.2. “Хэргийн газрын үзлэг” - мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, гэмт хэргийг хэн үйлдсэнийг тогтоохын тулд ул мөр, баримт сэлт, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах ажиллагааг;

томъёоны тодорхойлолтууд нь гэмт хэргийн тухай дуудлага, мэдээллээр шуурхай ажиллах мөрдөгчийн үйл ажиллагааг илүү тодорхой ойлгох боломжийг олгосон гэж үзэж байна.

Уг журмын 200.6.12-д нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжийн жижүүрийн ахлах мөрдөгч, жижүүрийн мөрдөгчийн гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхээр тусгаж өгчээ. Тухайлбал:

а/энэ журмын 200.5.4 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

б/энэ журмын 200.8.2 дахь хэсэгт заасан мэдээллийг хүлээн авмагц хоногийн нөхцөл байдлын мэдээний санд даруй хугацаанд үнэн зөв оруулж, тогтоосон хугацаанд хянан баталгаажуулах;

в/хоногийн нөхцөл байдлын мэдээний санд зарим төрлийн мэдээлэл оруулах үүрэг хүлээсэн бусад нэгж, албан тушаалтны оруулсан мэдээллийг хянаж, илэрсэн зөрчлийг засуулж, баталгаажуулах;

г/хоногийн нөхцөл байдлын мэдээг батлагдсан загварын дагуу бэлтгэж, нэгжийн даргаар хянуулан байгууллагын удирдлагад тогтоосон хугацаанд танилцуулах;

д/энэ журмын “Шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжид хөтлөгдвөл зохих бүртгэл, баримт бичгийн жагсаалт /маягт ЦБҮАЖ №200.54а/”-д заасан бүртгэлийг бүрэн хөтлөх;

е/энэ журмын “Шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжид байвал зохих зэвсэг хэрэгслийн жагсаалт /маягт ЦБҮАЖ №200.54б/”-д заасан албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, төхөөрөмж, эд зүйлийг бүрдэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;

ж/мэдээлэл хүлээн авагч-жижүүрийн цагдаагийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих;

з/албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээ, мэдээллийг задруулахгүй байж Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг чанд мөрдөж, хэрэгжүүлэх; и/хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэх хэргийн газрын үзлэгийн баг, жижүүр, харуулын томилгооны хуваарийг хийж, шуурхай удирдлагын нэгжийн даргаар хянуулж, байгууллагын даргаар батлуулах.¹²⁹

Түүнчлэн журамд заасан жижүүрийн мөрдөгч, ахлах мөрдөгчидтэй холбоотой зарим харилцааг зохицуулсан зүйл, заалтуудыг түүвэрлэн авч үзвэл:

- 200.6.15.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжийн теле-хяналтын камерын цагдаа дараах үүргийг хэрэгжүүлнэ: б/камерын хяналтын явцад илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын жижүүрийн ахлах мөрдөгчид даруй мэдэгдэж, шийдвэрлүүлэх;

- 200.10.4.Хэргийн газрын үзлэгийн багийн бүрэлдэхүүнд ажилласан мөрдөгч нь шалгасан хэргийн явц, үр дүнг тухайн байгууллагын дарга, эсхүл дэд даргад танилцуулж, түүний шийдвэрээр цааш үргэлжлүүлэн шалгах мөрдөгчид хэрэг, материалыг бүрэн хүлээлгэн өгч, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

• **Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх журам /код 201/**

- 201.2.9. Энэ журмын 201.2.1-д заасан ноцтой гэмт хэргийн мэдээллийн тодруулга мэдээллийг нийслэлд дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн ерөнхий жижүүр, ахлах мөрдөгч /мөрдөгч/ нь цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ болон харилцаа, холбооны хэрэгслээр

¹²⁸ 207.3. “Бүрэлдэхүүн” - зам тээврийн осол, хэргийн газарт үзлэг хийлгэхээр томилсон техникийн шинжээч, криминалистикийн шинжээч, мөрдөгч, мэргэжилтэнг. Шаардлагатай үед прокурор, шинжээч эмч нарыг;

¹²⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. –УБ.2022. 356-357 дахь тал

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн ерөнхий жижүүрт даруй мэдэгдэнэ. Алба, орон нутаг дахь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын ерөнхий жижүүр, ахлах мөрдөгч /мөрдөгч/ нь тодруулга мэдээллийг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ болон харилцаа, холбооны хэрэгслээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны онцгой нөхцөл байдлын шуурхай, удирдлага зохицуулалтын ажил хариуцсан нэгжийн ерөнхий зохицуулагчид даруй хүргүүлнэ.

- **Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах журам /код 202/**

- 202.6.5.Гомдол, мэдээлэл шалгах үүрэг хүлээсэн алба хаагч /мөрдөгч, хэрэг бүртгэгч, эрүүгийн мөрдөгч, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эргүүлийн офицер/ нь гомдол, мэдээллийг хүлээн авч нэн даруй нэгдсэн бүртгэлд бүртгэж, энэ тухай мэдээллийн нэгдсэн санд оруулна. Энэ хугацаанд шалгалтыг зогсоохгүй.

- 202.6.10.Мөрдөгч нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэргийг шалгах явцад зөрчил тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.11 дүгээр зүйлийг баримтлан шийдвэрлэнэ.

- **Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах журам /код 205/**

- 205.2.3.Хэргийн газрын үзлэгийн багийн мөрдөгч нь хэрэг, зөрчлийн газрын үзлэгийн үеийн болон үзлэгийн дараах хамгаалалтын хүч хэрэгсэл, хүрээ хязгаар, цаг хугацаа, дэглэмийг тогтоосны дагуу тухайн цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын алба нь хамгаалалтыг хариуцан зохион байгуулна.

- 205.6.6.Хэргийн газрын үзлэгийн баг ирмэгц мөрдөгчид хэргийн газрын хамгаалах талаар авсан арга хэмжээ, хэргийн газрын онцлог /үнэр, салхины чиг, агаарын температур, хэргийн газарт ирсэн цаг, минут, юуг ямар шаардлагаар хөдөлгөсөн, өөрийн гутлын мөр, орсон газар, хүрсэн зүйл гэх мэт/ зэргийг хамгаалалтад ажилласан алба хаагч илтгэх хуудсаар танилцуулж, тэмдэглүүлнэ.¹³⁰

- **Хэргийн газрын үзлэг хийх журам /код 206/**

- 206.3.1.Мөрдөгч дараах зохион байгуулалтын дагуу хэргийн газрын үзлэгийг явуулна:

- а/хэргийн газрын хамгаалалтын бүсийг тогтоож хамгаалалтад авах, хамгаалалтыг цуцлах;

- б/мөрдөгч нь хуульд заасны дагуу хэргийн газарт үзлэг хийх, зураглал үйлдэх, дүрс бичлэг хийх ба хэргийн газрын үзлэгийг удирдан зохион байгуулж ажиллах;

- в/шаардлагатай бол хэргийн газарт байгаа хохирогч, бусад хүнд эрүүл мэнд, сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ талаар тэмдэглэлд тусгана;

- г/тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодис алдагдсан, онц аюултай зэвсэглэсэн этгээд байгаа эсэх талаар урьдчилсан тандалт явуулж, илэрсэн тохиолдолд аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч мэргэжилтэнг оролцуулах бөгөөд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 201, 211-ийг мөрдөж ажиллах;

- д/хэргийн газрын үзлэгийн дарааллыг тодорхойлох;

- е/үзлэгт оролцогч нарыг хаана байрлахыг зааж өгөх, тэдгээрт нэмэлт ул мөр үлдээхгүй байхыг анхааруулж, ул мөр үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

- ж/үзлэгийн явцад тогтоогдож буй нөхцөл байдалтай уялдуулан яаралтай авч хэрэгжүүлбэл зохих мөрдөн байцаалтын хойшлуулшгүй болон гүйцэтгэх ажлын арга хэмжээ авч, гэмт этгээдийг олж тогтоох, илрүүлэх, баривчлах чиглэлээр алба хаагч нарт мэдээлэл, үүрэг, чиглэл өгч ажиллуулах;

¹³⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. –Уб.2022. 390 дэх тал

- з/хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа гэрч, хохирогч нарыг тогтоох;

- и/хэргийн газраас эд зүйл, хүн, мал, амьтан хайх бусад шаардлагатай тохиолдолд онцгой байдал, мэргэжлийн хяналт, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдыг татан оролцуулах;

- к/криминалистикийн мэргэжилтэн нь хэргийн газраас ул мөр, баримт сэлт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулахад ашиглагдах техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, үзлэг хийж буй мөрдөгчийн удирдлагаар ул мөр, баримт сэлт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах ажлыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх;

- л/тэмдэглэл хөтлөгч нь хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйлдэх, хойшлуулшгүй тохиолдолд оролцогч нараас мэдүүлэг, авах;

- м/эрүүгийн мөрдөгч нь хэргийн газрын ойр орчимд биечилсэн сурвалжлага хэргийн оролцогч этгээдийг олж тогтоох, хохирогчийг хэн болохыг олж тогтоох, алдагдсан эд зүйлсийг эрэн сурвалжлах, мэдээ, мэдээлэл цуглуулах;

- н/нохойн төлөөлөгч хэргийн газраас хүн, эд зүйл олох зорилгоор самналт нэгжлэг хийх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх, хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн үнэрийн мөрөөр мөрдлөг хийх, хэргийн газрын үзлэгийн үеэр оргон зайлсан сэжигтэй этгээдийг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх;

- о/хэргийн газрын үзлэгийн явцыг иргэд, хэвлэл, мэдээллийн ажилтнууд дууны болон дүрс бичлэг хийж олон нийтэд мэдээлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд хэргийн газрын хамгаалалтын алслалыг өөрчилж тогтоох.¹³¹

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан 200 орчим зүйл, заалтууд байгаа боловч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын жижүүрийн мөрдөгчийн үүрэг гүйцэтгэхтэй холбоотой зохицуулалтуудыг түүвэрлэн авч үзлээ.

Дээрхи журмуудад заасан зохицуулалтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэмт хэргийн дуудлага, мэдээллийн дагуу мөрдөгчийн хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээг зохицуулсан байх бөгөөд зарим харилцааг илүү нарийвчлан оруулж өгсөн нь мөрдөгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын нэг хэсэг болж байна.

Дүгнэлт. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын тасагт жижүүрийн мөрдөгчөөр ажиллаж байгаа мөрдөгчийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь ихэвчлэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаас гадна Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан 5 код журамд заасан зүйл, заалтуудаар зохицуулагдаж байна.

Дээрхи зохицуулалтаас үзвэл нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын тасагт жижүүрийн мөрдөгчөөр ажиллаж байгаа мөрдөгчийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллах үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болохоор байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын тасагт жижүүрийн мөрдөгчөөр ажиллах мөрдөгчдийн эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох

¹³¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. –Уб.2022. 391 дэх тал

шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа авч байх ажлыг тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах тасгийн дарга хариуцан зохион байгуулах;

2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын тасагт жижүүрийн мөрдөгчөөр ажиллах мөрдөгчдөөс гаргаж буй алдаа, дутагдал нь тэдний эрх зүйн мэдлэгээс шалтгаалж байгаа эсэхийг тогтоох судалгаа хийх;

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Эрүүгийн хууль
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
4. Зөрчлийн тухай хууль

Ном бүтээл:

5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. –Уб.2022.

Судалгааны ажил

6. Нандинцэцэг, М. Эрүүгийн процесст нотлох баримт цуглуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт /магистрын зэрэг горилсон дипломын ажил/. Уб.2023.

Сэтгүүл:

7. Төрийн мэдээлэл. 2016. №07
8. Төрийн мэдээлэл. 2017. №8
9. Төрийн мэдээлэл. 2017. №23
10. Төрийн мэдээлэл. 2017. №24

Цахим эх сурвалж:

11. <https://police.gov.mn>

ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДСЭН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН
ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АСУУДАЛ
INVESTIGATION OF FRAUD CRIMES COMMITTED IN THE ELECTRONIC
ENVIRONMENT FUNDAMENTAL THEORIES AND LEGAL PROBLEMS

П.Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа
P.Erdenebaatar
Senior teacher of Department Criminal
Procedure Law, Police Lieutenant Colonel,
Police school of University of Internal Affairs

Хураангуй: Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн криминалистик тодорхойлолт, тухайн гэмт хэргийг үлдэж байгаа хүн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагаа, тэрчлэн тухайн төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлогуудын талаар авч үзсэн болно.

Abstract: The Criminalistic definition of the crime of fraud committed in the electronic environment, the person who is committing that crime, the illegal activity of the law, as well as the features of the investigation of that type of crime are discussed in relation to the object of the research work.

Түлхүүр үгс: Криминалистик тодорхойлолт, Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, газар орон, цаг хугацаа, халдлагын зүйл, Гэмт хэрэгтний хувийн байдлын ерөнхий тодорхойлолт; Хохирогчийн хувийн байдал

Keywords: Criminalistics definition, The circumstances of the commit crime, land country, time, attack item, General description of the personality of the criminal, Identity of the victim

Удиртгал. Аливаа шинжлэх ухааны тухайд хөгжлийнхөө явцад шийдвэрлэвэл зохих үндсэн асуудлуудын нэг нь судалж буй тухайн зүйлийнхээ шинжлэх ухаанч тодорхойлолт, мөн чанар, байр суурь, хамаарах асуудлуудыг өөрийн шинжлэх ухааны арга зүйн үүднээс судлан тодорхойлох явдал байдаг.

Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухааны цөөнгүй судлаач, эрдэмтэн тухайлсан тодорхой төрлийн гэмт хэргийн криминалистик тодорхойлолтод хамаарах, ялангуяа тогтвортой байдаг мөн чанарыг судлан тогтоох асуудалд онцгой анхаарч нэгэнт судалж тогтоосон тодорхой шинж тэмдгүүдийг нь нэгтгэн улмаар гэмт үйлдлийн бүтцийг тогтооход зайлшгүй шаардагдах, урьд өмнө нь мэдэгдэж байгаагүй шинэ элементүүдийг гаргаж ирэх судалгаа шинжилгээний ажлыг хийсээр байна.

Орчин үеийн шинжлэх ухаанууд, түүний дотор эрүүгийн эрх зүйн чиглэлийн шинжлэх ухаанууд нь сэдвийн хувьд нэгдмэл, шинэ шинэ нэр томъёо, ойлголтуудаар цаг тухай бүр нэмэгдэж, судалгаа, шинжилгээний ажлуудын чиг хандлага нь тухай бүр нарийсаж, нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг нэг мөр шийдвэрлэхэд түлхүү анхаарах болсон байна.

Энэ байдал нь тухайлсан шинжлэх ухааны хувьд мэдлэгийнх нь хүрээ хязгаар өргөжин тэлээд зогсохгүй, бусад шинжлэх ухаантай холбоотой ойлголт мэдлэгийнх нь хэмжээ агуулга, түүнчлэн тэдгээрийн хоорондын харилцан хамаарлын тухай мэдлэгийн хүрээ улам бүр нэмэгдэх, хэрэглээнийх нь талаарх ойлголт улам бүр нарийн тодорхой байх шаардлагын нэгэн үндэслэл болж байна. Тухайлбал, зарим төрлийн гэмт хэргийн мөн чанарыг тодорхойлдог криминалистик тодорхойлолт нь цогцолбор ойлголт тул тэдгээр нь өөр хоорондоо салшгүй холбоотой байдаг

болохыг шинжлэх ухааны арга зүйн үүднээс тодорхойлон бичиж, уг гэмт хэргийг үйлдэхэд түүнийг хэрэгжүүлсэн арга, орон зай, цаг хугацаа, тоо болон чанар, орчин нөхцөл, гэмт халдлагын объект, субъект болон субъектив олон зүйл шууд, шууд бусаар нөлөөлдөг боловч эдгээр нь өөр хоорондоо салшгүй холбоотой учир уг асуудлыг гагцхүү цогцолбор байдалд нь авч судалдаг болж байна.

Гэмт хэргийн криминалистик тодорхойлолтын ойлголт, агуулга, түүнийг илэрхийлэх элементүүдийн талаарх асуудлууд, тодорхой төрлийн гэмт хэргийн криминалистик тодорхойлолт, шинж чанаруудыг идэвхтэй судлан шинжилж байгаа нь орчин үеийн криминалистикийн шинжлэх ухааны салшгүй нэг бөгөөд мөнхүү тодорхойлолт нь эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухааны үндсэн хэрэглэгдэхүүний нэг болдог онцлогтой.

Криминалистикийн арга зүйд гэмт хэргийн криминалистик тодорхойлолт нь чухал ач холбогдолтой байх ёстой ба гэмт хэрэг мөрдөх арга зүйг боловсруулахад криминалистикийн тодорхойлолтыг тогтоохгүйгээр тухайн гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүйн зөвлөмжийг гаргах боломжгүй юм. Иймд цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн криминалистик жишиг тодорхойлолтыг гаргах нь гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд зөвлөмж болно.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг үйлдэх асуудал маш өргөн дэлгэр болж байна. Залилах гэмт хэргийн энэхүү төрөл нь урьд өмнө нь үйлдэгдэж ирсэн уламжлалт гэж нэрлэж болохоор төрлүүдээсээ гэмт халдлага, үйлдэгдэж байгаа онцгой нөхцөл байдлаараа ялгарч байгаа юм.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь нэг талаас, урьд өмнө нь гэмт этгээдүүд хэрэгжүүлж ирсэн гэмт санаа зорилгодоо хүрэх аргуудыг¹³² ямар нэг өөрчлөлтгүйгээр хэрэглэж байгаагаараа залилах гэмт хэргийн өөрийнх нь хувьслын үр дүн, нөгөө талаас гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх арга нь тухайлсан төрөл зүйл бүрдээ улам нарийссан гэмт хэргийн шинэ бүлэг гэмт хэрэг боллоо. Энэ бүлгийн гэмт хэргүүд нь компьютерын техник, программ хангамж ашигласан бусад гэмт хэргүүдээс маш нууцлагдмал байдлаараа онцгой ялгардаг байна. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай түргэн явуулахад хүндрэл үүсгэдэг.
2. Цахим орчинд залилах аргаа хэрэгжүүлэх онцлог нь маш нарийн боловсруулагдсан байдгаас үүдэлтэй.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн тухайд залилах гэмт хэргийн уламжлалт гэмт хэргүүдийн нэгэн адил аль болох өргөн хүрээний хохирогч олоход чиглэгдсэн байдаг.

Харин цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь тухайн гэмт хэргийг үйлдэгч этгээдийн тухайд нэмэгдэл шаардлагуудыг тавьдаг гэж хэлж болно. Энэ бол хүн болгон тэр бүр өөрийн болгон эзэмшээд байж чаддаггүй мэдээллийн өндөр технологи, компьютерын программ хангамжийн салбарын тухайлсан танин мэдэхүйн тусгай мэдлэг юм. Цахим орчин зөвхөн мэдээлэл дамжуулах боломжтой тодорхой орчин, нөхцөл, гэдгийг анхаарвал цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн халдлагын зүйл нь зөвхөн өмч хөрөнгийг олж авах эрхэд чиглэгдсэн байна гэж үзэж болно.

Интернэтийн орчин материаллаг ертөнцийн бүх шинжийг агуулдаггүй учир зөвхөн хийсвэр байдлаар материаллаг гэж тооцож болох юм.

Цахим орчинд үйлдсэн гэмт хэргийг судлаачид хийсвэр байдалтай материаллаг орчныг хоёр түвшинтэй гэж үзсэн байна. Тухайлбал, эхнийх нь хийсвэр орчинд программчлалын кодын хэлбэртэйгээр бий болгож байгаа мэдээлэл солилцооны түвшин, хоёр дахь нь компьютерын өөрийнх нь санах ой дотор эсхүл түүний холбогдсон сүлжээний дотор гурван хэмжээст объектуудын (тэдгээрийг зарим ном зохиолд аватарууд гэж нэрлэсэн нь байна) хооронд мэдээлэл солилцох замаар үүсгэж байгаа амьдралын түвшин гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, харахад бодит мэт сэтгэгдэл төрүүлж байдаг зохиомол ертөнц нэг талаас, нөгөө талаас тэрхүү зохиомол нөхцөлд болж байгаа, эсхүл болж өнгөрсөн үйл явдлын талаар авч үзнэ гэсэн үг юм.

Орчин үед мэдээлэл харилцааны өндөр технологи хүний амьдралын салшгүй нэгэн хэсэг болон хувирч байгаа учраас өдөр тутмын харилцаанд нь “цахим орчин” гэдэг үг хэллэг нэвтэрч,

¹³² Нигерийн захидал илгээгчийг хэрхэн татан буулгах ...<https://vgolitsyno.ru> (Хандалт: 2022 оны 05 сар)

үүнтэй холбоотойгоор хууль сахиулах байгууллагуудын практикт “цахим орчинд үйлдсэн гэмт хэрэг” гэдэг нэр томьёо шинээр нэмэгдсэн.

Гэвч цахим орчинд үйлдсэн гэм хэргийг тодорхойлсон нийтээр хүлээн зөвшөөрч байгаа нэгдмэл нэршил байхгүй байгаа учраас ийм төрлийн гэмт хэргүүдийг эрдэмтэн судлаач бүр янз бүрээр нэрлэж байгааг нэр мөр болгох зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна. Жишээлбэл, Цахим гэмт хэрэг, Өндөр технологийн салбар дахь гэмт хэрэг, Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Кибер гэмт хэрэг, Компьютерын мэдээллийн эргэлтийн аюулгүй байдлын салбар дахь гэмт хэрэг, Компьютерын мэдээллийн салбар дахь гэмт хэрэг гэх мэтээр нэрлэж байна.

Тэгвэл цахим орчинд үйлдсэн гэмт хэргүүдийг дээрхээс өөр байдлаар, тухайлбал, “... цахим орчинд үйлдсэн гэмт хэрэг гэдэг бол компьютерын техник хэрэгсэл бодит байдалд гэмт хэрэг үйлдсэн багаж зэвсэг нь болсон, эсвэл хийсвэр орчин дахь гэмт халдлагын зүйл нь байсан хууль бус үйлдэл байна” гэж тодорхойлж болно.

2001 оны 11 дүгээр сарын 23-нд Европын Холбооноос баталсан “Цахим орчин дахь гэмт явдлын тухай Конвенц”¹³³ -д цахим гэмт хэрэг гэдэг ойлголтын шинжүүд, ангилал, ба цахим гэмт хэргийн тухай ойлголтын ач холбогдлын талаар анхлан тусгасан байна. Ингэхдээ *cibrcrime* (цахим орчин дахь гэмт хэрэг) гэсэн нэр томьёог хэрэглэсэн байх ба харин *computer crime* (компьютерын гэмт хэрэг) гэсэн нэр томьёог хэрэглээгүй байна.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн талаар нарийвчлан авч үзэхийн өмнө криминалистикийн шинжлэх ухааны үүднээс залилах гэмт хэргийн талаарх тодорхойлолт өгөх учиртай.

Энэ тодорхойлолтын агуулгын талаар эрдэмтэн судлаачдын дунд байгаа янз бүрийн чиг хандлагуудыг судалж үзэхэд дор дурдсан бүрдэл хэсгүүд олон дурдагдаж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, түүний дотор газар орон, цаг хугацаа, түүнчлэн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн нөхцөл байдал;
2. Гэмт хэрэг үйлдсэн арга (бэлтгэсэн арга, гэмт хэргийг үйлдсэн арга хэлбэр, гэмт хэргээ нуун далдалсан арга);
3. Халдлагын объект ба халдлагын зүйл;
4. Гэмт хэрэгтний хувийн байдлын ерөнхий тодорхойлолт;
5. Хохирогчийн хувийн байдлын ерөнхий тодорхойлолт багтаж байна.

Гэмт санаа бодлоо амжилттай болгох аль болох их үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бол гэмт этгээдийн хувьд гэмт хэрэг үйлдэх газар орон, цаг хугацааг хэрхэн сонгохоос нь ихээхэн шалтгаалдаг. Зарим эрдэмтэн, судлаач нар залилах гэмт хэргийн төрлүүд ихээхэн үйлдэгддэг газар орон, тухайлбал, хүн ам ихээхэн бөөгнөрдөг газар, галт тэрэг, нисэх онгоцны буудал, цэнгэлдэх хүрээлэн гэх мэт, нутаг дэвсгэрт энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ өргөнөөр зохиох нь зүйтэй гэж үздэг.

Гэмт этгээдүүд өөрийн санаа зорилгоо биелүүлэхээр төлөвлөхдөө зарим нэг гаднын хүчин зүйлс, тухайлбал, тухайн нутаг дэвсгэр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, байгаль, цаг уурын онцлог, хүн амын нягтаршил, бусад шаардлагатай гэж үзсэн нөхцөл байдлуудыг тооцож үздэг болжээ. Энэ бүхэн нэг талаас, аль болох олон хохирогчоос ихээхэн орлого олох үндсэн зорилгодоо хүрэх, нөгөө талаас өөрийн гэмт үйлдлээ нуун далдлах найдвартай аргыг сонгон хэрэгжүүлэх боломж олж авахад шийдвэрлэх нөлөөтэй байдаг.

Тухайн газар орон, цаг үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг өөрт ашигтай байхаар тооцоолох чадвар нь цахим орчинд залилах гэмт хэрэг үйлдэж байгаа хүн, хуулийн этгээдийн нийгэмд хамгийн их аюул учруулж байгаа чадвар гэж үзэж болно. Тухайн төрлийн гэмт хэргийн үзүүлж байгаа түүхэн сургамжаас харахад орчин үед, ялангуяа Монгол Улсад ихээхэн түгээмэл

¹³³ Конвенция о компьютерных преступлениях ETS N 185. 2001 оны 11 сарын 23-нд Будапешт хотноо батлагдсан ба 2003 оны 01 сарын 28-нд өөрчлөлт оруулсан. СПС “Трант

үйлдэгдэж байгаа “санхүүгийн пирамид”¹³⁴ хэмээн нэрлэгддэг залилах гэмт хэргийн төрлийг ийм чадварыг сайтар эзэмшсэн хүн, хуулийн этгээд үйлддэг нь нэгэнт тодорхой болж байна. Тухайлбал, “Жи тайм” сүлжээний Монголын Улсын санхүүгийн залилангийн түүхэнд гадаад эзэнтэйгээ, мөнгөтэйгөө баригдсан анхны тохиолдол юм¹³⁵.

Гэмт хэрэг үйлдэх арга бол эрт үеэс ямар нэг төрлийн гэмт хэргийн криминалистик тодорхойлолтын үндсэн бүрдэл хэсгүүдийн нэг байсаар ирсэн бөгөөд түүний талаар ерөнхийдөө гэмт санаа бодлоо ажил хэрэг болгох, олон төрлийн үйлдэл, үйл ажиллагааны нийлбэр цогц гэж тодорхойлдог.

Энэхүү нийлбэр цогц нь тогтолцооны шинжийг агуулсан байх тул өөр хоорондоо харилцан холбоотой гурван үе шатыг бүрдүүлж байдаг. Тухайлбал,

1. Бэлтгэл шинжтэй үйлдэл, гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх, эсвэл учрах саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн нөхцөлийг бүрдүүлэх үйл үйл ажиллагаа;

2. Гэмт этгээдийн зүгээс гэмт санаа бодлоо шууд хэрэгжүүлж эхлэх үйлдэл;

3. Үйлдсэн гэмт хэргийнхээ ул мөрийг баллах, нуун дарагдуулах, далдлах, гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах, хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагааг төөрөгдүүлэхэд чиглэгдсэн үйлдэл гэсэн төрлүүдтэй байна.

Эдгээр үе шатууд криминалистикийн шинжлэх ухааны үүднээс авч үзэхэд бүгд чухал ач холбогдолтой хэдий ч зарим тохиолдолд эрүүгийн эрх зүйн үүднээс аливаа төрлийн гэмт хэргийн зүйлчлэлд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.

Залилах гэмт хэрэг үйлдэгч хүн, хуулийн этгээдийн үйлдэл ямар байдлаар илэрсэн болох, өөрөөр хэлбэл хүн, хуулийн этгээдийн өөрийн санаа зорилгоо биелүүлэхдээ чухам ямар арга хэрэглэснээс үл хамааран тодорхой хэмжээний ул мөр, төрөл бүрийн объектууд хэлбэрээр тухайлбал, хуурамч баримт бичиг заавал үлддэг байна.

Орчин үед ихэнх тохиолдолд хувийн онцгой байдлаасаа хамаарч мөнгө нь залилан мэхлэгч хүн, хуулийн этгээдүүдийн анхаарлыг ихэд татах болсон учир залилах гэмт хэргийн халдлагын зүйл болох нь улам түгээмэл болж байна. Харин бусад өмч хөрөнгө, түүний төрөл зүйл болон өмчлөх эрхийн тухайд бол мөнгөтэй зөвхөн дүйцүүлж болох юм. Учир нь тэдгээрийг яг одоо биш ч дараа нь зарж борлуулснаар бас л мөнгө болох учиртай. Мөнгөнөөс гадна үнэт эрдэнийн зүйлс, гоёл чимэглэл, тээврийн хэрэгсэл, компьютер, тооцон бодох машины программ хангамж, ахуйн цахилгаан хэрэгсэл, хувцас, газар, түүн дээрх барилга байгууламж зэрэг бусад төрлийн хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн төрлүүд залилах гэмт хэргийн халдлагын зүйл¹³⁶ болж байна.

Өнөө үед өмчлөх эрх гэдэгт чухам юуг ойлгох талаар эрүүгийн эрх зүйн нарийн тодорхойлолт байхгүй байгаа учраас өмчтэй холбоотой гэмт хэргийг бүрэн төгссөн гэж үзэх хугацааны талаар, өөрөөр хэлбэл тухайн өмчийн хувьд захиран зарцуулах бүрэн эрхийг нь олж авсан үед үү, эсвэл ямар нэг хэмжээгээр эзэмших, ашиглах эрхтэй болсон үед үү гэдэг асуулт нээлттэй хэвээр байна.

Учир нь өмчлөх эрх түүнчлэн эдгээр эрхийн багтаамж нь тодорхой хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан байдаг тул гэмт халдлагын зүйл нь өмчлөх эрх байгаа тохиолдолд, тухайн баримт бичигт, дурдсанаар хохирогч ямар эрх эдэлж байсан, тэр эрхийг залилан мэхлэгч хүн, хуулийн этгээд өөртөө нэгэнт шилжүүлэн авсан тэр үед тухайн төрлийн гэмт хэргийг бүрэн төгссөн гэж тооцох ёстой.

Харин тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тухайлбал, худалдах, худалдан авах эрхийн тухайд өөрөөр шийдвэрлэгдэх нь зүй ёсны хэрэг юм.

¹³⁴Залилангийн гурвалжин онол: Залилах гэмт хэргийн талаар хамгийн өргөн тархсан онол нь Доналд Крессейгийн /DonaLd Cressey/ 1950-аад оны судалгаанд үндэслэсэн “боломж”, “дарамт буюу шаардлага” ба “ухаалаг тайлбар” гурвын нэгдэл буюу залилангийн гурвалжин /FRAUD TRAIANGLE (J.& Cressey, 2008)/ загварт үндэслэн тодорхойлсон онол юм.

¹³⁵ Чимэддамба, Д. “Жи тайм” Монголын санхүүгийн ...alim.mnhttp://alim.mn

¹³⁶Адъяабазар, Д. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал. сэдэвт хууль зүйн докторын диссертаци -УБ., 2004, 83 дахь тал

Гэмт хэрэгтний хувийн байдлыг нарийвчлан судлах нь залилах гэмт хэргийн тухайд чухал ач холбогдолтой гэж зарим нэг эрдэмтэн, судлаачид үздэг байна¹³⁷. Криминалистикийн сурах бичиг, эрдэм шинжилгээ судалгааны ажлын бүтээлд залилан мэхлэгчийн хувийн байдлын талаарх үзэл баримтлалыг ерөнхийд нь хоёр бүлэгт хуваан авч үзэж байна.

Нэгдүгээр бүлгийн төлөөлөгчид, залилах гэмт хэрэг нь гэмт этгээдээс тусгай шинж чанаруудын нэгдлийг, тухайлбал, хурц ухаан, өргөн мэдлэг, сайтар хөгжсөн мэдрэмж, нээлттэй зан чанар, бусдыг өөртөө татах чадвар, хүний сэтгэл зүйн талаарх сайн мэдлэг зэргийг шаарддаг гэж үзэж байна. Залилан мэхлэгчдийг “эрх зүйн салбарын танин мэдэхүйн болон ерөнхий мэдлэгийн өргөн хүрээний мэдлэгтэй өндөр боловсролтой мэргэжилтнүүд”, тэдний хувьд “жүжиглэх чадвар сайн хөгжсөн, хүмүүжилтэй, мөн түргэн өөрчлөгдөж байгаа нөхцөл байдлыг соргоогоор хүлээн авах чадвартай” гэж тодорхойлсон бол нөгөө талаас залилан мэхлэгч нь “хулгайн ертөнцийн элитүүд” гэж тооцож байна. Иймэрхүү байр суурь баримталж байгаа өөр бусад судлаачид ч бас байна.

Хоёрдугаар бүлгийн төлөөлөгчид, үүнээс өөр байр суурьтай байна. Тэдний судалснаар залилах гэмт хэргийг хэн ч үйлдэж чадах бөгөөд харин энэ салбарын гэмт явдал ихсэж байгаа нь үүсэн бий болж байгаа нөхцөл байдлаас болж байгаа болохоос биш энд хувь хүний ямар нэг зан чанар огтоос хамаагүй¹³⁸ гэж үзжээ.

Судлаачийн зүгээс энэхүү тодорхойлолтуудтай залилах гэмт хэргийг ямар ч хүн үйлдэж чадна гэдэгтэй нь санал нийлэхгүй байгаа бөгөөд учир нь тухайн тохиолдолд хувь хүний хүмүүжил, дотоод үнэт зүйлүүдийн тогтолцоо, бусад зарим нэг хувийн зан чанартай нь холбоотой хүчин зүйлсийг тооцон үзэх ёстой. Хэн боловч гэмт хэрэг үйлдэж чадах боловч залилах гэмт хэргийг бол тэр хүн болгон үйлдэж чадахгүй гэдэг нь эндээс харагдаж байгаа юм.

Монгол Улсын хувьд иргэдийн нийгмийн амьдрал түвшин, хөгжил, боловсролын байдал, сэтгэлгээний хандлага, ёс зүйн төлөвшил эрс ялгаатай байна. Ийм учраас цахим орчинд залилах гэмт хэрэг үйлдэж байгаа хувь хүний шинж төрхийг тусгайлан авч үзэх, судлах, зайлшгүй шаардлагатай юм.

Цахим орчинд залилах гэмт хэрэг үйлдэгч хүний хувийн шинж төрх, түүний онцлог нь гэвэл цахим залилах гэмт хэрэг үйлдэгчид нь компьютерын техникийн өндөр мэдлэг, мэдээллийн өндөр технологийн талаар зохих мэдлэг, түүнийгээ хэрэгжүүлэх дадлага чадвартай, тэр шинжээрээ бусдаас эрс ялгагдаж байдаг.

Гэмт хэрэг үйлдэх аргаа сонгохдоо тухайн этгээд өөрийн хүсэж байгаа зорилго, түүнд хүрэх арга зам хоёроо өөрийн чадал, чадвар, боломжтой харьцуулж байж шийдвэрээ гаргана. Энэ шийдвэр нь эцсийн дүндээ гэмт хэрэг үйлдэх үндсэн арга нь болж бодит байдалд хэрэгждэг байна.

Залилах гэмт хэргийн зарим нэг төрөл нь хэрэгжүүлэх үйлдлийнхээ хувьд нэлээдгүй ярвигтай байдаг тул гэмт этгээдээс нарийн “мэргэшил” шаарддаг байна. Ийм нөхцөлд гэмт хэрэгтнүүд урьдчилан тохирсон бүлэгт нэгдэх, эсвэл зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулдаг аргыг сонгож байна. Иймээс Монгол Улсын Эрүүгийн 17 дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт энэ талаар тусгайлсан заалт орсон байна.

Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүд нь дээд зэргийн дотоод эв нэгдэлтэй байдгийн дээр гүйцэтгэх үүргийн хувьд нарийн хуваарилагдсан байдаг онцлогтой. Ийм гэмт бүлэг нь тодорхой нэг нутаг дэвсгэрт залилах гэмт хэргийг олон давтамжтай, эсвэл байнга үйлдэх зорилготойгоор байгуулагдсан байна.

Цахим залилах гэмт хэрэг үйлдэгчдийн үйл ажиллагаа нь маш нарийн зохион байгуулалттай байдаг тул гэмт үйлдлийн зохион байгуулагч, гүйцэтгэгч, хамтран оролцогч нь бусдаасаа илүү гоц ялгарч байдаг онцлогтой тул үйл ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч нь цахим мэдээллийг бүтээх, дамжуулах өндөр арга, чадвар, мэдлэгтэй болох нь амьдралд нотлогддог байна.

¹³⁷ ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн “Гэмт хэрэгтний нийтлэг хэв шинж, сэтгэхүйн онцлог” (Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хоригдлын жишээн дээр) судалгааны тайлан.

-Уб., 2019

¹³⁸ Ивашенко, С.Б. “Бусдын үл хөдлөх хөрөнгийг хууль бусаар булаан эзэмшихэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага”. хууль зүйн докторын диссертацийн ажил. -М.1998. 48. дахь тал

Ийм бүлгийн үйлдсэн залилах гэмт хэргийг мөрдөн шалгахдаа тухайн орон өөр удирдах байгууллага болон хууль сахиулах байгууллага, нутгийн өөрийгөө удирдах тогтолцооны байгууллагын төлөөлөгчидтэй гэмт холбоо сүлбээтэй байх магадлалтайг онцгой анхаарах ёстой.

Сүүлийн жилүүдэд дээр нэрлэсэн хийсвэр ертөнц, гэмт хэргийн бодит ертөнц хоёр “нэгдэн ургаж төлжих” үзэгдэл ажиглагдах болж байгаа нь цаашдаа интернэт сүлжээ ашиглан үйлдэгдэх залилах гэмт хэрэг нь илүү боловсронгуй арга барил, үйлдлийн тогтолцоонд шилжиж болзошгүй аюулыг агуулж байна. Үүний үр дагавар нь ирээдүйд хууль сахиулах байгууллагуудын хооронд хэргийн харьяаллын талаар маргаан гарах, эсвэл өөр өөр чиг үүргийн байгууллагууд нэг гэмт хэргийн хойноос хөөцөлдөн мөрдөн шалгах ажиллагаа явуулах болж магадгүй байна.

Энэ байдлаас зайлсхийхийн тулд зөвхөн мөрдөн шалгах хамтарсан бүлэг байгуулах арга замыг боловсронгуй болгох, тухайн төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах анхан шатны ажиллагааны үед мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудын ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл солилцдог тогтолцоог бий болгох шаардлагатай юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн процессын хуульд¹³⁹ залилах гэмт хэргийн хохирогч нь гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд байхаар тусгагдсан байна. Тухайлбал, мөрдөн шалгах ажиллагааны гэмт хэргийн статистик тоон мэдээ, баримт бичиг, практик туршлагаас дүгнэн үзэхэд залилах гэмт хэргийн хохирогчийн үндсэн хэсэг нь хувь хүн байдаг нь тодорхой болж байна.

Залилах гэмт хэргийн хохирогч болсон тухай гомдол, мэдээлэл авагдсаны дараагаар биеэ хэрхэн авч яваа байдлыг нь харгалзан хохирогчийн тухайд дараах төрөлд хуваан авч үзэж болохоор байна.

1. Тухайн гэмт хэргт амжилттай мөрдөн шалгах ажиллагааг шалгаж, дуусгавар болохыг чин санаанаасаа хүсэн, хууль сахиулах байгууллагад шаардлагатай, өөрт нь илэрхий байгаа бүхий л мэдээллийг гарган өгч байгаа, бусад арга хэлбэрээр идэвхтэй дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа хэсэг;

2. Гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл гаргаснаар өөрийн үүргээ хязгаарлан, мөрдөн шалгах ажиллагааны талаар ямар нэг сонирхолгүй байдаг юм уу эсвэл залилан мэхлэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар огтхон ч ямар нэг үйлдэл огт хийдэггүй идэвхгүй хэсэг гэсэн хоёр хэсэг байна гэж үзэж байна.

3. Мөрдөн шалгах ажиллагааны үед өөрийн нэр төрийг эрхэм болгож нөхцөл байдлыг нуун дарагдуулдаг, түүнчлэн ямар нэг байдлаар мөрдөн шалгах ажиллагаанд эсэргүүцэл илэрхийлдэг хэсэг байгаа гэдгийг нэмэх саналтай байна. Ийм хохирогч нь зөвхөн хувь хүн, хуулийн этгээд байж болохыг энд зориуд тэмдэглэх нь зүйтэй. Ийм хачин байдлаар өөрийн хандлагаа илэрхийлэх болсон шалтгаан нь юуны өмнө хохирогч талын ажил хэргийн нэр хүндээ алдах, эсвэл хувийн амьдралтай нь холбоотой аливаа нууц задрахаас айх аюул гэх зэрэгтэй нь холбоотой байж болох юм гэж үзэж байгаа юм.

Хохирогчийн гаргаж байгаа ийм байдал нь залилан мэхлэх гэмт хэргийн далд нуугдмал байдлыг өөгшүүлж байгаа үндсэн нэгэн шалтгаан байж ч болно.

Дүгнэлт:

1. Интернэт нь зөвхөн мэдээлэл дамжуулах боломжтой тодорхой орчин, нөхцөл гэдгийг анхаарвал цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн халдлага нь зөвхөн өмч хөрөнгийг олж авах эрхэд чиглэгдсэн байна гэж үзэж болно. Интернэтийн орчин материаллаг ертөнцийн бүх шинжийг агуулдаггүй учир зөвхөн хийсвэр байдлаар материаллаг гэж тооцож болох юм. Судлаачийн үзэж байгаагаар, материаллаг бус боловч материаллаг ертөнцийн объект болж байгаа ийм нөхцөлийн тухайд хийсвэр виртуал ертөнц, хийсвэр орчин гэсэн ойлголтоор авч үзэх нь зүйтэй байна.

2. Орчин үед ихэнх тохиолдолд хувийн онцгой байдлаасаа хамаарч мөнгө залилан мэхлэгчийн анхаарлыг ихэд татах болсон учир залилах гэмт хэргийн халдлагын зүйл болох нь улам

¹³⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. -Уб., 2017

түгээмэл болж байна. Харин бусад өмч хөрөнгө, түүний төрөл зүйл болон өмчлөх эрхийн тухайд бол мөнгөтэй зөвхөн дүйцүүлж болох юм. Учир нь тэдгээрийг яг одоо биш ч дараа нь зарж борлуулснаар бас л мөнгө болох учиртай.

3. Өнөө үед өмчлөх эрх гэдэгт чухам юуг ойлгох талаар эрүүгийн эрх зүйн нарийн тодорхойлолт байхгүй байгаа учраас өмчтэй холбоотой гэмт хэргийг бүрэн төгссөн гэж үзэх, хугацааны талаар, өөрөөр хэлбэл тухайн өмчийн хувьд захиран зарцуулах бүрэн эрхийг нь олж авсан, эсвэл ямар нэг хэмжээгээр эзэмших, ашиглах эрхтэй болсон үед үү гэдэг асуулт нээлттэй хэвээр байна.

Өмчлөх эрх, эдгээр эрхийн багтаамж нь тодорхой хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан байдаг, гэмт халдлагын зүйл нь өмчлөх эрх байгаа тохиолдолд, тухайн бичиг баримтад дурдсанаар хохирогч ямар эрх эдэлж байсан, тэр эрхийг гэмт этгээд өөртөө нэгэнт шилжүүлэн авсан тэр үед тухайн төрлийн гэмт хэргийг бүрэн төгссөн гэж тооцох ёстой. Харин тодорхой төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тухайлбал, худалдах, худалдан авах эрхийн тухайд бол үүнээс өөрөөр шийдвэрлэгдэнэ.

4. Сүүлийн жилүүдэд бидний дээр нэрлэсэн хийсвэр ертөнц, гэмт хэргийн бодит ертөнц хоёр “нэгдэн ургаж төлжих” үзэгдэл ажиглагдах болж байгаа нь цаашдаа цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь илүү боловсронгуй арга барил, үйлдлийн тогтолцоонд шилжиж болзошгүй аюулыг агуулж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн эрх зүйн хуульд залилах гэмт хэргийн улмаас бие мах бодь, өмч хөрөнгө, ёс суртахууны хор хохирол хүлээсэн бол хувь хүн, харин өмч хөрөнгийн юм уу эсвэл үйл ажиллагааны нэр хүндийн хувьд хор хохирол хүлээсэн бол хуулийн этгээд, хохирогч байхаар тусгагдсан байдаг. Практикаас харвал залилах гэмт хэргийн хохирогчийн үндсэн хэсэг нь хувь хүн байдаг нь тодорхой байгаа юм.

Санал:

1. Залилах гэмт хэргийн үндсэн арга нь гэмт этгээд бусдын өмчийг хууль бусаар олж авах, тийм эрхийг олж авах гэсэн эцсийн зорилгодоо хүрэх дундаж үр дүн болгож, тухайн өмчийн эзэмшигч, эсвэл эзэмшигчийг төөрөгдөлд оруулахад чиглэгдсэн байдаг. Ийм нөхцөл байдал байхгүй бол тухайн үйлдэл нь залилах гэмт хэргийн шинжгүй гэж үзэх, харин онцгой арга хэрэглэн бусдын өмчийг хулгайлсан гэмт хэргийн нэгэн төрөл болно. Ийм учраас залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн өнөөгийн тодорхойлолтод шинээр “өөрийн болгох” гэдэг нэр томьёо нэмж оруулах саналыг оруулж байна.

2. Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг болон компьютерын тоон төхөөрөмж ашигласан бусад төрлийн гэмт хэрэг нь туйлын далд нуугдмал шинжтэй гэмт хэргүүдийн тоонд зүй ёсоор тооцогдож байна. Иймд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх хүн амын итгэлийг дээшлүүлэх чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах нь зүйтэй гэсэн саналтай байна. Ингэснээрээ мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлдэг хохирогчийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлээд зогсохгүй, илүү өргөн хүрээний мэдээлэл олж цуглуулах, эцсийн дүндээ цахим орчинд үйлдсэн гэмт хэргүүд, ялангуяа залилах төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд чанарын өөрчлөлт хийх боломжийг нэмэгдүүлнэ.

Ашигласан материалын жагсаалт

1. Туяа, Б. Компьютерын мэдээлэлд хууль бусаар нэвтрэх гэмт хэргийг мөрдөх ажиллагаа. - УБ., 2013.

2. Халтар, Т. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (кибер) гэмт хэргийг мөрдөн шалгах онцлог. УБ., 2019.

3. Хишигтогтох, Б нар. Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс. -УБ., 2015.

4. Хурцгэрэл, Ж. Криминалистик. -УБ., 1985.

5. Цэрэндаваа, Ц. Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ.-УБ., 2020.

6. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эерэг (Кибер) гэмт хэргийн судалгаа. -УБ.. 2019

**ЭЗЭН ХОЛБОГДОГЧ НЬ ТОГТООГДООГҮЙ МАЛ ХУЛГАЙЛАХ
ГЭМТ ХЭРЭГТ МАТРИЦЫН АРГААР ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХҮРСЭН ҮР ДҮН
THE RESULTS OF ANALYZING THE CRIME OF CATTLE
THEFT WITH AN UNIDENTIFIED PERPETRATOR USING
THE MATRIX METHOD**

Эрүүгийн цагдаагийн албаны Хулгайлах
гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, докторант,
цагдаагийн хурандаа Н.Ууганбаяр
Mr. N.Uuganbayar, Chief of Anti-Theft Division of
Criminal Police Department, PhD student,
Police Colonel

Хураангуй: Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй мал хулгайлах гэмт хэргийн статистик судалгаанд үндэслэн матрицын аргыг ашиглан дүн шинжилгээ хийж гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох тухай

A brief meaning: Based on the statistical study of livestock theft, where the perpetrator has not been identified, analyzing using the matrix method and determining measures to detect and stop the crime, and to take further measures

Түлхүүр үгс : Мал хулгайлах гэмт хэрэг, үйлдлийн арга, матриц, таамаглал, магадлал, бүлэг этгээд, цахим гарал үүслийн гэрчилгээ

Keywords: Cattle theft, method, matrix, prediction, probability, gang, electronic origin certificate

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Б/69 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг байгуулан тасгийн дарга 1, эрүүгийн ахлах мөрдөгч 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2022 онд мал хулгайлах 778 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 35 нэгжээр буюу 4,7 хувиар өссөн, бүртгэгдэх үедээ эзэнгүй байсан хэрэг бүртгэлтийн 778 мал хулгайлах гэмт хэргээс 414 хэргийг илрүүлж, илрүүлэлт 60.3 хувьтай өмнөх оноос 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

Монгол Улсад бүртгэгдэж буй мал хулгайлах гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж, үйлдлийн арга нь нарийн, зохион байгуулалтын шинжтэй болж байгаа өнөө үед цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх уламжлалт арга барилаас гадна шинжлэх ухааны үндэслэлтэй, онолд суурилсан олон улсын туршлага, арга, тактикаас суралцах, дэвшилтэд арга технологийн ололт амжилтыг гэмт хэрэгтэй тэмцэх ажилдаа нэвтрүүлэх, нутагшуулах шаардлага гарч байна.


Энэхүү хэрэгцээ шаардлагад нийцүүлэн матрицын аргыг гэмт хэрэгтэй тэмцэх түүний дотор гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд нэвтрүүлэх боложийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэхийг зорьлоо.

Сүүлийн үед бүртгэгдэж буй гэмт хэргийн үйлдлийн аргууд нь гадаад улс орон дамжсан, бүлэг зохион байгуулалтын шинжтэй, нарийн төлөвлөдөг, их хэмжээний хохирол учруулдаг, төрийн албан тушаалтан нар хамтран оролцдог, цахим хэрэгсэл болон дэвшилтэд техник технологи ашигладаг болсонтой холбоотойгоор гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэх,

нотлох баримт цуглуулах болон тухайн гэмт хэргийг илрүүлэхэд хүндрэл үүсэж байна. Иймд бид цаашид гэмт хэргийг илрүүлж буй арга, ажиллагаандаа шинэ санаа, иноваци нэвтрүүлэх, бусад гадаад улс орны ашиглаж буй арга, техник технологийг нэвтрүүлэх нь чухал болжээ.

Нийслэлийн хэмжээнд 2022 онд 42 мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оноос 6 нэгжээр буюу 14.2 хувь буурч илрүүлэлт 0 хувьтай байна. Хэргийн гаралтыг дүүрэг тус бүрээр харуулбал:

Мал хулгайлах гэмт хэргийн 2022 оны илрүүлэлт:



Энэхүү статистик тоон судалгаанд дурдагдсан Нийслэлийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх ажил 0% тай байгаа нь анхаарал татсан. Нийслэлд оршин суудаг мал бүхий иргэдтэй дүүргүүдийн цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэргийг харьцуулахад;

Тус 2022 онд мал хулгайлах гэмт хэргийн шинжтэй 141 гомдол, мэдээлэл хүлээн авч /Налайх дүүрэгт-1, Багануур дүүрэгт-9, Багахангай дүүрэгт-1, Баянзүрх дүүрэгт-21, Сонгинохайрхан дүүрэгт-74, Сүхбаатар дүүрэгт-1, Хан-Уул дүүрэгт-31/ шалгаж 47 гомдол, мэдээлэлд хээг бүртгэлтийн хэрэг нээж /Сонгинохайрахан дүүрэгт – 22, Хан-Уул дүүрэгт – 19, Баянзүрх дүүрэгт – 5, Сүхбаатар дүүрэгт – 1/ 64 гомдол, мэдээллийг татгалзаж шийдвэрлэсэн байв¹⁴⁰.

Энэхүү 47 хэргийн түүвэр гаргаж илэрсэн ул мөр, мэдээ, мэдээлэлд түшиглэн Матрицын аргаар дүн шинжилгээ хийхэд дараах таамаглал тодорхойлогдсон.

Матрицын арга ашигласан жишээ /1-5 хүрэлт тоон илэрхийлэлээр магадлалыг тооцоолсон болно/

¹⁴⁰ www.guide.police.gov.vt/file/ Статистик тайлан 2022 он мэдээ

д/д	Таамаглал Эд мөрийн баримт болон бусад нотлох баримт	1.Бүлэг этгээдүүд үйлдсэн	2. Тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн	3.Ганцаараа үйлдсэн	4.Тууварласан	5. Хөлөөрөө алга болсон	6.Нийслэлийн зах, худалдааны төв, дэлгүүрт зарж борлуулсан	7.Нийслэлээс өөр газар нутаг руу тээвэрлэлэг	8.Худалдан авдаг ченж, эич нартай холбоотой байх талтай	9.урьд өмнө энэ төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн этгээд	10. Нийслэлийн баруун дүүргүүдтэй хил залгаа аймгийн бүлэг этгээдүүд	11.Нийслэлийн зүүн дүүргүүдтэй хил залгаа аймгийн бүлэг этгээдүүд	12. Өмнө зүгийн аймгуудийн бүлэг этгээдүүд
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1.	Нийт 47 хэргээс СХД-т 22, ХУД-т 19 буюу 87,2% нь нийслэлийн баруун зүгийн дүүргүүдийн нутаг хамарч байна	5	5	2	3	2	5	2	5	5	5	2	2
2.	Хэрэг үйлдэгдэж байгаа цаг хугацаагаар нь үзэхэд орой, шөнийн цагаар буюу 17-06 цагийн хооронд 55,3% нь үйлдэгдсэн	5	5	5	5	3	5	5	5	5	5	5	5
3.	Гэмт хэргийн хадлагад 54 үхэр, 26 адуу, 1 ямаа өртсөн байна.	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
4.	3 дүүргийн нутагт 26 хэргийн 31 үхэр, 4 адуу нь нядлагдаж гэдэс, толгой, арьс нь хэргийн газарт үлдсэн, тээврийн хэрэгслийн мөртэй	5	5	2	0	0	5	2	5	5	5	2	3
5.	2 дүүргийн нутагт 3 хэргийг үйлдэхдээ айлын хашаанаас нь хөтөлж гаргасан байдаг	5	4	5	5	0	5	5	5	5	5	2	2
6.	СХД-ийн нутагт 1 үйлдэл чөдөртэй морь хулгайлсан	5	5	5	0	0	4	5	4	5	5	3	3
		30	29	24	18	10	29	24	29	30	30	19	20

Матрицын аргын үр дүнд Нийслэлийн дүүргүүд дэх мал хулгайлах гэмт хэргийг “урьд өмнө энэ төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлж байсан, тээврийн хэрэгсэл ашиглаж шөнийн цагаар үйлддэг, гарал үүсэл бичиж өгдөг малын эмч, худалдан авч борлуулдаг ченж нартай холбоотой байж болзошгүй бүлэг этгээдүүд үйлдсэн байх магадлал илүү их нийцэж байна. Уг бүлэг нь СХД, ХУД-ийн нутаг дэвсгэрээс ихэнх хадлагаа үйлдээд байгаа нь газар зүйн байршлаараа онцлог гэж гарсан.

Шалгалтын ажиллагааг урьд өмнө тээврийн хэрэгсэл ашиглаж мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж байсан бүлэг этгээдүүд рүү чиглүүлсэний үр дүнд “Л” нарын 11 бүлэг этгээдүүд Архангай, Булган, Төв аймгийн нутаг дэвсгэрээс 2019, 2020, 2021, 2022 онуудад 40 удаагийн үйлдлээр 416 тооны бод мал хулгайлсан 1.2 тэрбум төгрөгний хохирол учруулсан хэргийг илрүүлэн шүүхэд шилжүүлээд байна.

Бүлэг этгээдүүдийг үйлдийн арга, зохион байгуулалтыг судалж үзэхэд мал, махын цахим гарал үүслийн гэрчилгээ улсын хэмжээнд хэрэгжиж хэвшил болсон хэдий ч Нийслэл хотын зах, худалгааны төвүүдэд нийлүүлэх үеийн хяналт сул, мал, мах худалдан авч байгаа ченж нар гарал үүслийн гэрчилгээтэй, гэрчилгээгүй худалдаж авдаг, малын эмч нарыг гэрчилгээ олголт замбараагүй байгаа нь тогтоогдсон.

Хууль зүй дотоод хэргийн яамны Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар Нийслэлийн томоохон мал, мах худалдан орлуулдаг зах худалдааны төвүүдэд олон нийтийн цагдаа ажиллуулах саналыг хүргүүлсэний үр дүнд Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргаас мал, мах худалдан борлуулдаг 40 зах, худалдааны төвүүдэд олон нийтийн 10 цагдааг ажиллуулах зөвшөөрөл гарсан.

Ийнхүү 2023 оны 03 дугаар сарын 01-наас 40 зах худалдааны төвүүдэд хөдөө орон нутгаас бэлтгэн нийлүүлэгдэж байгаа мах, махны шилжилт хөдөлгөөн, мал эмнэлгийн цахим гэрчилгээнд хяналт тавьж, 214.556 ширхэг цахим гарал үүслийн гэрчилгээг шалгаж, мал эмнэлгийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэсэн зөрчил гаргасан 78 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дах хэсэгт зааснаар 11.700.000 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 5 гэмт хэрэг илрүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаартай тушаалаар мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж, амьдралын эх үүсвэрээ болгосон “Д” гэгч этгээдийн гэмт үйлдлийг баримтжуулан шалгаж, эрүүгийн хариуцлагад татах үүрэг бүхий 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулахад “Д” нь бусад 15 этгээдийг удирдан зохион байгуулж Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгуудын нутгаас 2021 оноос хойш 20 удаагийн үйлдлээр иргэдийн 47 тооны бод, 101 тооны бог нийт 148 тооны малыг зохион байгуулалттайгаар тээврийн хэрэгсэл ашиглан хулгайлан нядалж Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд байрлах “Эмээлт” зах, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хүчит шонхор” худалдааны төвд мал махны ченж ажилтай “Ж”, “У”, Дархан-Уул аймагт мал, махны ченж ажилтай “Б” нарт худалдан борлуулж, Баянзүрх дүүргийн малын эмч “М”-ээс гарал үүслийн цахим гэрчилгээг гаргуулж авч иргэдэд 86.100.000 төгрөгийн хохирол учруулсныг тогтоон хэргийг шүүхэд шилжүүлээд байна.

Мөн яллагдагч “Э”, “А”, “Б”, “Б” нар нь зохион байгуулалттайгаар Төв аймгийн Баянхангай, Лүн, Заамар, Цээл, Эрдэнэсант, Эрдэнэ, Баян, Баян-Өнжүүл, Угтаалцайдам сумдын нутгаас 2022 оноос хойш 21 удаагийн үйлдлээр иргэдийн 79 тооны бод малыг зохион байгуулалттайгаар тээврийн хэрэгсэл ашиглан хулгайлж Сонгинохайрхан дүүргийн “Эмээлт” зах, Налайх дүүргийн “Ундарга Хайрхан” зах, Чингэлтэй дүүргийн “Хүчит шонхор” худалдааны төвд мал, махны ченж ажилтай “Б”, “Д”. “А” нарт худалдан борлуулж, иргэдэд 104.5 сая төгрөгийн хохирол учруулсан болохыг тогтоож Мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Энэхүү 2 бүлэг этгээдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд цахим гарал үүслийн гэрчилгээгүй зах зээлд хулгайлах гэмт хэргийн замаар авчирч байгаа мал махыг худалдан борлуулах асуудал хязгаарлагдсан байна. Харин малын эмч нарыг хуурч мэхлэх, өөр малын зураг үзүүлэх, бусдын нэр дээр гарал үүсэл гаргуулж авах, нэг удаагийн гарал үүслийн бичгээр хэд хэдэн газарт 2-5 удаа хулгайн мал, махаа худалдан борлуулж байгаа нь тогтоогдсон. Харин цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж буй олон нийтийн цагдаа нарт хулгайн малын бодит зураг, мэдээлэл сан бол үлдэж байгаа нь бүлэг этгээдүүдийн гэмт үйлдэл тус бүрийг илрүүлэх, нотлох баримт бүрдүүлэхэд бодит үр дүнгээ өгч байна.

Дүгнэлт

1. Матрицын аргыг гэмт хэрэг илрүүлэх ажилд нэвтрүүлсэнээр эзэн холбогдогч нь тогтоогдоогүй мал хулгайлах гэмт хэргийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж болохоор байна.

2. Гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд матрицын аргыг ашиглах арга зүйн талаар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдад сургалт орох, энэ аргыг эзэмшүүлэх;

Ашигласан материал

1. Матрицын түүх History of a Matrix -youtube.com Babarinsa Olayiwola, Oct 11, 2021
5. www.guide.police.gov-/file/ Статистик тайлан 2022 он мэдээ

МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ ЖАГСААЛ,
ЦУГЛААНЫ ЯВЦ, ӨРНӨЛИЙГ ШИНЖИХҮЙ
THE ANALYSIS OF THE PROCESS OF PROCESSION AND
ASSEMBLY IN MONGOLIA

*Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч
Б.Чинтамир
Postgraduate of Police study
Police first lieutenant
B.Chintamir*

Хураангуй. Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д заасан “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэсэн зүйл, заалтыг үндэслэн жагсаал, цуглаанд оролцох, үгээ хэлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрхээ эдэлдэг. Гэвч сүүлийн жилүүдэд жагсаал, цуглаанд оролцогчид Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасан эрх зүйн хүрээнд оролцохгүй, зохион байгуулалтгүй, хийсэн аливаа хууль бус үйлдлээ хүний эрх нэрийн дор халхавчлах замаар хууль зөрчих явдал түгээмэл гарах боллоо.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад сүүлийн 10 жилийн хугацаанд жагсаал, цуглаан зохион байгуулагдаж байгаа үйл явц, хэлбэр, оролцогчдын гаргаж үйлдлийг шинжилж, судлаачийн байр сууринаас өөрийн үзэл бодлын талаар бичсэн болно.

Abstract. According to Article 16 of the Mongolian Constitution, which states that citizens have the following rights: "freedom of belief, free expression of opinion, speech, publication, peaceful procession and assembly," a citizen of Mongolia may join in procession and assembly, speak, and publish. Therefore, by disorganizing them and disguising their illegal conduct under the pretense of human rights, procession and assembly participants have failed to comply with the legal framework outlined in the Law on the Procedures for procession and assembly in recent years.

This study, conducted by me as a researcher, evaluates the procedures, formats, and behaviors of procession and assembly participants in Mongolia over the course of the last ten years in order to confirm legal conformity.

Түлхүүр үг. Жагсаал, цуглаан, зохион байгуулагч, оролцогч, цагдаа, замын цагдаа, тээврийн хэрэгсэл

Key word. Procession, assembly, organizers, participants, police, traffic police, vehicles

Оршил хэсэг. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгийн түгээмэл хэлбэр бол жагсаал, цуглаан билээ. Өнөөдөр Монгол улсад Үндсэн хуулиар олгогдсон эрхийн хүрээнд өөрийн сонгосон аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг. Эдгээр аргуудаас тайван жагсаал, цуглаан хийх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх нэг үндсэн арга бөгөөд иргэдийн улс төрийн үндсэн эрхийн нэг юм.

Хүн өөрийн хүсэл зоригоо хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд тодорхой хүрээнд хэрэгжүүлэх зан үйлийн боломжийг хүний эрх, эрх чөлөө гэж ойлгоно.¹⁴¹

¹⁴¹ Нармандах, Б. Үндсэн хуулийн эрх зүй. -УБ. 2010. 107 дахь тал

Улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа төрд болон олон нийтэд илэрхийлэх зорилгоор тайван жагсаал, цуглаан хийх эрх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид баталгаажсан байдаг.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичиг зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан хүний үндсэн эрх юм. Энэ нь ардчилсан нийгмийн үндэс суурь болж, хүн бүрт өөрийн санал нийлэхгүй, эсвэл өөр үзэл бодолтой байгаа талаараа олон нийтэд илэрхийлэх боломжийг олгодог. Улс орнууд энэ эрхийг хүндэтгэж, хамгаалж, биелүүлэх үүрэгтэй.¹⁴²

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь хүний үндсэн эрх, тийм ч учраас ардчилсан нийгмийн тулгын чулууны нэг гэж үздэг. Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь нь олон улсын хүний эрхийн бүх гол баримт бичигт тусгагдсан байдаг. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйл (1948) ;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйл (1966);
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенцийн 11 дүгээр зүйл (1950);
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 15 дугаар зүйл (1989)¹⁴³.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь бүх хувь хүн, нийгмийн бүлэг, бүртгэлгүй холбоод, хуулийн этгээд, аж ахуйн нэгжид хамаарна. Олон улсад хүний үндэс угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн болон бусад статус зэрэг дээр нь үндэслэн аливаа ялгаварлан гадуурхлыг хориглодог. Иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлахад чиглэсэн дээрхи үндэслэлээр ялгаварлан гадуурхах нь олон улсын хүний эрхийг зөрчсөн гэж үздэг. Тухайлбал:

- “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”¹⁴⁴-ын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй”

- “Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт” -ын 21 дүгээр зүйл “Тайван замаар цуглаан хийх эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд улсын буюу нийгмийн аюулгүй байдал, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт байж болохгүй.”¹⁴⁵

Олон улсын зарчимд “Хууль бус боловч аливаа хүч хэрэглээгүй жагсаал цуглааныг тараахдаа хэв журам сахиулах албан тушаалтан хүч хэрэглэхээс аль болохоор зайлсхийх ба хэрэв хүч хэрэглэх нөхцөл бүрэлдвэл хамгийн наад захын гарцаагүй байдлыг хүртэл хязгаарлах хэрэгтэй” гэж заажээ. Хууль бус жагсаал цуглааныг тайван замаар хохирол багатай зохицуулан тараах нь цагдаагийн удирдлагын нэн тэргүүнд тавих зорилго байдаг.¹⁴⁶

Манай улсын хувьд иргэн, хуулийн этгээд жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцохтой холбоотой харилцааг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар тусгайлан зохицуулдаг. Тухайлбал, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 4.1 “Жагсаал,

¹⁴² Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага. /орчуулгын бүтээл/. - УБ., 2022. 8 дахь тал

¹⁴³ <https://legalinfo.mn>. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. //Татаж үзсэн: 2023.09.12.

¹⁴⁴ <https://legalinfo.mn>. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. //Татаж үзсэн: 2023.09.12. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A/III тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. Монгол Улс 1961 онд НҮБ-д элсэж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болж, энэ үеэс НҮБ-аас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөний тухай олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, хүний эрх, эрх чөлөөг хангах үүрэг, хариуцлагыг НҮБ-ын өмнө хүлээсэн.

¹⁴⁵ Чулуун, Ш. Жагсаал, цуглаан, онцгой нөхцөл байдлын үед нийгмийн хэв журам сахиулах ажиллагаанд баримтлах эрх зүйн актын эмхтгэл. -УБ., 2013. 183 дахь тал

¹⁴⁶ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. –УБ., 2018. 45-46 дахь тал

цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй”, 4.2 “Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй”¹⁴⁷ гэсэн заалтуудыг үндэслэн иргэн, хуулийн этгээдүүд жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн үндэс нь тодорхойлогдож байна.

Үндсэн хэсэг. Олон нийтийн аюулгүй байдал ихэвчлэн олон хүн цугларсан газарт алдагдах магадлал өндөр байдаг. Олон нийтийн газар гэдэгт гудамж, талбай, бүх төрлийн үйлчилгээний газар, зорчигч тээврийн буудал, нийтийн тээврийн хэрэгсэл, орон сууц, нийтийн байр, худалдааны төвүүд болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын нутаг дэвсгэр хамаарна. Өөрөөр хэлбэл ямар зорилгын хүрээнд иргэд олноор цугларан тодорхой төвлөрлийг бий болгосон газар орчныг хэлж болно. Түүнчлэн хөдөө, хээр хүнгүй газар томоохон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдах үед тухайн газар нь түр хугацаагаар олон нийтийн газар болно. Тухайлбал даншиг наадам, спортын уралдаан тэмцээн, соёл, урлагын арга хэмжээ зохион байгуулагдах үед олон нийтийн газар болно.

Олон нийтийн арга хэмжээний хамгийн түгээмэл хэлбэр нь жагсаал, цуглаан билээ. Монгол Улсын иргэн жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, ЕАБХАБ¹⁴⁸/АИХЭГ болон Венецийн комиссын Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн тухай удирдамж¹⁴⁹-ид жагсаал, цуглааныг тодорхойлохдоо жагсаал, цуглаан гэдэг нь хэн нэгэнд ямар нэг зүйлийн талаар хэлэх зүйлээ дамжуулах зорилготой арга хэмжээ гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Хэдийгээр жагсаал, цуглаан нь ихэвчлэн түр зуурын шинж чанартай байдаг ч хагас-байнгын бүтэцтэйгээр хэдэн сарын турш ч үргэлжлэх боломжтой. Жагсаал, цуглааны тодорхой хэлбэрүүд нь эрх зүйн зохицуулалтын хувьд өөр өөр асуудлуудыг үүсгэж болох ч хөдөлгөөнгүй, хөдөлгөөнтэй бүх төрлийн тайван жагсаал, цуглааныг зохицуулах ёстой.¹⁵⁰

Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэх нь хамтын үзэл бодлоо дамжуулах, саналаа илэрхийлэх хэрэгсэл юм. Үүнд, олон янзын, шүүмжлэлт, радикал буюу эрс шинэчлэлт, нийтлэг бус болон цөөнхийн зэрэг олон үзэл бодлын илэрхийлэл ордог. Радикал болон цөөнхийн үзэл бодлыг илэрхийлэх нь нийгмийн бусад гишүүдэд тодорхой хэмжээгээр доромжлон халдаж байгаа мэт болов ч, үйл ажиллагаа нь тайван хэвээр байгаа цагт хамгаалж, зохицуулах ёстой болно. Жагсаал, цуглааны нэлээдгүй нь өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой хэмжээний саад учруулдаг, зам, гудамж талбайг эзлэх, хаах, эсхүл замын хөдөлгөөн, явган зорчигч, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсгэдэг.

Иргэний үндсэн эрх чөлөөгөө хэрэгжүүлэхээс үүдэлтэй ийм саад тасалдалд ямар нэг хэмжээгээр хүлээцтэй хандах ёстой. Нийтийн эзэмшлийн талбай нь бусад төрлийн үйл ажиллагаа явуулахтай адил хүмүүсийн жагсаж, цуглах боломжтой газар гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд тийм ч учраас энэхүү жагсаж, цуглах эрхийг зохицуулж өгөх ёстой. XXI зууны эхээр олон улсын үйл явц марксист буюу социалист радикал хандлага бус капиталист авторитар төрийн тогтолцоог хамгаалах хандлага руу орох болсон.¹⁵¹

¹⁴⁷ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

¹⁴⁸ ЕАБХАБ – Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага

¹⁴⁹ <http://www.osce.org>. //Татаж үзсэн: 2023.09.11. Тайван жагсаал цуглаан хийх эрхийн тухай удирдамж, 2 дахь хэвлэл, (Варшав: ЕАБХАБ/АИХЭГ/Венецийн Комисс, 2010)

¹⁵⁰ Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага. /орчуулгын бүтээл/. УБ., 2022. 16 дахь тал

¹⁵¹ <https://journal.num.edu.mn> //Татаж үзсэн: 2023.09.05

Хүн үзэл бодлоо үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх замаар илэрхийлдэг бөгөөд ингэхдээ бүх нийтийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, иргэдийн эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөнд хохирол учруулах ёсгүй.¹⁵²

Тайван гэдэг нь нийтийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй, эмх замбараагүй байдал үүсгэхгүй, хүчирхийлэл халдлага, үймээн самуун дэгдээхгүй гэсэн санааг илэрхийлдэг. Энэ нь иргэдийн хүрээлэн буй орчин тойронд болж буй аливаа шударга бус үйлдэлд санаа бодлоо ухаалаг, тайвнаар илэрхийлэх арга зам бөгөөд ингэснээр ойлголцол, дэмжлэгийг бий болгох нөхцөл бүрдэх боломжтой гэж үздэг.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3.1 “Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэнэ”, 3.2 “Иргэд хот суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэнэ”¹⁵³ хэмээн тус тус тодорхойлсон.

Жагсаал, цуглаан нь зорилгын хувьд адилхан боловч, хэлбэрийн хувьд ялгаатай. Жагсаал нь хот суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, үзэл бодлоо илэрхийлдэг бол, цуглаан нь тодорхой нэг газар, орчинд суурин хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх байдлаар ялгаатай байдал нь илэрдэг. Гэвч энэ нь жагсаал, цуглааны хэлбэрийг тодорхойлж байгаа гол зохицуулалт гэж үзэж болох бөгөөд хэрхэн ямар байдлаар зохион байгуулах арга зүйн талаар нарийвчлан тусгасан зохицуулалт байхгүй байгаа нь эрх зүйн тулгамдсан асуудал гэж үзэж болохоор байна.

Монгол Улсад сүүлийн 10 жил /2014-2023.05/-ийн байдлаар зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээ, үүнээс жагсаал, цуглааны тоо, тэдгээрийн бүртгэлтэй эсэх талаар судалгаа авч үзвэл:

Хүснэгт №1. Жагсаал, цуглааны тоо сүүлийн 10 жилийн байдлаар

№	Огноо	Нийтийг хамарсан арга хэмжээ	Жагсаал цуглааны тоо	Өлсгөлөн, суулгын тоо	Үүнээс				
					Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Жагсаал	Цуглаан	Үндэсэрхэг үзэлтэй
1	2014 он	204	115	5	10	105	38	44	2
2	2015 он	228	140	2	19	121	51	64	1
3	2016 он	195	121	1	14	107	30	58	0
4	2017 он	201	128	3	13	115	31	65	3
5	2018 он	298	180	0	10	170	28	51	4
6	2019 он	350	206	4	21	185	54	89	7
7	2020 он	323	255	3	16	239	44	98	8
8	2021 он	468	214	11	0	214	25	128	4
9	2022 он	420	241	8	44	197	31	210	18
10	2023 он 5 сар	295	132	2	38	94	34	98	4
11	Нийт	2982	1732	39	185	1547	366	905	51

¹⁵² Нармандах, Б. Үндсэн хуулийн эрх зүй. -УБ., 2010. 110 дахь тал

¹⁵³ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

Дээрхи хүснэгтээс үзвэл Монгол Улсын хэмжээнд 2021, 2022 онуудад хамгийн их жагсаал, цуглаан зохион байгуулагдсан нь харагдаж байгаа бөгөөд энэ нь тухайн үеийн нийгмийн шинжтэй олон явдлаас үүдэлтэй бөгөөд жагсаал, цуглааны өсөлт, бууралтыг доорхи графикаас харж болно.

График №1. Жагсаал, цуглааны өсөлт, бууралт



Дээрхи графикаас үзвэл 2014-2017 оны хооронд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны тоо харьцангуй тогтвортой байсан бол 2018 оноос нэмэгдэх хандлагатай болж, 2019 онд 52 нэгжээр нэмэгдэж, 2020 онд 49 нэгжээр нэмэгдэж, харин 2021 онд 41 нэгжээр буурсан үзүүлэлттэй боловч, жагсаал, цуглааны хамрах хүрээ нь улам нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд хуулийн 9 дүгээр зүйл /Жагсаал, цуглаан хийх журам/-ийн 9.1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ” гэж заасан байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж, жагсаал, цуглаан зохион байгуулах явдал улам нэмэгдэх хандлагатай болж байна.

График №2. Жагсаал, цуглааны бүртгэл



2021 онд болсон жагсаал, цуглааны дийлэнх нь дэлхий дахинд гарсан цар тахал болох COVID 19 өвчний улмаас иргэдийн хөдөлгөөн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг ихээр хязгаарласан, нийгмийн халамж нэмэгдүүлэхтэй холбоотойгоор гарч байсан бол, 2022 онд төр засгаас эдийн засгийн хямралыг даван гарахтай холбоотой бодлого, шийдвэр төрийн эрх бүхий зарим албан тушаалтнуудын холбогдсон нүүрсний хулгай, түүнд анхаарлаа хандуулж шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, мөн зарим нэг олны анхааралд орсон хэргийн явц байдал, шийдвэрлэлт, түүнчлэн ОХУ, Укрианы дайнтай холбоотой иргэдийн үзэл бодлын зөрчилдөөнтэй байдлаас үүдэлтэй жагсаал цуглаан ихэнхи хувийг нь эзэлж байна. Жагсаал, цуглаанд оролцогдын тавьж буй шаардлагыг түүвэрлэн авч үзвэл:

- 2022 оны 4 дүгээр сард залуучууд төр, засгаас сонгуулиар амалсан амлалтаа хэрэгжүүлэх;

- 2022 оны 12 дугаар сард жагсагчид нүүрс тээвэрлэлтийн авлигатай холбоотой нүүрсний хулгайчдаа ил зарлаж, УИХ-ыг тараах болон авлигын албан тушаалтнуудад хуулийн хариуцлага тооцох;

- Хөгжлийн банкны луйврын хэрэг үнийн өсөлт, эдийн засгийн хямралын эсрэг тэмцэх арга замаа тодорхой болгох;

- Эдийн засгийн хямралыг даван туулах бодлогоо Засгийн газар УИХ-аар батлуулах, төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх гэх мэт шаардлагуудыг тавьсан байдаг.

Түүнчлэн энэхүү жагсаал, цуглаануудын үеэр жагсагчид дараах хууль бус үйлдлүүдийг гаргаж, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэхийг санаархсан. Тухайлбал:

- Жагсаалд оролцогч зарим иргэд бусдыг эмх замбараагүй байдалд уриалан дуудаж гэмт үйлдэлд турхирах

- Тээврийн хэрэгсэл дотор жагсагчдад архи, согтууруулах төрлийн ундаа уулгах

- Цагдаагийн алба хаагчдаас тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх

- Цагдаагийн алба хаагчдын хувцсыг урж тасдсан, эд зүйл, техник хэрэгслийг эвдэж гэмтээх

- Тээврийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглаан болж буй газар луу хориглосон зүйл /гэр, майхан, эсгий гэх мэт/ нэвтрүүлэхийг оролдох

- Жагсагчид төрийн ордон руугаа дайрч, төрийн тусгай хамгаалалтын бүсийг тогтоосон хашааг эвдэх

- Жагсагч иргэд бөөнөөрөө Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын амьдардаг “Их Тэнгэрийн ам” хэмээх төрийн тусгай хамгаалалтын бүс дотор жагсахаар нэвтрэхийг оролдох зэргийг дурдаж болохоор байна.

Дүгнэлт. Монгол Улсад зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаантай холбоотой нөхцөл байдлыг авч үзээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсад зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг ихэвчлэн иргэдийн үүсгэл санаачлагаар явагдсан нь иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх нөхцөл боломж эрх зүйн хүрээнд хангалттай байгааг мэдэж байгаатай салшгүй холбоотой юм.

2. Монгол Улсад сүүлийн 3 жилд зохион байгуулагдсан жагсаал, цуглааныг судлан үзвээс дийлэнхи нь Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд заасан тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад бүртгүүлэлгүй зохион байгуулсан байна. Өөрөөр хэлбэл өнөөдрийн хүчин төгөлдөр хуульд зааснаар зөрчилтэй жагсаал, цуглаан гэж үзэж болохоор байна.

3. Жагсаал, цуглаан зохион байгуулагчид тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад бүртгүүлэлгүй Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг зөрчиж хийж байгаа нь нэг талаар хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа, нөгөө талаараа Үндсэн хуульд заасан эрхээ

эдэлж байна гэх хэт туульширсан хандлагаар зохион байгуулж байгаатай холбоотой гэж гэж үзэж байна.

4. Жагсаал, цуглаан зохион байгуулагч, оролцогчид сүүлийн үед хүний эрх нэрийн дор төрийн эрх бүхий албан тушаалтнуудын хууль ёсны тавьсан шаардлагыг эсэргүүцэх, хувцас, эд зүйл, техник хэрэгслийг нь эвдэж гэмтээх явдал улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь хуулийн хариуцлага сул байгаа, нөгөө талаараа хууль сахиулагчид олны хэл ам, цахим орчинд буруутгах магадлал өндөр байгаатай холбон үзэж байна.

5. Цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ шаардлагатайгаа нийцүүлэн нэн даруй Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хурдан боловсруулж батлуулах шаардлага тулгарчээ.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглаан зохион байгуулагч нарын хүлээх үүргийг нэмэгдүүлэх замаар тайван замаар зохион байгуулж явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх

2. Жагсаал, цуглааны явцад жагсаал, цуглааныхаа зорилго, чиглэлийг өөрчлөх, бусдыг эмх замбараагүй байдалд уриалан дуудах, турхирч байгаа оролцогчдод хүлээлгэх хариуцлагыг чангатгах

3. Хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаанд оролцож байгаа алба хаагчдын эрх зүйн хамгаалалтыг улам боловсронгуй болгох

4. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглаанд оролцогчдын эрх зүйн байдлыг илүү тодорхой болгож оруулах зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

Ном бүтээл:

3. Нармандах, Б. Үндсэн хуулийн эрх зүй. -Уб. 2010.
4. Чулуун, Ш. Жагсаал, цуглаан, онцгой нөхцөл байдлын үед нийгмийн хэв журам сахиулах ажиллагаанд баримтлах эрх зүйн актын эмхтгэл. -Уб., 2013.
5. Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. –Уб., 2018.
6. Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага. /орчуулгын бүтээл/. -Уб., 2022.

Сонин сэтгүүл:

7. Төрийн мэдээлэл. 1994. №9.
8. Төрийн мэдээлэл. 1994. №9.

Цахим эх сурвалж:

9. <https://legalinfo.mn> .
10. <http://www.osce.org>.
11. <https://journal.num.edu.mn>

ХҮҮХЭД ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛД ӨРТӨХӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ
CHILDREN ARE EXPOSED TO TRAFFIC ACCIDENTS AND CONFLICTS
SOME PROBLEMS TO CONSIDER PREVENTION

Б.Баянмөнх
Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
*Дотоод хэргийн их сургууль,
Монгол Улс Цахим шуудан:*
byanmunkh@uia.gov.mn

B. Bayanmunkh
Head of Police Law, University of Internal Affairs
Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel
University of Internal Affairs
State Email: byanmunkh@uia.gov.mn

Хураангуй. Сүүлийн таван жилд 25.000 орчим зам, тээврийн осол бүртгэгдэж, 284 хүүхэд амиа алдсан харамсалтай статистик байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг нь унших, тоо бодохтой адилхан чухал ач холбогдолтой бөгөөд хүүхдүүдэд цэцэрлэгээс нь эхлэн мэдлэг олгох нь чухал юм.

Бид энэхүү өгүүлэлд бага насны хүүхэд зам тээврийн осол, зөрчилд өртөж байгаа өнөөгийн байдал, осолд нөлөөлж байгаа хүчин зүйл, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Abstract. In the last five years, about 25,000 road and transport accidents were registered, and 284 children lost their lives. Road safety awareness is just as important as reading and numeracy, and it's important to educate children from kindergarten.

In this article, we have briefly discussed the current situation in which young children are involved in traffic accidents and violations, the factors that influence accidents, and some ways to take preventive measures and measures.

Түлхүүр үг. Зам тээврийн осол, зөрчил, бага насны хүүхэд, эцэг эх, гадаадын зарим оронд нэвтрүүлсэн туршлага

Key word. Road traffic accidents and violations, young children, parents, experience introduced in some foreign countries

Үндсэн хэсэг. Дэлхий дахинд осол гэмтлийн улмаас жил бүр 5.8 сая хүн амь насаа алдаж, 600 гаруй сая хүн бэртэж гэмтэж, хөгжлийн бэрхшээлтэй болж, 700 тэрбум ам.долларын хохирол учирч байгаа бол үүнээс зам тээврийн ослын улмаас 1.25 сая гаруй хүн амь насаа алдаж 50 гаруй сая хүн бэртэж гэмтэж 65 тэрбум ам.долларын хохирол учруулж байгаа нь хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байгаа тухай дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас онцолжээ.¹⁵⁴

Дэлхийн хэмжээнд нас баралтын шалтгаанаар 8-рт зам тээврийн осол хэрэг орж байгаа бөгөөд нийт осол, гэмтлийн нас баралтын 23 хувийг эзэлж байна. Зам тээврийн ослын улмаас жилд 1,2 сая хүн буюу өдөр бүр 3242 хүн амь насаа алдаж байна. Харин Монгол Улсад жилд дундажаар зам тээврийн ослын улмаас 540 хүний амь нас барж 800-900 хүн бэртэл гэмтэл авч байна. Зам

¹⁵⁴ <https://police.gov.mn>. //Татаж үзсэн: 15.10.2023

тээврийн ослоос нас баргасадын 65% бэртэгсэдийн 35% гаруй нь Орон нутгийн хатуу хучилттай замд гарч байгаа нь нийгмийн аюулгүй байдалд нөлөөлж байна.

Монгол Улсад сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гадаадын өндөр хөгжилтэй орнууд /Япон, БНСУ, АНУ, Европын бусад орнууд/-аас имплотоор оруулж ирж байгаа автомашины тоо өдрөөс өдөрт өсч, нийслэл хот болон орон нутгийн замын ачаалал эрс нэмэгдэж, хөдөлгөөний нягтрал, түгжрэл, шатахуун тосны хий шаталт /агаарын бохирдол/, үргүй цаг ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол ихээхэн гарч, сөрөг үр дагаврыг бий болгож байна.¹⁵⁵

Өнөөдөр зам тээврийн осол гарч байгаа шалгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж нас баралт, гэмтэлтийн тоог багасгахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, зөвхөн иргэдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан ч үндэс суурь нь чанартай хийгдээгүй учир хүний зан үйлийг өөрчлөх боломжгүй юм.

Сүүлийн 20 жилийн хугацаанд өндөр хөгжилтэй дэлхийн улс орнууд замын аюулгүй байдалд системийн хандлагыг хэрэглэж, дан ганц замын хөдөлгөөнд оролцогсдыг зан үйлийг өөрчлөх замаар бус, харин замын орчин, тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнд оролцогсдод чиглэсэн арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлснээр зам тээврийн хэрэг ослыг огцом бууруулж чадсан байна. Тухайлбал зам төлөвлөлт, менежментийг болон стандарт, хурд хэтрүүлэлт, суудлын даруулга, хэрэглээ, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох асуудалд тавих хяналтыг сайжруулах явдал юм.

Манай орны хувьд хот хоорондын замд гарч байгаа осол нь замын тодорхой цэгүүдэд цаг хугацааны давтамжтай гарч байгаа нь зам тээврийн ослын статистик тоо мэдээ, замын цагдаагийн газрын тайлангаас харагддаг.

Улсын хэмжээнд 2022 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 779 бүртгэгдсэний 443 буюу 56.9% нь нийслэлд, 336 буюу 43.1% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Хүүхэд өртсөн зам тээврийн ослын үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад нийслэлд 203 нэгж буюу 84,6%-иар, орон нутагт 113 буюу 50.7%-иар тус тус өсчээ.

Зам тээврийн ослын улмаас 76 хүүхэд амь насаа алдаж, 810 хүүхэд гэмтэл, бэртэл авсаны 171 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авч эрүүл мэндээрээ хохирчээ. Осолд өртөж гэмтэл, бэртэл авсан 2879 хүний бол нийт гэмтсэн хүний 810 буюу 28,1%-г хүүхдийн гэмтэл эзэлжээ. Зам тээврийн ослын улмаас 2022 онд амь насаа алдсан нийт 539 хүний 76 буюу 14,1%-г хүүхдийн нас баралт эзэлж байна.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ маршрутаар явахдаа анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа гарц, гарамтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр өөрсдийн замын хөдөлгөөний мэдлэг дутмагаас осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна.

Хүүхэд өртсөн зам тээврийн ослын үзүүлэлтийг 2022 оны байдлаар төв, орон нутгаар харьцуулан авч үзвэл: орон нутагт Төв, Дархан аймгуудад тухайн осол давамгайлж байна. Хүүхэд зам тээврийн осолд өртөж хохироход жолоочийн буруутай үйлдэл дотор жолооч анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, аюул саад тулгарах үед зогсоох арга хэмжээ аваагүй гэсэн үйлдэл давамгайлдаг. Улсын хэмжээнд 2022 онд явган хүний гарцан дээр 85 хүүхэд осолд өртсөний 70 буюу 82,4% нь Улаанбаатар хотын замд бүртгэгдсэн байна.

Явган хүний гарц дээр хүүхэд осолд өртсөн тохиодол Орхон аймагт 9, Дархан-Уул аймагт 2, Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар аймгуудад тус тус 1 осол бүртгэгдсэн.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн хүүхэд өртсөн зам тээврийн ослын 18,9% нь явган ба дугуйтай хүүхдийн буруутай үйлдэл, 9,5% нь эцэг, эх асран хамгаалагчийн буруутай үйлдлээс

¹⁵⁵ Мөнхбаяр, Р. зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан, нөхцлийг тогтоох зарим арга зам хууль тогтоомжийн эмхтгэл. -УБ.2019., 3 дахь тал

гарчээ. Эцэг, эх асран хамгаалагчийн буруугаа 45 осол бүртгэгдсэний 36 буюу 80,0% нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.¹⁵⁶

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн “Тэр-сургууль-цэцэрлэг” гэсэн маршрутаар замын хөдөлгөөнд оролцохдоо зам хөндлөн гарахдаа зорчих хэсгийн гарцтай гарамтай хэсгээр зам хөндлөн гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр зам тээврийн осолд ихээхэн өртөж хохирдог. Орон нутгийн замд хүүхдийн хамгаалалтын бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвшээгүй, хэрэглэхгүй байгаагаас тээврийн хэрэгслээр зорчигч хүүхдүүд амь насаа алдсаар байна.¹⁵⁷

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13.2.7-т “Эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх”¹⁵⁸ гэж заасан байдаг.

Зөрчлийн хуулийн 14 дүгээр бүлгийн 7 дугаар зүйлийн 54 дэх хэсэгт “Эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулж замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргахад хүргэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалтын дагуу 2022 онд 120 хүнийг торгосон байна.¹⁵⁹

Зам тээврийн осолд өртөж, хохирсон нийт 886 хүүхдийн 25,7%-г 0-6 хүртэл насны хүүхэд, 53,4%-г 7-14 насны хүүхэд, 20,9%-г 15-17 насны хүүхэд эзэлсэн байна. Зам тээврийн осолд өртсөн нийт 886 хүүхдийн 529 буюу 59,7% нь эрэгтэй, 357 буюу 40,3% нь эмэгтэй хүүхдүүд байна.

Сургуулийн насны хүүхдүүдийг эцэг эхчүүд өөрсдөө заавал хүргэж өгөх, тарахад нь авах хэрэгтэй. Өөрсдөө гэр лүүгээ явж чадна гэсэн байдлаар анхааралгүй өнгөрвөл ямар нэгэн байдлаар аюулд өртөж болзошгүй байдаг. Бага насны хүүхдийг бол яах аргагүй зориулалтын суудалд нь суулгаж бүсийг нь бүсэлж учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй юм.

Статистик тоо мэдээнд дурдсан хүүхэд ихээр өртөөд байгаа цагуудыг авч үзвэл хичээл эхлэх буюу тарах үеийн 12.00-13.00 цаг, 16.00-17.00 цагуудад хамгийн их осол бүртгэгдсэн байна. Мөн 11.00-17.00 цагуудад дийлэнх ослууд бүртгэгдсэн нь тоон үзүүлэлтээс харагдаж байна.

Зам тээврийн ослын улмаас хохирсон нийт 886 хүүхдийн 566 буюу 63,9% нь явганаар, 252 буюу 28,4% нь тээврийн хэрэгслээр зорчигч, 34 буюу 3,8% нь унадаг дугуйгаар, 34 буюу 3,8% нь бусад /тээврийн хэрэгсэл жолоодсон, гэртээ байсан, хашаандаа, машины ард г.м/ замын хөдөлгөөнд оролцох үедээ амь нас, эрүүл мэндээрээ хохирч, гэмтэл бэртэл авчээ.

Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Отгонтамир ЦЕГ-ын <https://police.gov.mn> цахим сайтад “Бага насны хүүхэд зам тээврийн осол, хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлье!” гэсэн ярилцлагандаа “Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хоёр гол шалтгаан байгаа. Нэг нь хүүхдийг явган зорчигч хэлбэрээр эцэг эхчүүд гараас нь хөтлөн авч явдаг нөгөө нь тээврийн хэрэгсэлтэй зорчигч хэлбэрээр авч явдаг. 2022 оны эхний нэгдүгээр улирлын байдлаар зам тээврийн ослын улмаас 14 хүүхдийн амь нас хохирсон харамсалтай мэдээлэл байна. Эдгээр тохиолдлын шалтгааныг аваад үзэх юм бол 11 хүүхэд нь тээврийн хэрэгсэлд зорчигч хэлбэрээр хөдөлгөөнд оролцож байгаад амь нас нь хохирсон. Үлдсэн гурван тохиолдол нь жолооч хөдөлгөөн эхлэхдээ зам орчноо шалгаагүйн улмаас тээврийн хэрэгслийн хажууд байгаа ой гурван сартайгаас ой найман сартай хүүхдүүдийн амь нас нь хохирсон харамсалтай тохиолдол бүртгэгдсэн байна”¹⁶⁰ гэж бичжээ. Эндээс үзвэл хүүхэд зам тээврийн осол, зөрчилд өртөж байгаа үндсэн шалтгаан нь эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүйгээр бие даан замын хөдөлгөөнд оролцож байгаа явдал юм.

¹⁵⁶ “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2022”. -Уб., 2023. 57 дахь тал

¹⁵⁷ <https://police.gov.mn>. //Татаж үзсэн: 15.10.2023

¹⁵⁸ Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

¹⁵⁹ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл 2022. Уб. 2023. 55 дахь тал

¹⁶⁰ <https://police.gov.mn>. //Татаж үзсэн: 24,10,2023

Улаанбаатар хотод замын хөдөлгөөнд явганаар оролцогч хүүхдүүд зам тээврийн осолд өртөж, хохирох нь их байхад орон нутагт тээврийн хэрэгсэлээр зорчигч хүүхдүүд ихээхэн өртөж хохирч байна.

Манай улсын зам тээврийн дүрэмд зааснаар явган зорчигч зохицуулдаг буюу гэрлэн дохиотой гарц, зохицуулдаггүй буюу цагаан шугаман гарцаар зам хөндлөн гарах зохицуулалттай. Монгол Улсын замын хөдөлгөөний тухай хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ явганаар болон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх, эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй юм.

Сүүлийн жилийн тоо баримтаас харахад орон нутагт явганаар замын хөдөлгөөнд оролцогч хүүхдийн осолд өртөх нь нэмэгдэх хандлагатай байгаа ба бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсанаас хохирох нь ихсэх хандлага харагдаж байна. Мөн орон нутагт насанд хүрээгүй хүүхэд мотоцикл, автомашин жолоодон замын хөдөлгөөнд оролцож яваад амь насаа алдсан 5 тохиолдол бүртгэгдсэн байгаад бид онцгойлон анхаарал шаардлагатай байна.

Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хур тунадас их бага хэмжээгээр орж, замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нар хурдаа зам орчиндоо тохируулах, үзэгдэх хүрээ багассан цасан болон шороон шуургатай байгаа үед бол хурдаа тохируулж явах явдал дээр учир дутагдалтай хандаж байгаа нь өнөөдөр тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Автобусны буудал болон явган хүний гарц хэсгээр хөл хөдөлгөөн ихтэй байдаг бөгөөд ялангуяа дулааны улиралд бол унадаг дугуй, скүүтер, ролликтортойгоор хүүхэд багачууд хөдөлгөөнд оролцож байгаад бид анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна. Хамгийн гол зүйл бол хүүхэд замын хөдөлгөөнд оролцохдоо аюулгүй байдлаа хэрхэн хангах, гарцтай, гарамтай хэсгээр явахдаа баруун гар талаа барьж тухайн тээврийн хэрэгсэл бүрэн зогсож зам тавьж өгсний дараа зам хөндлөн гарах арга зүйг л бид хүүхдүүдийн тархи оюун ухаанд нь суулгаж өгөх ажлыг л эрчимтэй зохион байгуулмаар байна.

Түүнчлэн бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж тээвэрлэх, хамгаалах бүсийг тогтмол зүүлгэж хэвшүүлэх, 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, хорооллын доторх хөдөлгөөнд зогсож буй тээврийн хэрэгслийн дундуур хүүхэд гэнэт гарч ирэх тул хурдаа тохируулж явах, гэр хорооллын хашаа болон зогсоол талбай дээрээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг эхлүүлэхдээ байнга тойрч шалгаж байхыг эцэг эх, асран хамгаалагч нарын зайлшгүй мэдвэл зохих, амьдралын хэмнэлдээ дадал болгож оруулмаар зүйлүүд цөөнгүй байгааг анхаарах шаардлагатай.

НҮБ-ын Хүүхдийн сан ба Олон улсын автомашины холбооны хамтран боловсруулсан “Аюулгүй суралцахуй” тайланд: “Дэлхий даяар өдөрт хамгийн багадаа 500 хүүхэд зам тээврийн ослоор амиа алдаж, мянга мянган хүүхэд гэмтэж, бэртэж байна. Энэ нь өдөр бүр хоёр дунд, ахлах сургууль хоосон байгаатай дүйцэхүйц тоо баримт юм”¹⁶¹ хэмээн дурджээ.

Өдөрт хоёр удаа буюу сургууль цуглах, тарах цагаар замын хөдөлгөөнд оролцох хүүхдийн тоо эрс нэмэгддэг бөгөөд дэд бүтэц, хуулийн хэрэгжилт зэрэг нөхцөл байдлаас олон хүүхэд насанд хүрсэн хүний хараа хяналтгүйгээр замын хөдөлгөөнд оролцож байдаг нь нууц биш юм. Бидний хойч болсон хүүхэд залуус замын хөдөлгөөнд аюулгүй зорчих эрхтэй бөгөөд хүүхдэд ээлтэй орчныг бүтээхэд хүн бүрийн оролцоо чухал бөгөөд үүнд төр засгийн бодлого, шийдвэр онцгой ач холбогдолтой.

Тэгвэл өнөөдөр хүүхдийн аюулгүй орчинд өсөж, суралцах орчныг хангах нь хэний хариуцлага вэ? Тэднийг зам тээврийн ослоос сэргийлэхэд гэр бүл, сургуулийн оролцоо ямар түвшинд байх ёстой вэ? гэдэгт анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна.

¹⁶¹ <https://gogo.mn>. //Татаж үзсэн: 18.10.2023. Хэний хариуцлага вэ: Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх шийдэлд суурилсан санаачилга

2022 оны 10 дугаар сард “Тэр өргөө” ТББ, Их Британийн “Аюулгүй, тогтвортой тээврийн холбоо” хамтран Сонгинохайрхан дүүргийн Хөгжил цогцолбор сургуульд нэг сарын хугацаанд хэрэгжүүлсэн хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах, сургуулийн орчны замын аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд иргэд, асран хамгаалагчдыг нэмэгдүүлэх зорилготой “Судалтай зам” төслийг судалж үзэх нь зөв гэж үзлээ.

Төслийн хүрээнд иргэд, асран хамгаалагчид мөн сургуулийн хамтын оролцоотойгоор “Сургуулийн орчны замын аюулгүй байдлын үнэлгээ ба тайлан” олон улсын арга барилд суурилсан орчны аюулгүй байдлын үнэлгээг гүйцэтгэн сургуулийн орчин дахь “хар цэг”-үүдийг тодорхойлсон. Төслийн гол зорилго нь үнэлгээ, нотолгоонд суурилсан шийдлийг боловсруулах бөгөөд төслийн баг, асран хамгаалагчдын оролцоотойгоор Хөгжил цогцолбор сургуулийн баруун талын орц, гарцны эрсдэлтэй орчныг өөрчилсөн байна.

Тус шийдлээр хүүхдийн сургуулийн орчинд тулгардаг дараах асуудлуудыг шийдсэн:

- Сургуулийн орц, гарцнаас гарах үед үзэгдэх орчин хязгаарлагдмал
- Сургуулийн орчинд явган хүний гарц, тэмдэг, тэмдэглээ байдаггүй
- Автомашины зогсоолын хүрэлцээ муутай үед хүүхдээ буулгах түр зогсоол байдаггүй.

Шийдлийн онцлог нь олон улсад сургуулийн орчинд түгээмэл ашигладаг “Kiss-and-ride” буюу аюулгүй орчинд хүүхдээ машинаас буулгах түр зогсоолыг туршсан явдал юм байна.

Түүнчлэн Цэцэрлэгийн дунд бүлэгт нэвтрүүлсэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын яриа тоглоом” гэж байдаг. Энэ нь цэцэрлэгээс нь эхлэн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, болзошгүй осол, аюулаас хэрхэн биеэ хамгаалах, орон зайд орохгүй байх гэж олон санаа, дадлыг хүүхдүүдэд олгодог байна.

Тоглоомон ярианы бүтэц нь:

Харилцан ярианы картын индекс Цэцэрлэгийн замын хөдөлгөөний дүрэм

Хүүхдүүдтэй хийсэн яриа “Би хаана тоглож болох вэ?”

Зорилтот:

- Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд гудамж, зам дээрх аюулгүй байдлын талаархи санаа бодлыг бий болгох;
- Зам дээр тоглох аюулын талаар хүүхдүүдэд итгүүлэх (зам);
- Та яагаад гудамж, зам дээр тоглож чадахгүй байгаагаа тайлбарла;
- Тоглоом, скутер, хүүхдийн унадаг дугуй, цанаар гулгах, чарга, тэшүүрээр гулгах газрыг зааж өгөх.

Толь бичиг : аюул, сахилга бат.

Ярилцлагын явц: Замын хөдөлгөөний дүрэм¹⁶²

Замын хөдөлгөөнд явганаар болон бусад байдлаар оролцох арга ухааныг зааж ойлгуулж өгдөг маш олон сэдвийн хүрээнд бэлтгэсэн тоглоомон яриа, ярилцлагыг манай улсын сургуулийн өмнөх боловсрол олгох болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын хөтөлбөрт заавал оруулж өгвөл болзошгүй зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, осол, зөрчлийн тоо буурах боломжтой.

ОХУ-д “Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан замын хөдөлгөөний дүрмийн талаархи хичээлийн хураангуй” цогц хичээлийг 2014 онд Армавир хотын багш Чертановская Татьяна Петровна¹⁶³ “Залуу явган зорчигч” цуврал хичээлийн төслийг боловсруулж нэвтрүүлж байжээ.

Хамааралтай байдал: Энэхүү төсөл нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд дүрмийг заах нь бодит асуудалд зориулагдсан бөгөөд хүмүүс өнөөдөр бүгд замын хөдөлгөөний нөхцөл байдалд зан үйлийн тодорхой хэм хэмжээ, дүрмийг дагаж мөрдөх ёстой нийгэмд амьдарч байна. Ихэнхдээ зам тээврийн ослын буруутан нь хүүхдүүд өөрсдөө байдаг ба тоглох замын ойролцоо, буруу газраар

¹⁶² <https://minikar.ru/mn>. //Татаж үзсэн: 18.10.2023. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын яриа тоглоом дунд бүлэг

¹⁶³ <https://pnak.ru>. //Татаж үзсэн: 21.10.2023. Хотын сургуулийн өмнөх боловсрол боловсролын байгууллага, цэцэрлэг хосолсон төсөл №21

гудамж хөндлөн гарах, тээврийн хэрэгсэлд буруу орж гарах байдлаар илэрдэг. Замын хөдөлгөөний дүрмийн үндсийг үл тоомсорлож, насанд хүрэгчдийн зам дээрх хүүхдүүдийн зан үйлд хайхрамжгүй хандах хандлага нь үүнд хүргэдэг.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд зан авираа хэрхэн зөв хянахаа мэдэхгүй хэвээр байгаа тул болзошгүй аюулыг урьдчилан харах чадварыг хараахан хөгжүүлээгүй байгаа тул тэд тайван замаар зам руу гүйдэг. Олон талаараа явган зорчигчийн аюулгүй байдал нь гудамжинд биеэ авч явах дүрмийг дагаж мөрдөхөөс хамаардаг тул хүүхдүүдэд дүрмийг заах шаардлагатай байдаг.

Бага наснаасаа тогтсон зуршил насан туршдаа хэвээр үлддэг тул нэг нь байдаг чухал асуудлын нэг бол замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал бөгөөд энэ нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх явдал юм. Тиймээс Замын хөдөлгөөний дүрмийг судлах нь өнөөдрийн гол зорилтуудын нэг бөгөөд үүнд Замын хөдөлгөөний дүрмийг судлахад зориулсан энэ төслийн ажил тус дөхөм болно гэсэн байна.

Асуудал: Өнөөдөр замын хөдөлгөөнд оролцогчдын бие биедээ хүндэтгэлтэй хандах хандлагыг сурталчлах асуудал хурцаар тавигдаж байна. Залуу үеийнхэнд зам дээр зөрчил гаргасан хүмүүст сөрөг хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай байна. Жил ирэх тусам улам олон машин манай замаар явж байна. Зам тээврийн осолд өртөхгүйн тулд насанд хүрэгчид, хүүхдүүд хоёулаа замын хөдөлгөөний дүрмийг мэддэг байхаас гадна дагаж мөрдөх ёстой.

Зорилтот: Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зам, гудамж, тээврийн хэрэгсэлд аюулгүй байдлын үндсийг төлөвшүүлэх.

Даалгаварууд:

Боловсролын:

- Замын хөдөлгөөний дүрмийн талаархи хүүхдийн мэдлэгийг хөгжүүлэх, сайжруулах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөх хэрэгцээг ойлгох чадварыг бий болгох;
- Эцэг эхчүүдийн замын хөдөлгөөний дүрмийн талаархи мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх, танилцах гудамжинд хүүхдэд зан төлөвийг заах хэлбэр, арга барилтай эцэг эхчүүд;
- Хүүхдэд аюултай үйл явдлыг урьдчилан харж, боломжтой бол түүнээс зайлсхийх, шаардлагатай бол арга хэмжээ авах чадварыг сургах;
- Замдаа анхаарал болгоомжтой байх, анхаарал болгоомжтой байх, бие даасан байдал, хариуцлага, ухамсартай байдлыг хөгжүүлэх;
- Танин мэдэхүйн үйл ажиллагааг идэвхжүүлэх, харилцааны чадварыг хөгжүүлэх;

Яриа: Төсөл дээр ажиллах явцад хүүхдийн яриаг хөгжүүлэх, хүүхдийн идэвхтэй, идэвхгүй үгсийн санг нөхөхөд хувь нэмэр оруулах;

- Хөгжүүлэх холбогдсон яриа;
- Хувийн аюулгүй байдлын ур чадвар, өөрийгөө хамгаалах мэдрэмжийг төлөвшүүлэх.¹⁶⁴

ОХУ-д нэвтрүүлсэн энэхүү төсөл нь манай улсад нэвтрүүлж болох, зардал мөнгө харьцангуй бага шаардагдахаар харагдаж байгаа тул туршилтын журмаар нэвтрүүлэх боломжийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Замын цагдаагийн газар хамтран судалж үзэхээс гадна тухайн хотод хэрхэн хэрэгжиж байгааг газар дээр нь очиж туршлага судлах хэрэгтэй.

Түүнчлэн АНУ-д нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрсэн “Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр”-ийг манай улсад нэвтрүүлэх боломжыг судалж үзмээр байна.

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр

Цэцэрлэгийн 5-р ангиас эхлэн хүүхдүүдэд явган зорчигчийн аюулгүй байдлыг сургах, дэмжих зорилгоор хичээлийн төлөвлөгөө, үнэлгээний гарын авлага, сурагчдын хариу арга хэмжээний талаар тусгасан байна.

¹⁶⁴ <https://pnak.ru>. //Татаж үзсэн: 21.10.2023. Хотын сургуулийн өмнөх боловсрол боловсролын байгууллага, цэцэрлэг хосолсон төсөл №21

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр нь цэцэрлэгийн 5-р ангийн сурагчдад явган зорчигчийн аюулгүй байдлыг сургаж, сургадаг. Хөдөлгөөний ойролцоо алхах, гудамжаар гарах, уулзвар гарцаар гарах, зогсоолын аюулгүй байдал, сургуулийн автобусны аюулгүй байдал гэсэн таван хичээлээр зохион байгуулдаг. Хичээл бүр өмнөх олж авсан ур чадвар дээр тулгуурладаг.¹⁶⁵

Энэхүү сургалтын хөтөлбөр замын хөдөлгөөнд харьцангуй бие даан оролцдог дунд ангиас нэвтрүүлээд явбал тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж бодож байна.

Дүгнэлт. Хүүхэд замын хөдөлгөөнд оролцохтой холбоотой буруу үйлдлийн хор уршгийг бодолгүй, ямар үр дагаварт хүргэх вэ гэдгийг ухамсарлах боломжгүй байдаг гэж хууль зүйн шинжлэх ухаанд үздэг юм байна. Энэ нь чухамдаа ганц манай улсад бус, дэлхийн ихэнх улс оронд эрх зүйн зохицуулалт энэ жишгээр явдаг нь анхаарал татаж байна.

Замын хөдөлгөөнөөс үүдэн гарч байгаа ослын цөөнгүй хэсгийг бага насны хүүхэд эзэлж байгааг онцгойлон анхаарч, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд үүсэж болзошгүй хохиролоос урьдчилан сэргийлэх түүний тоон үзүүлэлтийг багасгахад чиглэсэн үр нөлөөтэй арга хэмжээг зохион байгуулах, гадаадын зарим оронд нэвтрүүлсэн туршлага, шинэ санаа, шинэ шийдлийг ашиглах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Боловсролын байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролд замын хөдөлгөөний дүрмийг шат дараатай оруулах /хүн бүр байнгын замын хөдөлгөөнд оролцогч/

2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр”-ийг оруулж тусгуулах;

3. Хүүхдүүдийг болзошгүй аюул, зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын байгууллагуудтай хамтран даатгалд хамруулах, төлбөрийг төрөөс даах зохицуулалтыг судалж үзэх

4. Монгол Улсын бүх цэцэрлэгийн дунд бүлэгт “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын яриа тоглоом” хичээл сургалтыг нэвтрүүлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
2. Мөнхбаяр, Р. зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан, нөхцлийг тогтоох зарим арга зам хууль тогтоомжийн эмхтгэл. -УБ.2019
3. Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2022. -УБ., 2023
4. Хотын сургуулийн өмнөх боловсрол боловсролын байгууллага, цэцэрлэг хосолсон төсөл №21
5. Төрийн мэдээлэл. 2015. №28.
6. <https://police.gov.mn>
7. <https://pnak.ru>
8. <https://www.nhtsa.gov>

¹⁶⁵ <https://www.nhtsa.gov/pedestrian-safety/child-pedestrian-safety-curriculum> //Татаж үзсэн: 19.10.2023.
Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ
PREVENTION OF TRAFFIC ACCIDENTS AND VIOLATIONS
BROADCASTING THE EXPERIENCES OF SOME FOREIGN COUNTRIES**

С.Эрдэнэбаяр

Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн дэслэгч
S. Erdenebayar
Master of Police Studies,
police lieutenant

Хураангуй. Манай улсад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд маш олон төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч хүссэн үр дүнд төдийлөн хүрэхгүй байгаа нь байнга анхаарал татдаг билээ.

Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, гадаадын зарим оронд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга зам, туршлагын талаар товч авч үзсэн болно.

Abstract. In our country, many types of work and measures are taken to prevent traffic accidents and violations, but the desired results are not achieved.

This article briefly discusses the current situation of traffic safety in Mongolia, some methods and experiences of preventing traffic safety crimes and violations in some foreign countries.

Түлхүүр үг. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, явган хүний гарц, гарын авлага, самбар,

Key word. Road safety, pedestrian crossings, manuals, boards

Үндсэн хэсэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь энэ зууны дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байгаа учир энэхүү тулгамдсан асуудлын нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн өргөн хүрээний сөрөг үр дагаварыг багасгах арга хэмжээ аваагүй тохиолдолд улс орнуудын тогтвортой хөгжил, Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болж байна.

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гадаадын зарим орны туршлагыг авч үзэхийн өмнө Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлын талаар товч авч үзэх нь зүйтэй юм.

Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдсан асуудлын нэг болсон. Замын нөхцөл байдлыг аль болох замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулсан гадаадын сайн туршлагаас судлан нутагшуулах шаардлагатай байна.

Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал. Монгол Улсад 1929 онд 20 автомашин замын хөдөлгөөнд оролцож байсан бол 93 жилийн дараа буюу 2022 онд 11278131 автомашин болон өсчээ. Монгол Улсад 2022 онд 1264542¹⁶⁶ тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 1127813 буюу 89.0%-г автомашин эзэлж байна. Монгол

¹⁶⁶ Авто тээврийн үндэсний төвөөс 2022,12,31-ны байдлаар гаргасан үзүүлэлтээс авав.

улсын 1264542 тээврийн хэрэгслийн 711835 буюу 56.3% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.

Монгол Улсад 2022 онд шинээр 34332 автомашин бүртгэгдсэн нь өнгөрсөн онд шинээр бүртгэгдсэн автомашинаас 4,8 %-иар буурчээ.

Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалтын /насжилт/ хугацааг 2022 оны байдлаар авч үзвэл: 0-3 жил ашиглагдаж буй автомашин 58465 буюу 4,6%, 4-6 жил болсон автомашин 44051 буюу 3.5%, 7-9 жил 117225 буюу 9,3%, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй автомашины тоо 1044811 буюу 82.6 %-ийг тус тус эзэлж байна.

Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа /насжилт/-г өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл: ашиглалтын хугацаа багатай автомашин 0,8%, ашиглалтын хугацаа ихтэй 10 ба түүнээс дээш жил ашиглаж буй автомашин 1,4%-р тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсад бүртгэлтэй 1127813 автомашины 451107 буюу 40,0% нь зүүн талдаа, 676706 буюу 60,0% нь баруун талдаа жолооны хүрдний байрлалтай автомашин байна.

Улаанбаатарт буруу буюу баруун талдаа жолооны хүрдтэй 433305 автомашин замын хөдөлгөөнд оролцож байгаа нь нийслэлд бүртгэлтэй автомашины 66,3%-г эзэлж байна.¹⁶⁷

Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн ослын шинжтэй 101233 дуудлага хүлээн авч 24121 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна. Тухайн онд тээврийн хэрэгсэл, автомашины өсөлт 2,4%-иар өсч зам тээврийн ослын шинжтэй дуудлага 21973(27,7 %), бүртгэгдсэн зам тээврийн осол 1639 (7,3 %)-аар тус тус өсөв.

“Зам тээврийн осол” - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг¹⁶⁸; -ыг хэлнэ.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 101233 дуудлага хүлээн авчээ. Хүлээн авсан дуудлага, мэдээллийн 95409 буюу 94,2%-ийг Улаанбаатарт, 5824 буюу 5,8%-г орон нутагт шийдвэрлэсэн байна.

Монгол улсын хэмжээнд 2022 онд 24121 зам тээврийн осол бүртгэгдсэний 20322 буюу 84,3 хувь нь Улаанбаатарт, 3799 буюу 15,7% нь орон нутагт бүртгэгджээ.

Улаанбаатарт бүртгэгдсэн зам тээврийн ослын 27,7% нь Баянзүрх дүүрэг, 19,2 % нь Сонгинохайрхан дүүрэг 16,7% нь Хан-Уул дүүрэг, 14,6% нь Баянгол дүүрэг, 14,3% нь Сүхбаатар дүүрэг, 6,2% нь Чингэлтэй дүүрэг, 1,2% нь алслагдсан 3 дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 846(80.3%) эрэгтэй жолооч, 208(19,7%) эмэгтэй жолооч эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүний 385 буюу 36,5% нь тодорхой ажил эрхэлдэггүй буюу ажилгүй хүн байв. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан үзвэл: Төрийн алба хаагч холбогдсон гэмт хэрэг 1,1%, хувиараар хөдөлмөр эрхлэгч 6,1%, хувийн хэвшлийн байгууллагад ажил эрхэлдэг хүн 1,2%-иар тус тус өсчээ.

Монгол Улсад 2022 онд зам тээврийн 24121 осолд 3418 өртөж хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ. Зам тээврийн осолд өртөж, хохирсон 3418 хүний 539 буюу 15,8% нь амь насаа алдаж, 2879 буюу 84,2% нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна.

Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 3418 хүний 1896 буюу 55,6% нь Улаанбаатарт, 1522 буюу 44,5% нь орон нутгийн замд бүртгэгдсэн осол байна. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 19,6%-иар өсчээ. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 1220 гэмт хэргийн улмаас 1321 хүн хохирсоны 280(21,2%) нь амь насаа алдаж, 1041(78,8%) нь хүнд, хүндэвтэр гэмтэл авсан.

¹⁶⁷ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ. 2022. 12 дахь тал

¹⁶⁸ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6 заалт. ЗХДүрмийн 1.2.17.

Монгол улсын хэмжээнд бүх төрлийн 35340 гэмт хэргийн улмаас 766 хүн нас барсан /амь насаа алдсан/ нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 12.2%-р өссөн. Гэмт хэргийн улмаас нас барсан 766 хүний 280 (36.6%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Монгол Улсад зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн гэсэн 2 тоон үзүүлэлт гарч үйл ажиллагаанд ашиглагдаж байна. Амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг: - Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн - Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн гэж ангилан авч үздэг.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн 481 ослын улмаас 539 хүний амь нас хохирчээ. Амь насаа алдсан 539 хүний 453(84.0%) нь орон нутгийн замд, 86(16.0%) нь нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн осол байна.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон гэмт хэргийн 481 тохиолдол бүртгэгдэж 539 хүний амь нас хохирсон байна. Хүний амь нас хохирсон 136 гэмт хэргийг ЭХХШТХ-ийн холбогдох зүйл заалтаар хэргийг хэрэгсэхгүй болгосон мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж зөрчлийн хэргээр шалгасан байх тул статистик /ЦЕГ-ын/ мэдээнд нас барсан хүн 280 гэсэн тоон үзүүлэлтээр тусгагдсан.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бүх төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 10310 хүн гэмтсэний дотор 1041(10.1%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн статистик үзүүлэлт гарчээ.

Монгол улсад зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн гэсэн 2 тоон үзүүлэлт гарч үйл ажиллагаанд ашиглагддаг.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн – зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр гэмтэл, бэртэл авсан /зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан гэх мэт/ хүнийг багтаасан тоон үзүүлэлт юм.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн – зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадлагаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт юм.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 2879 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 16,3%, хүнд, хүндэвтэр гэмтсэн хүн 17,6%-р тус тус өссөн.¹⁶⁹

Өнөөдөр дэлхийн 100 гаруй улс оронд 2100 орчим загварын төрөл бүрийн суудлын автомашиныг жилдээ 40 гаруй сая ширхэгийг үйлдвэрлэн гаргаж хүмүүсийн хэрэгцээнд нийлүүлж байна.¹⁷⁰

Энэ тоо нь зөвхөн суудлын автомашины үйлдвэрлэлтэй холбоотой бөгөөд автобус, ачааны машин, мотоцикл, механизмын тоо ороогүй юм.

Гадаадын зарим орны туршлага. Дэлхий нийтээр жил бүр 1.3 сая хүн зам тээврийн ослын улмаас нас барж байгаа буюу зам тээврийн ослын нас баралт 100.000 хүн амд 18 ногдож байна.¹⁷¹ Ийнхүү зам тээврийн ослын тоо улам бүр нэмэгдэж, ослоос үүдэлтэй хүний амь нас, эрүүл мэнд хохирох, эд материалын хохирол учрах явдал ихсэх хандлагатай байна.

ОХУ-н эрдэмтэн А.П.Матросов зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох зорилгоор 1971 онд хийсэн судалгаагаар замын нөхцөл нь гарсан ослын 70 хувьд нь ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн байжээ. Гэтэл тухайн үед албан ёсны тоо

¹⁶⁹ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Уб. 2022. 15-17 дахь тал

¹⁷⁰ -http://www.who.int/roadsafety/ministerial_conference/declaration_en.pdf

¹⁷¹ Global Status Report on Safety 2013.Supporting a decade of action.Who, 2013

баримтаар энэ үзүүлэлт дөнгөж 4.7 хувьтай байв. Одоо энэ тоон үзүүлэлт 35 хувьд хүрсэн бөгөөд Замын цагдаагийн албаны алба хаагчдыг авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэгээнийн стандарт, норм, дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх үе шаттай сургалтад хамруулснаар зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг тал бүрээс нь шалгаж бодитой тогтоох чадвар эзэмшүүлж дээрх үр дүнд хүрчээ.

АНУ, Канад улсуудад автозамын аюулгүй байдлын үзүүлэлт жилд 2 удаа AASHTO /American Association of State Highway and Transportation Officials/ байгууллага аудит хийж байна. Энэхүү үйл ажиллагааны талаарх тайланг тээврийн яаманд хүлээлгэж өгдөг бөгөөд замын аюулгүй байдлын үзүүлэлт, зам засварлах, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлын гүйцэтгэлээр нь холбогдох төсөв санхүүг олгодог тогтолцоотой байна.

Мөн авто замыг төлөвлөх, төсөллөх, барих, ашиглах, засвар үйлчилгээ хийх бүхий л шатанд хүний нөөц, техник тоног төхөөрөмж, тухайн замд орох материал, үйл ажиллагааны менежментийн аудит хийгдэж байна.

Аудит хийгдэхэд 2100 гаруй стандарт, удирдлагын гарын авлага ашиглаж байна. Зөвхөн автозамын материалд хяналт, аудит хийхэд нэг бүр нь 1000-2000 хуудас бүхий 214 боть гарын авлага хэрэглэж байна.¹⁷² Замын цагдаагийн алба замын хөдөлгөөнийг сахиулах товчоо, төмөр замын хөдөлгөөнийг сахиулах товчоо, ердийн хөсгийн хөдөлгөөнийг сахиулах товчоо, замын хөдөлгөөний ослыг хянан тогтоох товчоо, бодлого боловсруулах товчоо гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Том хотууд ба хороо суурингуудад 16 товчоо ажилладаг. Эдгээр нь орон нутгийн замын хөдөлгөөний асуудлыг эрхэлдэг. Замын хөдөлгөөнийг зохицуулах 10 жилийн хугацаатай ерөнхий төлөвлөгөө гаргаж түүнийхээ хэрэгжилтийг ерөнхий сайд хариуцан ажилладаг байна.

Вьетнам Улс. Тус улсад гарч байгаа зам тээврийн ослыг өндөр хөгжилтэй улс орнуудынхтай харьцуулахад үхэлд хүргэж байгаа осол харьцангуй бага хэмжээтэй байна. Ослыг үхэлд хүргэсэн ба гэмтээж бэртээсэн гэж ангилах бөгөөд үүнийгээ тухайн орны тээврийн хэрэгсэлд ноогдох тоотой харьцуулан авч үздэг байна.

Замын цагдаагийн алба нь Тээврийн газартай хамтран хөдөлгөөний аюулгүй байдлыг судлах, хөдөлгөөнийг шинж чанараар нь ангилах, өдрийн цагаар хүнд даацын болон овор ихтэй ачааны автомашины хөдөлгөөнийг хязгаарлах зэргээр зохицуулалт хийж байгаагаа зөв ажиллагаа гэж үздэг. Улсын хэмжээний 3 их замын 50 км тутамд замын цагдаагийн эргүүлийн 1 машин 24 цагийн туршид эргүүл хийж ажилладаг байна. Харин эргүүлийн цагдаа нь манай улсынхтай адил зөрчил илрүүлэн арга хэмжээ авах үүрэг хүлээдэг.

Хурд хэтрүүлэх, дураараа авирлах мэтийн зөрчил гаргагчдын хөдөлгөөнд оролцох эрхийг 15-30 хоног хасч, мөн торгууль оногдуулдаг байна. Энэхүү арга хэмжээг 2003 оноос хэрэгжүүлж эхлээд 8 сар болоход замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал эрс багасч шийдвэр гаргахад хялбар болсон юм. Зам тээврийн ослыг хөнгөн, хүнд, үхэлд хүргэсэн гэсэн 3 төрлөөр судлан авч үздэг байна.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх явцад хотын замыг өргөтгөн зохион байгуулж, хувийн тээврийн хэрэгслээр хүн тээвэрлэх асуудлыг хязгаарласан нь хөдөлгөөний эмх цэгц, аюулгүй байдлыг хангахад ихээхэн үр дүнтэй болсон гэж үздэг юм байна.

Зам төлөвлөх, төсөллөх, барих, ашиглах, засвар үйлчилгээний шатанд Европын ISO стандарт, үйл ажилагаанд АНУ-ын AASTO стандарт хэрэглэж байна.

Япон улс. Тус улсын 4 хүний нэг нь автомашин жолооддог гэсэн тооцоо байдаг бөгөөд ослын тоо хэмжээг багасгах, замын нөхцөл байдлыг хурдан хугацаанд хэвийн байдалд оруулахын тулд цагдаагийн байгууллага үзлэг, шалгалтдаа хамгийн үр дүнтэй арга барил нэвтрүүлэхийг зорьдог.¹⁷³ Зарим ялимгүй ослын үзлэгийг газар дээр нь хийдэг ажээ.

¹⁷² American Association of State Highway and Transportation Officials 2007

¹⁷³ [3https://ru.wikipedia.org/wiki/japan](https://ru.wikipedia.org/wiki/japan)

Ослын үзлэг хийх, ашиглах тоног төхөөрөмж, үзлэг хийх дараалал, гэмт хэргийн ул мөр бэхжүүлэх зэрэг асуудлыг стандартаар тогтоохоос гадна алба хаагч өөрийн мэдлэг, ур чадвараа нэмэгдэл байдлаар ашиглахыг зөвшөөрдөг байна.

Замын цагдаа гэрлэн дохионы телеметр болон диаграмм зурах төхөөрөмжөөс бүрдсэн хагас автоматчилагдсан үзлэгийн төхөөрөмжийг хэрэглэж, ослыг шинжлэх ухааны үүднээс үр дүнтэй шалгахын тулд автоматаар илрүүлэн бичиж авдаг видео камерыг замын уулзваруудад байрлуулсан байдаг. ЗТО-ыг автоматаар санах төхөөрөмж нь хүлээн авах хэсэг /видео камер микрофонтой/, үндсэн хэсэг, дуу чимээ илрүүлэгч, дүрсний санах байгууламж, YTR г.м-ээс бүрдэнэ. Уулзвар дээр осол гарсан тохиолдолд ТААМ-5 нь мөргөлдөөний юмуу, шарвах дууг илрүүлэн ослыг автоматаар бичиж авдаг байна.

Ингэснээр YTR-т бичигдсэн бичлэгийг үндэслэн цагдаагийн ажилтан ослын байдлыг хурдан хугацаанд тодорхойлох боломж олгодог юм.

Замын хөдөлгөөний хууль, дүрэм зөрчиж хууль бус газар автомашин байрлуулсан үед голдуу хэрэглэдэг арга хэмжээ нь автомашиныг чирэгчээр чирэх, зогсоох төхөөрөмж /дугуй цоожлох гутал/ хэрэглэдэг байна. Хэрэв ажил олгогч ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй бол тээврийн хэрэгсэл ашиглах эрхийг хязгаарлахаас гадна, тээврийн асуудал эрхэлсэн ажилтан, жолооч хоёрт захиргааны арга хэмжээ ногдуулдаг.

Замын хөдөлгөөнийг хянах дэвшилтэт систем, боловсронгуй дохиолол, орчин үеийн техник технологийн ололт зэрэгт тулгуурлан аюулгүй, жигд, саадгүй замын хөдөлгөөний орчныг бүрдүүлнэ гэж үздэг байна.

АНУ. Тус улсын Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба (NHTSA)-наас замын хөдөлгөөнд оролцож байгаа явган зорчигч нарт зориулан аюулгүй байдлын 8 зөвлөмжийг гаргасан байна. Алхах аюулгүй байдлын 8 зөвлөмж:

1. Замын хөдөлгөөний дүрмийг дагаж, тэмдэг, дохиог дагаж мөрдөөрэй.
2. Боломжтой үед явган хүний замаар яв.
3. Явган хүний замгүй бол замын хөдөлгөөнд харан, замын хөдөлгөөнөөс аль болох хол яв.
4. Явган хүний гарц эсвэл уулзвар дээр гудамжаар хөндлөн гарах. Зүүн эсвэл баруун тийш эргэх зэрэг бүх чиглэлд машин хайх.
5. Явган хүний гарц, уулзвар байхгүй бол гэрэлтүүлэг сайтай, замын хөдөлгөөнийг хамгийн сайн харах боломжтой газар байрлуул. /Аюулгүй хөндлөн гарахад хангалттай хугацаа өгөх замын хөдөлгөөний цоорхойг хүлээх; хөндлөн гарахдаа замын хөдөлгөөнийг үргэлжлүүлэн ажиглаарай/
6. Автомашины зам руу орох, гарах эсвэл зогсоол дээр нөөцөлж байгаа машинуудыг ажиглаарай.
7. Явган явахдаа архи, мансууруулах бодис хэрэглэхээс зайлсхийх; тэд таны чадвар, шүүлтийг муутгадаг.
8. Явган явахыг эрүүл тээврийн хэрэгсэл болгон хүлээн зөвшөөр - бос, гарч, хөдөл зэрэг зөвлөмжүүдийг гаргасан байна.

АНУ-ын Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба нь явган зорчигч нарт зориулсан гарын авлага, самбар гаргаж, явган хүний гарц, түүний ойролцоо газруудад байршуулсан нь зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн тус дөхөм үзүүлсэн байна.

Бага сургуулийн хүүхдүүд маш идэвхтэй, хөдөлгөөнтэй байдаг. Хэдийгээр тэд сурч, өсч байгаа ч 10 ба түүнээс доош насны сургуулийн насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний ойролцоо тоглож, алхаж байхдаа заавар, хяналт шаардлагатай хэвээр байдаг байна.

Тиймээс Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын албанаас хүүхдүүдээ сургууль руугаа буцах замдаа аюулгүй байлгах таван зөвлөмж боловсруулж гаргажээ. Энэхүү зөвлөмжийн агуулга нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгээ

бататгах, хүүхдэдээ явган зорчигчийн аюулгүй байдлын дадлыг зааж, бататгах зорилготой гаргасан зөвлөмж юм байна.

Тээврийн болон хөдөлгөөнт байдлын хүртээмжийг үнэлэх хяналтын хуудас¹⁷⁴

Транзит замын хүртээмж, түүний дотор аяллын замыг (Улаан өндөгний баярын тамганаас) үнэлэхийн тулд хяналтын хуудсыг ашиглах танилцуулга ба заавар.

Easter Seals Project ACTION (ESPA) нь АНУ-ын Тээврийн яам, Холбооны Транзит Захиргаатай хамтран ажиллах гэрээгээр санхүүждэг бөгөөд Easter Seals, Inc.-ээс удирддаг. Энэхүү мэдээллийг ESPA мэдээлэл солилцох зорилгоор түгээдэг. Улаан өндөгний баярын тамга болон АНУ-ын DOT, FTA аль аль нь түүний агуулга, ашиглалтын төлөө хариуцлага хүлээдэггүй.

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр

Цэцэрлэгийн 5-р ангиас эхлэн хүүхдүүдэд явган зорчигчийн аюулгүй байдлыг сургах, дэмжих зорилгоор хичээлийн төлөвлөгөө, үнэлгээний гарын авлага, сурагчдын хариу арга хэмжээний талаар тусгасан байна.

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр нь цэцэрлэгийн 5-р ангийн сурагчдад явган зорчигчийн аюулгүй байдлыг сургаж, сургадаг. Хөдөлгөөний ойролцоо алхах, гудамжаар гарах, уулзвар гарцаар гарах, зогсоолын аюулгүй байдал, сургуулийн автобусны аюулгүй байдал гэсэн таван хичээлээр зохион байгуулдаг. Хичээл бүр өмнөх олж авсан ур чадвар дээр тулгуурладаг.¹⁷⁵

Дүгнэлт. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Замын цагдаагийн газар, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж, явуулж буй ажил, арга хэмжээнүүд бидний хүссэн үр дүнд төдийлөн хүрэхгүй байгаа нь статистик тоо мэдээнээс харагдлаа. Тиймээс бид гадаадын зарим оронд нэвтрүүлж тодорхой үр дүнд хүрсэн аргуудыг өөрийн орны хөрсөнд буулгах замаар нэвтрүүлж, үр дүнг тооцох ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатай байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. АНУ-д нэвтрүүлсэн “Алхах аюулгүй байдлын 8 зөвлөмж”-ийг манай нийтийн тээврийн автобусны буудлын самбар, автобусны дотор хананд, ерөнхий боловсролын сургуулийн гадна самбар, дэлгүүрийн гадна хэсэг гэх мэт хүн олноор цуглардаг газруудын ил харагдах хэсгүүдэд иргэдийн сэтгэлд хоногшуултал нь байрлуулах;

2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр”-ийг оруулж тусгуулах;

3. Вьетнам улсын хэмжээнд их замын 50 км тутамд замын цагдаагийн эргүүлийн 1 машин 24 цагийн туршид эргүүл хийж ажиллуулдаг туршлагыг судалж үзэх;

4. Вьетнам улсын хууль тогтоомжид хурд хэтрүүлэх, дураараа авирлах мэтийн зөрчил гаргагчдын хөдөлгөөнд оролцох эрхийг 15-30 хоног хасч, мөн торгууль оногдуулдаг эрх зүйн туршлагыг нэвтрүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

¹⁷⁴

https://nationalcenterformobilitymanagement.org/wpcontent/uploads/2013/11/Checklist_Assessing_Accessibility.pdf

¹⁷⁵ <https://www.nhtsa.gov/pedestrian-safety/child-pedestrian-safety-curriculum>

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
2. Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ. 2022.
3. Global Status Report on Safety 2013.Supporting a decade of action.Who, 2013
4. American Association of State Highway and Transportation Officials 2007
5. <https://ru.wikipedia.org>
6. <http://www.who.int>.
7. <https://nationalcenterformobilitymanagement.org>
8. <https://www.nhtsa.gov>